



**ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ХҮРЭЭЛЭН
ГАМШИГ СУДЛАЛЫН ТӨВ**

**ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛАЛД ХИЙСЭН
ШИНЖИЛГЭЭ /2018-2022 ОН/**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ
2023 ОН**

**ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛАЛД ХИЙСЭН
ШИНЖИЛГЭЭ /2018-2022 ОН /**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны захиалагч:

Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн
Гамшиг судлалын төв

**Судалгааны багийн
гишүүд:**

Б.Саранцэцэг

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм
шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гамшиг
судлалын төвийн эрхлэгч, гамшиг судлалын
доктор (Ph.D), дэд хурандаа

Б.Ганзагас

Гамшиг судлалын төвийн эрдэм
шинжилгээний ажилтан, ахлах дэслэгч

С.Анхбаяр

Гамшиг судлалын магистрант

Агуулга

Өмнөх үг	3-4
Зургийн жагсаалт	5
Хүснэгтийн жагсаалт	6-7
Товчилсон үгийн жагсаалт	8
Нэр томъёоны тайлбар	9-10
Удиртгал	11-13
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА	
1.1. Хүүхэд хамгаалал, гамшгийн үеийн хүүхэд хамгаалал, эрх зүйн зохицуулалт	14-45
1.2. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх олон улсын туршлага	46-56
Нэгдүгээр бүлгийн дүгнэлт	57-59
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ (ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖИШЭЭН ДЭЭР)	
2.1. Гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд хийсэн шинжилгээ	60-73
2.2. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллыг сайжруулах арга зам	74-91
Хоёрдугаар бүлгийн дүгнэлт	92-94
Дүгнэлт	95-99
Санал	100
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	101-102
ХАВСРАЛТ	103-120

Өмнөх үг

Өнгөрсөн хугацаанд тохиолдсон гамшгийн болон COVID-19 цар тахлын үед хүүхдэд яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын асуудал нь тулгамдсан асуудлын нэг байсан.

Хүүхэд хамгааллын байгууллагуудад гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд таны хүүхэд болон ажилчдынхаа хэрэгцээг хэрхэн хамгаалах, хангах талаарх тусгасан зүйл, заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна.

Иймээс гамшиг, байгалийн аюулт үзэгдлийн үед учирч болзошгүй аюулын хүчин зүйлээс шалтгаалан хүүхэд, эцэг эхчүүд эрсдэлд орох магадлал өндөр байсаар байна.

“Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ”, Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр-2030, Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Парисын хэлэлцээр, Сендайн үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх Азийн бүсийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдтэй уялдуулан Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулан гаргаж, хэрэгжүүлэх эхний алхам хийж буй үед гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудалд шинжилгээ хийсэн нь бүтээлийн ач холбогдлыг улам өргөж байна.

Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудлыг Гамшгаас хамгаалах тухай хууль болон гамшгийн үеийн үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу зохион байгуулсаар ирсэн байна. Тухайлбал, Гамшгийн үеийн хүүхэд хамгааллыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн С/66 дугаар тушаалаар батлагдсан “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021 стандарт юм. Энэхүү стандартыг гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхэд төрийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, хүмүүнлэгийн болон хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийтийн хамтын ажиллагааны уялдаа холбоог ханган ажиллах, стандартыг хялбаршуулсан хэлбэрээр сурталчлах, сургалт зохион байгуулах үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэн ажиллахтай холбогдуулан энэхүү судалгааны тайлан гарсан нь шинэлэг талыг илэрхийлнэ.

Энэхүү судалгааны ажлын тайлан нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулдаг, хэрэгжүүлдэг төрийн болон төрийн бус байгууллагууд, Улсын албад, мэргэжлийн анги, байгууллагын албан хаагч

болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургууль, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын судлаач, багш, оюутан, суралцагчдад бага боловч хувь нэмэр болно хэмээн найдаж байна.

Зургийн жагсаалт

- Зураг 1 НҮБ-ын Хүүхдийн сангийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөний хүрэх үр дүн
- Зураг 2. 2022–2025 оны стратеги төлөвлөгөө: 2030 он руу чиглэсэн шинэчлэл
- Зураг 3 Сүүлийн 5 жилийн харьцуулалт
- Зураг 4. Усны осолд өртөж нас барсан хүүхдийн тоо
- Зураг 5 Усны ослоос аварсан хүүхдийн тоо
- Зураг 6. Гамшиг осолд өртөж нас барсан хүүхдийн шалтгаан
- Зураг 7. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг эрх зүйн зохицуулалттай харьцуулбал
- Зураг 8. Гамшгийн аюулын эх үүсвэр, эрсдэл үзүүлэх нөлөөлөл
- Зураг 9. НҮБ-ын Хүүхдийн сангийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөний хүрэх үр дүн

Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 1. Монгол Улсын нэгдэн орсон хүүхэд хамгаалалтай холбоотой олон улсын гэрээ конвенц дахь гамшгийн үеийн хүүхэд хамгааллын зарим зохицуулалт
- Хүснэгт 2. Монгол Улсын нэгдэн орсон хүүхэд хамгаалалтай холбоотой олон улсын гэрээ конвенц дахь гамшгийн үеийн хүүхэд хамгааллын эрх зүйн зохицуулалт
- Хүснэгт 3. Монгол Улсын хэмжээнд объектын гал түймрийн тохиолдлын тоо /Сүүлийн 5 жилээр/
- Хүснэгт 4. Монгол Улсын 2018-2022 онд усны осолд өртсөн хүүхдийн судалгаа /Сүүлийн 5 жилээр/
- Хүснэгт 5. Хүснэгт 5. Хөвсгөл аймагт сүүлийн 5 жилд тохиолдсон аюулт үзэгдэл, гамшиг ослын бүртгэгдсэн байдал
- Хүснэгт 6. Судалгаанд оролцогчдын хүйсийн ангилал
- Хүснэгт 7. Судалгаанд оролцогчдын насны ангилал
- Хүснэгт 8. Судалгаанд оролцогчдын гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаар таны ойлголт хангалттай байдаг уу
- Хүснэгт 9. Судалгаанд оролцогчдын гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээллийг хүүхдэд хэрхэн өгч байна вэ
- Хүснэгт 10. Судалгаанд оролцогчдын гамшгийн үеийн хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдсэн гэдэгт итгэж байна уу
- Хүснэгт 11. Судалгаанд оролцогчдын хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн зохицуулалт хангалттай гэж бодож байна уу
- Хүснэгт 12. Судалгаанд оролцогчдын хүүхдийг гамшгаас хамгаалах талаар сургалт, мэдлэг, мэдээлэл хангалттай авдаг уу
- Хүснэгт 13. Судалгаанд оролцогчдын гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө хамгаалах талаар сургалт ордог уу
- Хүснэгт 14. Судалгаанд оролцогчдын гамшиг болоход хүүхэд өөрийгөө аврах чадвар эзэмшсэн гэж бодож байна уу
- Хүснэгт 15. Судалгаанд оролцогчдын гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэгийг хүүхдэд хэрхэн хүргэвэл үр дүнтэй вэ
- Хүснэгт 16. Гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө аврах ур чадварыг хэн эзэмшүүлэх вэ
- Хүснэгт 17. Гамшигт өртсөн хүүхдийн хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломж байна уу
- Хүснэгт 18. Гамшгийн үед хүүхдэд үүсэж болох эмзэг байдлуудын талаар дурдана уу
- Хүснэгт 19. Та гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар хүүхдэд мэдээлэл, зөвлөгөө өгдөг үү

- Хүснэгт 20. Гамшгийн үед хүүхэд хамгааллын талаар мэдээлэл, зөвлөгөө авдаг уу
- Хүснэгт 21. Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021 стандартын харьцуулалт
- Хүснэгт 22. Хүүхдэд үүсэж болох эмзэг байдал
- Хүснэгт 23. Эрсдэлийг даван туулах чадварын үнэлгээ
- Хүснэгт 24. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын оролцоо

Товчилсон үгийн жагсаалт

НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ХӨСҮТ	Хавдар өвчин судлалын үндэсний төв
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
УОК	Улсын онцгой комисс
УИХ	Улсын их хурал
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар
ОУБ	Олон улсын байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага

Нэр томъёоны тайлбар

“Гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг;

“Гамшгийн үе” гэж хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор бүх хүн, хүч, техник хэрэгслийг ашиглан янз бүрийн арга хэрэгслийг ашиглан гүйцэтгэх зорилго, зорилт, газар, цаг хугацаа, арга замууд хоорондын харилцан ойлголцол зөвшилцөн тохиролцдог үйл ажиллагааг хэлнэ;

“Гамшгийн онцгой нөхцөл байдал” гэж аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг хэлнэ;

“Дарамт” гэж давуу тал, эрх мэдлээ урвуулан ашиглаж хүүхдийн нэр төр, эрхэм чанар, аюулгүй байдал, хөгжил, сайн сайхан байдалд хор хохирол учруулах зүйлийг санаатайгаар үйлдэхийг хэлнэ;

“Мөлжлөг” гэж хүүхдийн эмзэг байдлыг ашиглан тэднийг хүнд хөдөлмөр эрхлүүлэх, наймаалах, садар самуун болон бусад эрсдэлт үйл ажиллагаанд уруу татан ашиг хонжоо олох үйлдлийг хэлнэ;

“Нийгмийн бүхий л орчин” гэж гэр бүл, боловсрол, асрамж, халамж, хорих, засан хүмүүжүүлэх байгууллагууд, ажлын байр, малын бэлчээр, гудамж талбай, олон нийтийн газар, цахим орчин, хэвлэл мэдээлэл зэрэг хүүхдийг хүрээлэн буй орчин юм. Мөн хүүхдийг нийгмийн бүхий л орчинд эрүүл, аюулгүй байлгах, тухайн хүүхдийн нас, онцлогт тохируулан эцэг эх, асран хамгаалагч, хүүхдийн сэтгэл зүйч, багш, нийгэмд үлгэр дуурайлал болсон нөлөө бүхий хүмүүс, хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэшсэн алба хаагчдаар мэдлэг олгох, гамшгийн үед хүүхэд өөрийгөө хамгаалах мөн аюулгүй орчныг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр нь бүрдүүлж хангуулахад оршино;

“Урьдчилан сэргийлэх” гэж аливаа үйл явдал, нөхцөл байдлыг бий болгохгүй байхын тулд урьдчилан авч байгаа арга хэмжээг хэлнэ;

“Хамгаалал” гэж нас, хүйс, жендер, үндэс угсаа, тусгай хэрэгцээт буюу хөгжлийн бэрхшээлтэй, нийгмийн болон улс төрийн харьяалал, шашин шүтлэг болон бусад байдлаас үл хамааран бүх хүмүүсийн эрхийг бүрэн дүүрэн, ижил тэгш хангахад чиглэсэн бүхий л үйл ажиллагааг хэлнэ;

“Хариу арга хэмжээ” гэж гамшиг, онцгой байдлын үед буюу түүний дараа мэн даруй хүний амь насыг аврах, эрүүл мэндэд учрах хор хөнөөлийг бууруулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хүний нэр төрийг хамгаалах, гамшигт нэрвэгдсэн хүмүүсийн амьжиргааны наад захын хэрэгцээг хангах зорилгоор үйлчилгээ, тусламж үзүүлэхийг хэлнэ;

“Хүүхэд” гэж НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод 18 нас хүрээгүй хүн бүрийг тодорхойлсон;

“Хүчирхийлэл” гэж хүүхдийн аюулгүй нөхцөл байдал, сайн сайхан байх, нэр төр, сурч боловсрох хөгжихөд бодит болон болзошгүй сөрөг нөлөө үзүүлэх санаатай үйлдлийг хэлнэ;

“Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ” гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагааг хэлнэ;

“Хүүхэдтэй зүй бусаар харьцах явдал” гэж хүүхдийн төрөлхийн болон хуулиар тогтоосон эрхээ эдлэх хэрэгцээг хязгаарлаж, өөрийгөө болон бусдыг хүндэтгэдэг бие хүн болж төлөвших, хөгжихөд нь саад болсон сэтгэл зүйгээр, биеийн хүчээр, бэлгийн харилцаагаар, үг хэлээр, үл хайхарч шоовдорлох замаар сэтгэл санаа, бие махбодод хор нөлөө, гэмтэл учруулж болохуйц, эсвэл учруулсан аливаа үйлдлийг хэлнэ;

“Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг хэлнэ;

УДИРТГАЛ

Судалгааны ажлын үндэслэл: Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудлаар сүүлийн үед нэлээн өргөн хүрээнд олон улсад судлагдах болсон. Бид бүхэн тайван амгалан цагт ч өөрсдийн гэрэлт ирээдүй гэж ярих дуртай хүүхдийн талаар хангалттай мэдлэгтэй байж, тэдний аюулгүй амьдрах орчныг бүрэн бүрдүүлж чадаж байна уу гэдэг асуудал эргэлзээтэй хэвээр байна. Энэ нь гамшгийн үед хамгийн их хохирол амсдаг нийгмийн бүлэг нь хүүхдүүд байдаг. Иймээс бид гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд шинжилгээ хийж, хүүхэд хамгааллын асуудлыг сайжруулах шаардлага урган гарсаар байна.

Дэлхий дахинд түгээмэл тохиолддог байгалийн 30 гаруй аюулт үзэгдлээс манай оронд , зуд, цасан болон шуурга, хуй салхи, цөлжилт, аянга, аадар бороо, үер, усны осол, зэрэг байгалийн гаралтай 10 гаруй аюулт үзэгдэл, ой хээрийн түймэр, гол нуурын мөсний цөмрөлт, уурхайн дэлбэрэлт, үер, усны осол, химийн хорт бодисын хордолт, объектын гал түймэр болон авто тээврийн хэрэгслийн томоохон осол зэрэг хүний буруутай үйл ажиллагаа, техникийн холбогдолтой осол гарч, хүний амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин сүйрч, нийгэм эдийн засагт ихээхэн хохирол учирч байна. Тухайлбал, олон улсын судлаач нар 5-аас доош насны 48 сая хүүхэд 2020-2030 оны хооронд урьдчилан сэргийлэх боломжтой шалтгаанаар нас барна гэж таамаглал дэвшүүлсэн бол ойролцоогоор 1,2 тэрбум хүүхэд гамшгийн эрсдэл, эмзэг байдал үүссэн орнуудад амьдарч, 500 сая орчим хүүхэд үер усны эрсдэл ихтэй буюу маш өндөр эрсдэлтэй бүс нутагт, 160 сая хүүхэд ган гачигт нэрвэгдэх эрсдэлтэй буюу өндөр эрсдэлтэй бүс нутагт амьдарч байна гэсэн судалгаа байна.¹

Иймээс олон улсад хүүхэд хамгааллын асуудалд анхаарлаа хандуулж байгаа өнөө үед бидний хүүхдүүд болзошгүй гамшгийн үеийн хүүхэд хамгаалал ямар байгаа талаар судалж, Хөвсгөл аймгийн хэмжээн дэх гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд шинжилгээ хийж, сайжруулах арга замыг тодорхойлох зорилгоор энэхүү сэдвийг сонгов.

Судалгааны зорилго: Хүүхэд хамгаалал, гамшгийн үеийн хүүхэд хамгаалал, эрх зүйн зохицуулалт, олон улсын туршлага дээр тулгуурлан Хөвсгөл аймгийн хэмжээн дэх гамшгийн үеийн хүүхэд хамгааллын

¹ www.unicef.org/state-worlds-children-2022

өнөөгийн байдалд шинжилгээ хийж, түүнийг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход оршино.

Судалгааны зорилт: Судалгааны ажлын зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүллээ.

- 1 Хүүхэд хамгаалал, гамшгийн үеийн хүүхэд хамгаалал, эрх зүйн зохицуулалтыг судлах;
- 2 Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх олон улсын туршлагыг судлах;
- 3 Хөвсгөл аймгийн жишээн дээр гамшгийн үеийн хүүхэд хамгааллын өнөөгийн байдалд шинжилгээ хийх;
- 4 Хөвсгөл аймгийн жишээн дээр гамшгийн үеийн хүүхэд хамгааллыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлох;

Судалгааны объект: Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал

Судлах зүйл: Гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд хийсэн шинжилгээ

Судалгааны арга: Сэдвийн судалгаанд түүхчлэх, харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг үндсэн аргын зэрэгцээ социологийн болон статистикийн мэдээлэл, SPSS программыг ашигласан.

Энэ судалгаандаа монголын болон гадаадын эрдэмтэд, судлаачдын бүтээлийг онолын эх сурвалж болгон олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын баримт мэдээ судалгааг хийх зэргээр шинжлэх ухааны судалгааны анализ, синтезийн аргыг хэрэглэсэн болно.

Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол: Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын өнөөгийн байдалд шинжилгээ хийж, түүнийг сайжруулах арга замыг тодорхойлж, цаашид гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгааллыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх санал дэвшүүлэн тавьсан нь шинэлэг тал боллоо. Мөн гамшгийн үеийн хүүхэд хамгааллын эрх зүйн байдлыг судалж, гамшигт нөхцөл байдлын үед хүүхдэд үүсэх нөлөөлөл, эмзэг байдлыг тодорхойлон гаргаж ирэхийг оролдсон нь практик ач холбогдолтой.

Судалгааны статистик боловсруулалт. SPSS-26 программыг ашиглан статистик боловсруулалт хийж, судалгааны үр дүнг тооцохдоо дундаж, медиан, стандарт хазайлт, хамгийн их болон хамгийн бага утга, тохирох болон найдварт чанар, хамаарлын статистик шинжилгээ хийсэн.

Судалгааны хязгаарлалт: Хөвсгөл аймгийн жишээн дээр

Судалгааны эх сурвалж: Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаар туурвисан гадаад, дотоодын эрдэмтдийн бүтээл, түүхэн эх сурвалж, хууль тогтоомж, ном, сурах бичиг, гарын авлага, судалгааны тайлан, статистик зэрэг нь судалгааны ажлын эх сурвалж болно.

Судалгааны бүтэц: Энэхүү судалгааны ажил нь удиртгал, хоёр бүлэг, дөрвөн зүйл, бүлгийн дүгнэлт, ерөнхий дүгнэлт, эх сурвалж, хавсралтаас бүрдэнэ.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД ХАМГААЛАЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

§1.1. Хүүхэд хамгаалал, гамшгийн үеийн хүүхэд хамгаалал, эрх зүйн зохицуулалт

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцод “18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” гэж тодорхойлсон. Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулиар “Монгол Улсын иргэн төрсөн цагаас эхлэн 18 нас хүртэл, эсхүл Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд 18 наснаас дээш 21 хүртэл насны хүнд энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг үзүүлж болно.” гэж заасан.

“Хамгаалал” гэж нас, хүйс, жендер, үндэс угсаа, тусгай хэрэгцээт буюу хөгжлийн бэрхшээлтэй, нийгмийн болон улс төрийн харьяалал, шашин шүтлэг болон бусад байдлаас үл хамааран бүх хүмүүсийн эрхийг бүрэн дүүрэн, ижил тэгш хангахад чиглэсэн бүхий л үйл ажиллагааг хэлнэ.¹

А.Батхишиг, О.Мягмар нарын бүтээлд “Хүүхэд хамгаалал нь нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаа юм.”² гэж дурдсан байна. Н.Мөнхчулуун “Хүүхэд хамгаалал гэдэг нь хүүхдийг хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах явдлын улмаас учрах хор хөнөөлөөс нийгмийн бүхий л орчинд хамгаалах явдал юм³” гэжээ. НҮБ-ын хүүхдийн сангийн судалгааны бүтээлд “Хүүхэд хамгаалал гэж хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үл хайхрах байдал, мөлжлөг гарахаас урьдчилан сэргийлэх, хариу үйлдэлд үзүүлэхэд чиглэсэн санаачилга, үйл ажиллагаа юм”⁴ хэмээн тодорхойлсон байна.

Дээрх эрдэмтэн, судлаачийн тодорхойлолтыг дүгнэн үзээд хүүхэд хамгаалал гэдэг нь нийгмийн бүхий л орчинд хүүхэд бүрийг үл хайхрах

¹ www.Legalinfo.mn Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021 стандарт

² Батхишиг.А, Мягмар.О, Нямдорж. М “Хүүхэд хамгааллын үйлчилгээ” -Уб.,2009.

³ Мөнхчулуун.Н, ““Хүүхэд хамгааллын талаарх эцэг эхчүүдийн ойлголт хандлага, түүнийг дээшлүүлэх нь “судалгааны ажил -Уб., 2015,

⁴ Save the children’s definition of Child protection, 2007, UNICEF, Internationally Recognized Child

байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаа төдийгүй мэдлэг, хандлагын цогц гэж тодорхойлж байна.

Хууль тогтоомжийн хүрээнд болон уламжлалын дагуу хүүхдийн сайн сайхны төлөө тодорхой хариуцлага хүлээсэн хувь хүн, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага нь хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдал, нэр төр, хөгжилд бодит болон болзошгүй хор хөнөөл учруулахаас сэргийлэх, хамгаалах, хүүхдийн эсэн мэнд, эрүүл байх, хөгжих, суралцах сайн сайхан амьдрах эрхийг хангах явцдаа хүлээсэн үүргээ санаатай болон санамсаргүйгээр биелүүлээгүй байдлыг хэлнэ.¹

Хүүхдийг үл хайхрах явдал нь хүүхэдтэй зүй бус харьцах явдлын бусад хэлбэртэй адил хүүхдийн хэвийн хөгжил, эрүүл мэнд, оюун ухаан ба танин мэдэхүйн хөгжилд хор нөлөөг үзүүлнэ.

АНУ-ын Холбооны Засгийн газрын Хүүхдийг хүчирхийлэл, дарамтаас хамгаалах ба эмчлэх тухай хуульд “Хүүхдийг асран хамгаалах үүрэг хүлээсэн эцэг эх, асран хамгаалагч, хүмүүжүүлэгчийн зүгээс хүүхдэд сэтгэл санааны дарамт, бие махбодын болон бэлгийн дарамт, хүчирхийлэл үзүүлэх, улмаар хүүхдийг мөлжих байдлаар хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, аюулгүй байдалд хор хөнөөл, аюул занал учруулсан буюу учруулах эрсдэлтэй бүхий л үйлдлийг хүүхэдтэй зүй бус харьцах явдал гэнэ.”² гэж тодорхойлсон.

Хүүхэдтэй зүй бусаар харьцах явдал гэдэг нь хүүхдийн төрөлхийн болон хуулиар тогтоосон эрхээ эдлэх хэрэгцээг хязгаарлаж, өөрийгөө болон бусдыг хүндэтгэдэг бие хүн болж төлөвших, хөгжихөд нь саад болсон сэтгэл зүйгээр, биеийн хүчээр, бэлгийн харилцаагаар, үг хэлээр, үл хайхарч шоовдорлох замаар сэтгэл санаа, бие махбодод хор нөлөө, гэмтэл учруулж болохуйц, эсвэл учруулсан аливаа үйлдлийг хэлнэ.³ гэж томъёолон байдаг ба эцэг эх, асран хамгаалагч, нийгмийн үйлчилгээний байгууллагын зүгээс үйлдсэн болон хийх ёстой үүргээ биелүүлээгүй, эс үйлдлүүдийг бүгдийг хамруулж ойлгохоор тусгасан.

¹ www.Legalinfo.mn Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021 стандарт

² Scannapieco and Connel-Carrick, ‘Understanding child maltreatment’ 2005.

³ Энхтуяа. С., “Хүүхэд хамгааллын үндэс” -Уб., 2009.

Анхан шатны урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь хүүхдийн дарамт шахалт, үл хайхрах байдал, мөлжлөг, хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлыг бууруулах зорилгоор хүн амын дундах хүүхэд хамгааллын эрсдэлийн үндсэн шалтгааныг шийдвэрлэх, хоёрдогч урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь гамшиг, онцгой байдлын үед хүүхдийг аюул, ослоос авран хамгаалах, гэр бүлээсээ хагацсан, салсан хүүхдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, гуравдагч урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь хүүхэд, гэр бүл болон хүрээлэн буй орчны тодорхой хүчин зүйлийн улмаас дарамт шахалт, үл хайхрах байдал, мөлжлөг, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртөх онцгой эрсдэлтэй хүүхдийн эмзэг байдал болон аюул заналхийллийн шалтгаан, үүсвэрт анхаарлаа хандуулах, дөрөвдөгч урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь дарамт шахалт, үл хайхрах байдал, мөлжлөг, хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хүүхдэд тусах урт хугацааны хор хөнөөлийг бууруулах, дахин хор хөнөөл учруулах нөхцөлийг бууруулах; юм.¹

“Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг хэлнэ.

“Гамшгийн онцгой нөхцөл байдал” гэж аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг хэлнэ.²

Дээрх ойлголтуудыг авч үзэхэд хүүхэд хамгаалал хэмээх ойлголт нь хүүхдийн талаарх асуудлыг цогцоор нь тусгасан өргөн ойлголт болох нь харагдаж байна.

Гэхдээ судалгааны ажилдаа “Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” буюу гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийн талаарх асуудлыг цаашид судлах болно.

Гамшгийн онцгой нөхцөл байдал гэх ойлголтод багтах аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн

¹ Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021 стандарт

² www.Legalinfo.mn Гамшгаас хамгаалах тухай хууль. -Уб., 2017.

байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдсан үеийн хүүхэд хамгааллын асуудлыг Гамшгаас хамгаалах тухай хууль болон гамшгийн үеийн үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, заавар, стандартын дагуу зохион байгуулсаар ирсэн байна. Тухайлбал, Гамшгийн үеийн хүүхэд хамгааллыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн С/66 дугаар тушаалаар батлагдсан “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021 стандарт юм.

Энэхүү стандартыг гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхэд төрийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, хүмүүнлэгийн болон хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийтийн хамтын ажиллагааны уялдаа холбоог ханган ажиллах, стандартыг хялбаршуулсан хэлбэрээр сурталчлах, сургалт зохион байгуулах үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Стандартын зорилго нь гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн язгуур эрх ашгийг нэн тэргүүнд тавих, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, эрсдэлд өртсөн хүүхдийн эсэн мэнд, аюулгүй амьдрах, хөгжих, оролцох эрхийг нь тэнцвэртэй хангах, хүүхэд хамгааллын үйлчилгээг гамшгийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний хүрээнд хор хохирол, эрсдэл учруулахгүйгээр үзүүлэх чиглэлээр оролцогч талуудын хүлээх чиг үүрэг, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, зарчим, хамтын ажиллагааны зохицуулалтад тавих босго шаардлагыг тогтооно.¹

Гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд дараах ерөнхий зарчмуудыг баримтлан ажилладаг. Үүнд:

1. Эсэн мэнд амьдрахуй ба хөгжил
2. Үл ялгаварлал ба тэгш хамруулалд
3. Хүүхдийн оролцоо
4. Хүүхдийн дээд ашиг, сонирхол
5. Хүүхдийн аюулгүй байдал, нэр төр, эрхийг хамгаалж, нэмж хохирол учруулахгүй байх

¹ Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021 стандарт

6. Хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн тусламжийг ялгаварлан гадуурхалтаас ангид, шударгаар үзүүлэх
7. Бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэл, сүрдүүлэг, албадлага болон санаатайгаар бий болгосон хомсдолыг даван туулахад нь туслах
8. Хүүхдэд эрх ашгаа хамгаалалд нь туслах
9. Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх
10. Хүмүүнлэгийн үйл ажиллагааны үед хүүхдийн даван туулах чадварыг бэхжүүлэх

Олон улсын болон үндэсний хэмжээнд дээрх ерөнхий зарчмуудыг гамшгийн үеийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажилладаг.

Хүүхдэд тулгарч буй аюул, ослыг олон талаас нь шалтгаан нөхцөл, шийдлийг хамт авч үзэхийн тул хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулах арга хэмжээг дараах аргачлалыг ашиглана.

- Аюулыг тодорхойлох, суурь шалтгааныг илрүүлэх
- Хариу арга хэмжээг тухайн нөхцөл байдалд тохируулах
- Орон нутгийн иргэдийн оролцоо, санаачилгыг дэмжих
- Салбар дундын хамтын ажиллагааг хангах
- Урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг зэрэг хэрэгжүүлэх
- Холбогдох бүх талуудтай хамтран ажиллах

Гамшгийн үед дараах үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллана.
Үүнд:

- Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал-хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл
- Хүүхэд хамгаалал-боловсрол
- Хүүхэд хамгаалал-эрүүл мэнд
- Хүүхэд хамгаалал-орон гэр

Дээрх үйл ажиллагааг дэлгэрүүлэн авч үзлээ. Үүнд:

Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал-хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл:

Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги нь хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл ба хүүхэд хамгааллын уялдаа зохицуулалтыг хангасан тогтолцоотой, нэгдсэн аргачлалтай, хөтөлбөртэй байж, хүмүүнлэгийн хямралд өртсөн бүх хүүхдийн хүнсний аюулгүй байдлыг хангаж хоол

тэжээлийн хомсдолоос сэргийлэн хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулж, үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллана.

Гамшгийн үед хүнсний аюулгүй байдлын дөрвөн зарчим болох хоол хүнс (i) хангалттай, (ii) хүртээмжтэй, (iii) тогтвортой (iv) тэжээллэг хоол хүнсээр хэрэглээг хангаж, хүүхдийн аюулгүй байдал, сайн сайхан байдлыг дэмжинэ.

Хүүхэд хамгаалал ба хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл хариуцсан оролцогч талууд нь хүүхдийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл ба хүүхэд хамгааллын суурь судалгааг дараах зорилгоор хийнэ. Үүнд:

- Өрхийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн хангамж ба хүүхэд хамгааллын эрсдэлийг хамтран хянаж үнэлэх;
- Хүүхэд хамгааллын асуудал нь хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн хүртээмжид эергээр эсвэл сөргөөр нөлөөлж буй эсэхийг тодруулах;
- Бүх хяналт үнэлгээнд хүүхдийг оролцуулж, тэдний санал бодлыг тусгах;
- Мэдээллийг жендер, нас, хөгжлийн бэрхшээл зэрэг ялгаатай байдлыг харгалзан ангилах;
- Хяналт үнэлгээ, дүн шинжилгээний мэдээллийг хуваалцах үр дүнтэй аргыг тодорхойлох;
- Хүүхэд, иргэд олон нийттэй ярилцах замаар хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл ба хүүхэд хамгааллын нийтлэг тулгамдсан асуудлыг тодорхойлох;
- Эрсдэлтэй хүүхэд, өрхөд тусламжийг нэн тэргүүнд үзүүлэх нийтлэг шалгуурыг тодорхойлох;
- Хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл ба хүүхэд хамгааллын эрсдэлтэй өрхөд хүрч ажиллах хариу арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх.

Хүнсний аюулгүй байдлын ажилтан хүүхэд хамгааллын ажилтантай хамтран эрсдэлтэй хүүхдийг илрүүлж, тусламж үзүүлэх шалгуурыг боловсруулж, эмзэг бүлгийн хүн амд нийцтэй үйлчилгээг үзүүлж ажиллана.

Хүнсний аюулгүй байдлын болон хоол тэжээлийн бүх ажилтан хүүхэд хамгааллын, ёс зүйн болон бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс

урьдчилан сэргийлэх, бэлгийн хүчирхийллийн талаар мэдээлэх зэрэг холбогдох бодлого журамтай танилцаж сургалтад хамрагдана.

Хүүхэд хамгааллын ажилтан дараах чиглэлээр ойлголт, мэдлэгээ дээшлүүлнэ. Үүнд:

- Нялхас, бага насны хүүхдийн хооллолт, хоол тэжээлийн хөтөлбөрийн зорилго, үйл ажиллагааг хэрхэн танилцуулах;
- Хүүхэд, эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн нөхцөл байдлыг хэмжих үнэлэх;
- Хоол тэжээлийн үйлчилгээнд тэгш хамрагдах боломжгүй хүүхдийг илрүүлэх арга зам;
- Хоол тэжээлийн дуталтай хүүхэд, жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдийг илрүүлэх, холбон зуучлах арга зам.

Хүүхдэд ээлтэй, салбар дундын холбон зуучлах механизмыг бүрдүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах, хоол тэжээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааны явцад илэрсэн хүүхэд хамгаалал, хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн хомсдолын талаарх зөрчлийг илрүүлж, хүүхэд хамгааллын кейс/зөрчлийн мөрөөр арга хэмжээ авна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах, хоол тэжээлийн хомсдолыг арилгах үйл ажиллагаа нь хүүхдэд аюулгүй, хүртээмжтэй, тэгш хамруулсан, тэднийг хамгаалсан, жендер, нас, хөгжлийн бэрхшээл, хөгжлийн онцлог, хоол тэжээлийн хэрэгцээ, гэр бүлийн нөхцөл байдлын хувьд ялгаатай хүүхдийн хэрэгцээг хангахуйц байна.

Хоол тэжээлийн үйлчилгээ үзүүлж буй цэгт хүүхэд хамгааллын ажилтан дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Эрсдэлтэй өрх болон тусламж хүлээн авагчдыг тодорхойлох;
- Хоол хүнс, барааг түгээх;
- Хүүхэд нь нас барсан гэр бүлд туслах;
- Хүүхэд хамгааллын эрсдэлтэй байж болзошгүй кейстэй ажиллах;
- Хоол тэжээлийн үйлчилгээ авахад хүндрэлтэй гэр бүлд дэмжлэг үзүүлэх;

Хүн амыг дараах бүлгийг хамгийн ойр эрүүл мэндийн төв, хоол тэжээлийн төв/багтай холбоно. Үүнд:

- Хоол тэжээлийн дутагдалд орох эрсдэлтэй өрх, хүүхэд;

- Хөхүүл эх, өсвөр насны болон хөхний сүүний гарц нь хангалтгүй ээж;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөхөө хөхөх эсвэл залгих бэрхшээлтэй хүүхэд;
- Ээжгүй хүүхдийг хооллох хөхүүл эх/асрагч олох, хөхний сүүг орлуулах хэрэгцээг илрүүлж тогтооно.

Гамшигт нэрвэгдсэн хүүхэд болон бусад оролцогч талуудтай хамтран хүүхэд хамгааллын асуудлаар хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй, нууцлалыг хадгалсан санал авах, мэдээлэх механизмыг боловсруулан, хэрэгжилтийг хянаж үнэлнэ.

Хүнс, амь насыг аврах яаралтай тусламжийг нэрвэгдсэн гэр бүл, хүүхдэд түгээх ажилд хүүхэд хамгааллын мэргэжлийн анги оролцоно. Түгээлтийг дараах зарчмаар хийнэ. Үүнд:

- Хугацаа алдахгүй байх;
- Гамшигт нэрвэгдсэн иргэд, олон нийттэй зөвшилцөх;
- Сайтар төлөвлөсөн байх;
- Хүртээмжтэй байх;
- Аюулгүй байх.

Хүүхэд хамгааллын ажилтан бүртгэл, түгээлт хариуцсан ажилтанд дараах мэдээллийг өгнө. Үүнд:

- Хүүхэд өртөж хохирч болзошгүй эрсдэл;
- Эмзэг бүлгийн хүүхдийг илрүүлэх шалгуур;
- Эрсдэлтэй бүлгийн хүүхэд (тухайлбал өрх толгойлсон хүүхэд, асран хамгаалагч нь өндөр настай эсвэл өвчтэй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд)-тэй ажиллах үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ тухай мэдээлэл.

Олныг хамарсан бүртгэл, түгээлтийн үед хамгийн эмзэг бүлгийн хүүхэд, иргэдэд нэн тэргүүнд тусламж үзүүлнэ.

Түгээлт хийх байршил тодорхой, үйл явц нь хүүхдэд осол аюулгүй байна. Түгээлт хийхдээ дараах зүйлсийг анхаарч ажиллана. Үүнд:

- Түгээлтийн цэг рүү хүрэх зам нь хөл хөдөлгөөн ихтэй, аюулгүй, зохих тэмдэглэгээтэй, гэрэлтэй, эмэгтэйчүүд, хүүхэд ойр байна.
- Хүүхдийг хамгаалах, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэх талаар хүүхдэд ээлтэй, харагдахуйц мэдээ мэдээллийг бүх түгээлтийн цэгт байрлуулна.

- Түгээлтийн цэгт ажиллаж буй багуудын бүрэлдэхүүнийг хооронд нь тодорхой давтамжтай сольж, ээлжлүүлнэ.
- Түгээлтийн цэгт урт дараалал үүссэн тохиолдолд хүүхдийг эцэг эхтэйгээ хамт байлгах, төөрсөн хүүхдэд туслах цэгийг зохион байгуулна.
- Бага насны хүүхэдтэй асран хамгаалагчдад зун бол нарнаас хамгаалах сүүдэртэй, хүйтний улиралд дулаан, аюулгүй газарт байрлана.
- Бие бялдар эсвэл хамгааллын асуудалтай холбоотойгоор урт дараалалд удаан зогсох боломжгүй хүмүүст зориулсан бүртгэл, түгээлтийг тусад нь хийнэ.
- Түгээлтийн цэг, байршилд биечлэн очих боломжгүй хүмүүст түгээлтийн хувилбарт аргаас сонгож хоол хүнсийг нь хүргэнэ.
- Хүүхэд, жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүд, охидод зориулсан тусгай хоол хүнсийг төлөвлөж түгээнэ.
- Хоол тэжээлийн дутагдал болон хүүхэд хамгааллын эрсдэлтэй хүүхэд, өрхөд тусламжийг нэн тэргүүнд үзүүлэх нийтлэг шалгуурыг тодорхойлно.

Цаг хугацаа, хуваарийг эмэгтэйчүүд, хүүхдийн өдөр тутмын үйл ажиллагаа, сургууль, хичээлийн цагийг тооцож төлөвлөнө. Гэртээ бага насны хүүхэд эсвэл өндөр настан, өвчтэй хүн асардаг хүмүүст түгээлтийг гэрт нь хүргэх зохицуулалтыг хийнэ.

Хүмүүнлэгийн тусламжийг бүх хүнд хүртээмжтэй түгээх үүднээс дараах ажлыг мэргэжлийн ангиуд хамтран хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үнэлгээний явцад хоол хүнс авахад хүндрэлтэй хүүхдийг илрүүлэх;
- Ялгаатай бүлгийн хоол хүнсний хүртээмжийн бэрхшээлийг тодорхойлох;
- Эдгээр бэрхшээлийг даван туулах стратегийг хэрэгжүүлэх чиглэлээр хүүхэд хамгааллын оролцогч талуудтай хамтран ажиллах;
- Өрх толгойлсон, асран хамгаалагчгүй, гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдэд тусламж, бэлэн мөнгө, эрхийн бичгийг өөрийн нэр дээр авахад нь туслах;
- Тусламжийн хэмжээг нэмүүлэх, давхардуулж авах үүднээс хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлахаас урьдчилан сэргийлэх;

- Хүүхдийг дээрэм, мөлжлөгт өртөхөөс хамгаалах.

Хүүхэд хамгааллын зарчмыг бүхий л төрлийн түгээлт, түүний дотор бэлэн мөнгө, эрхийн бичиг олгоход мөрдөнө,

Бэлэн мөнгөний шилжүүлэг болон эрхийн бичгийн тусламжийг төлөвлөх үеэр хүүхэд хамгаалалд үзүүлэх нөлөөг судалж тооцоолно. Төрсний гэрчилгээгүй гэх шалтгаанаар хүүхдийг тусламжаас хоцроож болохгүй.

Түгээлтийн явцад хүүхдэд хор хөнөөл учруулсан талаар мэдээлэх хүүхдэд ээлтэй, нууцлалыг хадгалсан, хүртээмжтэй механизмыг иргэд олон нийттэй хамтран зохион байгуулна. Иргэдээс ирсэн санал, мэдээллийг хүүхэд хамгааллын ахлах мэргэжилтэн хянан нягталж, мэдээллийн мөрөөр цаг алдалгүй хариу арга хэмжээ авна.

Хүүхэд хамгаалал-боловсрол:

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын орон нутгийн салбартай хамтран сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчны гамшгийн үнэлгээг жил бүр хийж илэрсэн зөрчил, дутагдлыг бүрэн шийдвэрлэнэ.

Үнэлгээг үндэслэн сургууль, цэцэрлэгийн удирдлага, сурагчид, эцэг эхийн зөвлөл, багш, ажилчид, холбогдох байгууллагуудтай хамтран "Сургуулийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө"-г шинэчлэх, хэрэгжүүлэх, хянаж үнэлэх ажлыг хийнэ.

Сурагчдад "Аюулгүй амьдрах ухаан" сургалтын хөтөлбөрт тусгасан, гамшгийн үед эрсдэлээс өөрийгөө хамгаалах, бусдад туслахын тулд хэрэгжүүлэх нэн яаралтай алхмуудыг гамшгийн төрөл тус бүрээр бэлдэж, эргэцүүлэл, дүрийн тоглолт, туршилт, сургуулилалт, хэлэлцүүлэг гэх мэт оролцоот сургалтын аргаар эзэмшүүлнэ.

"Сургуулийн гамшгаас хамгаалах менежмент" гарын авлагын агуулгаар сургуулийн удирдлага, нийт багш, ажилтнуудыг хамруулсан дадлага сургуулилтыг жилд 1 удаа хийхээр хичээлийн жилийн төлөвлөгөөнд оруулж, нийт сурагчид, эцэг эхийг хамруулан орон нутгийнхаа Онцгой байдлын байгууллагатай хамтран зохион байгуулж, үр дүнг хянана.

Дадлага сургуулилт нь дараах агуулгыг багтаасан байна. Үүнд:

- Гамшгийн үед нийт сурагчдыг зохион байгуулж аюулгүй байдлыг нь хангах, эрсдэлээс хамгаалах, мэргэжлийн ангиудтай хамтран ажиллах, осолдож гэмтсэн, алга болсон, эцэг эх нь холбоогүй болсон хүүхдүүдийг бүртгэх, эцэг эх, асран хамгаалагчдад нь хүлээлгэж өгөх, эцэг эх нь холбогдохгүй байгаа хүүхдийг хүүхэд хамгааллын мэргэжлийн ангид холбон зуучлах;
- Хүүхэд хамгааллын багийн манлайлал, оролцоог дайчлах;
- Хариу арга хэмжээний олон хэлбэрийг турших;
- Анхны тусламж;
- Сэтгэл зүйн анхны тусламж;
- Сэтгэлийн хөдөлгөөн, стрессээ удирдах;
- Хүүхдийн эрх, жендер ба хөгжлийн бэрхшээлд мэдрэмжтэй хандах;
- Хүүхдийн хувийн нууцыг хамгаалах;
- Хүмүүжлийн эерэг арга;
- Хүүхдийн оролцооны арга.

Гамшгийн үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулахад бэлтгэх үүднээс сайн дураараа ажиллах сонирхолтой тэтгэвэрт гарсан багш, сайн дурын ажилтан, үе тэнгийн сургагч нарын бүртгэлийг тайван цагт гаргана.

Гамшгийн үед боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага нь бүх хүүхдийг тэгш хамруулсан, нэр төрийг нь эрхэмлэн дээдэлсэн, хамгаалал оролцоог нь хангаж дэмжсэн боловсролын үйлчилгээг хүүхдэд ээлтэй аюулгүй орчинд хоцрогдол, тасалдал, чирэгдэлгүй үзүүлнэ.

Гамшгийн үед боловсролын тасралтгүй байдлыг дараах аргаар хангана. Үүнд:

- Халдварт өвчин цар тахал зэрэг хүн хоорондын биет харилцааг хязгаарласан нөхцөлд цахим сургалтад шилжинэ.
- Телевизор, гар утас, интернэтгүй өрхөд амьдардаг, ган зудын улмаас алсад оторлож байгаа малчин өрхийн хүүхдийн боловсрол эзэмших эрхийн хэрэгжилтэд хяналт тавьж, цахим хичээл үзэх, зайнаас суралцах боломж нөхцөлөөр хангаж шаардлагатай дата, техник, хэрэгслийн дэмжлэг үзүүлнэ.

- Олон тооны байшин барилга, сургууль нурж сүйдсэн, хими, бактериологийн хордлого, цацраг идэвхт бодисын хэмжээ эрс нэмэгдсэний улмаас иргэдийг нүүлгэн шилжүүлж түр суурьшлын бүс, хуаран байгуулах хэрэгцээ үүссэн үед түр хичээллэх анги танхим, багш, сургалтын хэрэгцээг тооцож шийдвэрлэнэ.
- Сургалтад хэрэгцээтэй материал хэрэгслээр хангана.
- Цахим болон теле хичээлийг бэлтгэнэ.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах, бусад сургалтад дайчлах багш, хүний нөөцийг шийднэ.
- Сургуулийн болон сургуулиас гадуурх үйл ажиллагааг зохион байгуулах, урлаг, спортын ажлуудыг зохион байгуулах хүүхдэд ээлтэй орон зайг бий болгоно.

Бүртгэгдсэн сайн дурын ажилтан, ахмад багш, үе тэнгийн сургагчийг сургуулийн захиргаа сонгон шалгаруулж сургалтын үйл ажиллагаанд оролцуулахдаа хүүхэд хамгааллын бодлого, ёс зүйн дүрэмтэй танилцуулж, мэргэжлийн удирдлагаар тогтмол хангана. Тухайн гамшиг, онцгой байдлын нөхцөл байдалтай уялдуулан сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг нь хүүхэд хамгааллын мэргэжлийн ангитай хамтран эрсдэлд орсон хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлнэ.

Эцэг эх, асран хамгаалагчаасаа салж төөрсөн, тусгаарлагдсаны улмаас хараа хяналтгүй болсон 0-6 хүртэлх насны хүүхдийг 24 цагийн цэцэрлэгт хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн саналд үндэслэн түр байрлуулахад нутгийн захиргааны байгууллага, цэцэрлэгийн захиргаа хамтран ажиллана.

Эцэг эх, асран хамгаалагчаасаа салж төөрсөн, тусгаарлагдсаны улмаас хараа хяналтгүй болсон, гэр бүлийн хүчирхийллийн уршгаар хамгааллын үйлчилгээ шаардлагатай байгаа 6-17 насны хүүхдийг дотуур байр, байнгын ажиллагаатай хүүхдийн зусланд түр байрлуулж нийгэмсэтгэл зүйн дэмжлэг, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд орон нутгийн хүүхэд хамгааллын мэргэжлийн анги, сургуулийн удирдлага, хүүхдийн зуслангийн удирдлагатай хамтран ажиллана.

Гамшгийн үед янз бүрийн хэлбэрийн хүчирхийллээс өөрийгөө болон найз нөхдөө хэрхэн хамгаалах тухай зөвлөмж, санамжийг сурагчдын өргөн хэрэглэдэг нийгмийн сүлжээний групп дээр байршуулж хэлэлцүүлэг

өрнүүлэх байдлаар тэднийг чадваржуулах ажлыг сургуулийн нийгмийн ажилтан сайн дурынхны оролцоотойгоор зохион байгуулна.

Гамшигт өртсөн хүүхдийг нийгмийн ялгаварлал, сургуулийн болон цахим орчин дох дээрэлхэгчээс хамгаалахад сурагчид нэгдэн дэмжих бүлэг байгуулах, үе тэнгийнхний сургалт явуулахад хүүхэд хамгааллын баг мэргэжил арга зүй, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлнэ.

Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги нь гамшгийн үед сургууль, цэцэрлэгт хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, тулгарч буй эрсдэлийг даван туулах чадвартай болоход нь туслах үйл ажиллагааг бүлгийн ажлаар зохион байгуулах аюулгүй, найдвартай хүүхдэд ээлтэй орон зайг болгоход нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ. Тэнд хүүхдүүд амрах, бие биетэйгээ тоглох, ярилцах, сэтгэл санаагаа сэргээх, сурах зэргээр хэвийн амьдралаа үргэлжлүүлж болохоор зохион байгуулна.

Хүүхдэд ээлтэй орон зайг сургууль, соёлын төв, хүүхдийн зусланд, түр суурьшлын бүс, хуаранд бол гэр, дулааны улиралд майхан, асар зэргийг ашиглан дараах шаардлагын дагуу байгуулна. Үүнд:

- Хүүхэд олж очиход хялбар, аюулгүй байх;
- Хангалттай зай талбайтай байх;
- Аюулгүй, тэгш, хуурай газарт байрласан байх;
- Ариун цэврийн шаардлагад нийцсэн жорлон, гар угаах тосгууртай байх;
- Тэнд ажиллах багш, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эмч, сайн дурынхан зэрэг хүмүүсийг хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр өмнө нь сургаж бэлтгэсэн байх.

Хүүхэд хамгаалал-эрүүл мэнд:

Гамшгийн үед эрүүл мэнд ба хүүхэд хамгааллын хамтын ажиллагаа нь дараах шаардлагыг хангана. Үүнд:

- Хүүхдэд аюулгүй, баталгаатай, үнэ төлбөргүй.
- Хүүхдийг нэмж хохирох, хүчирхийлэлд өртөх, гэр бүл, эцэг эхээсээ төөрч тусгаарлагдахаас хамгаалсан;
- Тэгш хамруулсан;
- Системтэй;
- Бусад бүх салбарын үйл ажиллагаатай уялдсан;

- Хүүхдийн нууцлалыг алдахгүй мэдээлэл солилцох, хадгалах журамтай;
- Хүүхэд, гэр бүл, иргэд олон нийтийн оролцуулсан.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь эрүүл мэндийн салбарт мөрдөх хүүхэд хамгааллын бодлогод гамшигийн үеийн хүүхэд хамгааллын асуудлыг багтаан боловсруулж бүх шатны эрүүл мэндийн ажилтныг сургаж хэрэгжилтэд хяналт тавина.

Гамшигт өртсөн хүүхдийг эмнэлэгт хүргэх, бүртгэх, гэр бүлд нь мэдээлэх, тусгаарлах, хөл хорионд оруулах, эмнэлэгт шилжүүлэхдээ уг арга хэмжээний талаар урьдчилж тайлбарладаг, мэдээлэл өгдөг, сэтгэл зүйн айдас, түгшүүр үүсгэхгүй байхаар зохион байгуулдаг, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлыг хангадаг, эцэг эхээсээ салж төөрсөн, өөрийгөө таниулж илэрхийлж чадахгүй байгаа хүүхдийг олдсон газар, онцлог таних тэмдгээр нь бүртгэж тусгай дугаартай бугуйвч зүүлгэдэг, хүүхэд хамгааллын мэргэжлийн ангид мэдээлдэг байхаар журамлана.

Хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхдээ хүүхдийн нас, хөгжлийн онцлог, тусгай хэрэгцээ, суурь өвчлөл, өвчний хүнд, хөнгөнд нийцүүлэн эцэг эх, асран хамгаалагчийнх нь санал, хүүхдээ асрах чадавхад үндэслэн хүүхдэд ээлтэй шийдвэр гаргах талаар тухайн гамшиг, онцгой байдлын нөхцөлд тохирсон эмчилгээ, үйлчилгээний горимд (зааварт) тусгаж мөрдүүлнэ.

Эцэг эх, асран хамгаалагч нь нас барсан, эмнэлэгт хүргэгдсэн, тусгаарлагдсан, хөл хорионд орсон, хаана байгаа нь мэдэгдэхгүй байгаа хүүхэд гэр бүлээсээ төөрч салах, өнчирч үлдэх, бүх төрлийн хүчирхийлэл, дарамтад өртөхөөс урьдчилан сэргийлж, хүүхдийн тусламжийн 108 утас эсвэл хүүхэд хамгааллын мэргэжлийн ангид шуурхай мэдээлнэ.

Гэмтэл согог судлалын үндэсний төв, Түлэнхийн төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв болон томоохон хээрийн эмнэлгүүд дээр сэтгэл зүйч, нийгмийн ажилтныг хүүхэд, гэр бүлд нийгэм-сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллуулна.

Бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагад хүүхэд түр саатуулах өрөө, тусгаарлан ажиглах өрөө бэлтгэх, өвчтөн зөөх, тээвэрлэх, шилжүүлэх үед мөрдөх дүрэмд хүүхэд хамгаалах бодлогыг тусгаж, хэрэгжүүлнэ.

Хөнгөн хэлбэрээр гэмтсэн, өвдсөн, ажиглалт тусгаарлалтад байгаа хүүхдэд боловсрол, хөгжлийн үйлчилгээнд тасралтгүй хамрагдах нөхцөлийг бүрдүүлж, өрөө бүрд телевиз байрлуулж, хязгаарлалттай интернэтийн орчин бүрдүүлж өгнө. Цар тахлын бус гамшгийн үед хүүхдийн хөгжлийн буюу тоглоомын өрөөг бэлдэнэ.

Эмнэлэгт хэвтэж буй хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндэд анхаарч хүүхдэд сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэх, мэргэжлийн байгууллага, сэтгэл зүйчид холбон зуучлах чадварт эмч, сувилагчдыг сургана.

Тухайн эмнэлэг нь нийгэм-сэтгэл зүйн дэмжлэгийг зайнаас үзүүлдэг төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж уг байгууллагын мэдээлэл, цахим хаяг, утсыг хүүхэд, эцэг эхэд хүртээмжтэйгээр байрлуулж холбогдох боломжоор хангана.

Эрүүл мэнд, осол гэмтлийн төрөлжүүлэн ангилсан мэдээллийг цуглуулж осолдож гэмтсэн, нас барсан хүүхдийн тоо, шалтгаан ба нөхцөл байдал, байршил, цаг хугацаа, гэм буруутай этгээдийн талаар бүртгэл хөтөлж мэдээллийг аймаг, нийслэл, дүүргийн Онцгой комисс, цагдаа, хүүхэд хамгааллын мэргэжлийн ангид хугацаа алдалгүй өгнө.

Эрүүл мэндийн нийт ажилтан хүүхэд хамгааллын бодлоготой танилцаж, дагаж мөрдөнө.

Эрүүл мэндийн ажилтныг хүүхэд хамгааллын зарчим, аргачлалыг ашиглаж хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх, илрүүлэх, холбон зуучлах чиглэлээр сургалтад хамруулна.

Эрүүл мэндийн байгууллага нь гэмтэл, осол, сэтгэцийн ноцтой эмгэгээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, холбон зуучлах, халдварт өвчний үед эрт илрүүлэг, ариутгал цэвэрлэгээнд баримтлах дүрэм журмын талаар хүүхэд хамгааллын мэргэжлийн анги, хамтарсан багийн гишүүдийг сургалтад хамруулна.

Хамтарсан багийн нийгмийн ажилтан болон өрх, сумын эмч нар сэтгэцийн эрүүл мэнд, нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг ба кейс менежментийн салбар дундын зохицуулалтыг хангаж хамтран ажиллана.

Эрүүл мэндийн үзлэг болон бүртгэлийн үед хүүхдийг асран хамгаалагчтайгаа байх зохицуулалтыг нийгмийн ажилтан, өрх, сумын эмч нар хамтран хийнэ.

Гэмтэж бэртсэн хүүхдийг хэрэгцээнд нь нийцсэн, тэгш хамруулсан, сэргээн засах, мэс заслын, болон ортопед протезын үйлчилгээнд хамруулна.

Эрүүл мэндийн ажилтны зүгээс хүүхэд хамгааллын кейсийг илрүүлж холбон зуучлах механизмыг бүрдүүлж ажиллана. Хүүхэд хамгааллын мэдээ мэдээллийг эрүүл мэндийн арга хэмжээнд тусгана.

Гамшигт нэрвэгдсэн хүн амын бүх бүлэгт эрүүл мэндийн чанартай үйлчилгээ хүлээн авах нөхцөлийг бүрдүүлнэ. Үүнд:

- Эрүүл мэндийн үйлчилгээ авахад хүндрэл бэрхшээлтэй учирч буй хүүхэд, гэр бүлийг илрүүлэх;
- Үйлчилгээний хүртээмж хангалтгүй, бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд хүүхэд хамгааллын мэргэжлийн анги, хамтарсан багтай хамтран ажиллах;
- Өрх толгойлсон, асран хамгаалагчгүй, гэр бүлээсээ тусгаарлагдсан бүх хүүхдийг бүртгэх.

Асран хамгаалагчгүй хүүхдийг эрүүл мэндийн үйлчилгээнд хүлээн авах, эмчлэх, эмнэлгээс гаргах хүртээмжтэй, мэдрэмжтэй, хүүхдэд ээлтэй журмыг хэрэгжүүлэхэд хүүхэд хамгааллын мэргэжлийн ангитай хамтран ажиллана.

Бүх хүүхдэд хүртээмжтэй, тэгш хамруулсан, нас, хөгжлийн онцлогт нь нийцсэн бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, хэрэгсэл, мэдээллийг хүргэхэд боловсролын байгууллага, хүүхэд хамгааллын мэргэжлийн ангитай хамтран ажиллана. Үүнд:

- Өсвөр насныхны бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд;
- Бэлгийн ба гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн харьцаанд орох зөвшөөрөл;
- Гэрлэлт;
- Жирэмслэлт;
- Хүүхэд асарч өсгөх эцэг эхийн үүрэг, хариуцлага.

Хүчирхийлэл, дарамт, үл хайхралд, мөлжлөгийн хохирогч хүүхдэд эрүүл мэндийн ганцаарчилсан үйлчилгээ үзүүлнэ.

Хүүхэд хамгаалал-орон гэр:

Гамшиг, онцгой нөхцөл байдлын улмаас орон гэргүй болсон хүүхэд, гэр бүлийг аюулгүй, хамгаалагдсан, хүртээмжтэй зэрэг үндсэн хэрэгцээгээ хангахуйц орон гэрээр хангах ажлыг УОК хариуцна.

Эрсдэлтэй хүүхэд, өрхөд орон гэрийн тусламжийг нэн тэргүүнд үзүүлэх нийтлэг шалгуурыг тодорхойлно.

Орон гэрээр хангах хөтөлбөрийн бүхий л шатанд орон байрны нөхцөл нь аюултай, хангалтгүй болон хүүхэд хамгааллын тулгамдсан асуудалтай өрхийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж, үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллана.

Хүүхдэд ээлтэй, салбар дундын холбон зуучлах механизмыг бүрдүүлж орон байрны тусламж хүргэх явцад илэрсэн хүүхэд хамгааллын кейсийн мөрөөр арга хэмжээ авна. Тусламжийг гамшигт нэрвэгдсэн хүн амын бүх гишүүдэд хүргэхийн тулд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үнэлгээний үр дүнд орон байр, суурьшлын үйлчилгээ авахад хүндрэлтэй байгаа хүүхдийг илрүүлэх;
- Үйлчилгээ авахад бэрхшээлтэй бүлэг, ялангуяа өрх толгойлсон хүүхэд, асран хамгаалагчгүй эсвэл гудамжинд амьдарч буй хүүхдийг илрүүлэх;
- Бичиг үсэгт тайлагдаагүй эсвэл бичиг баримтгүй хүүхдийн асуудлыг шийдвэрлэхэд хүүхэд хамгааллын мэргэжлийн ангитай хамтран ажиллах.

Хүүхэд, тэдний асран хамгаалагчийн оролцоотой орон байр, суурьшлын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дараах нөхцөлийг хангана. Үүнд:

- Байршил нь аюулгүй, нийцтэй байх;
- Өрхийн бүтэц буюу ам бүлийн тоонд нийцүүлэх, хөгжлийн бэрхшээл болон хүртээмжийн бусад онцлог байдлыг харгалзсан байх.

Өрх толгойлсон хүүхэд, асран хамгаалагчгүй, гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдэд орон байрны тусламжийг өөрийн нэр дээр авахад нь туслан, илүү их хэмжээний тусламж авах үүднээс хүүхдийг гэр бүлээс нь санаатайгаар тусгаарлахаас сэргийлж, хүүхдийг хулгай дээрэм, мөлжлөгт өртөхөөс хамгаална.

Төслийн загвар, хэрэгжилтийг нягталж орон байр, суурьшлын хариу арга хэмжээ нь хүн амын бөөгнөрөл үүсгэхгүй, гэр бүлийн гишүүд хамтдаа, нэг гэрт байхад анхаарч ажиллана.

Орон байр, суурьшлын арга хэмжээг төлөвлөхдөө хувь хүний орон зай, аюулгүй байдлыг хангах, ялангуяа охид, эмэгтэйчүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хэрэгцээг харгалзана.

Орон байрны загварыг төлөвлөхдөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд аливаа саадгүйгээр гэртээ орж гарах, гэр дотор болон гэрийнхээ орчимд чөлөөтэй явах, зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

Бүх түр орон байр нь аюулгүй бөгөөд хүний хувийн орон зайгаа хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Орон байрны хэрэгцээг судлахдаа бүх төрлийн үнэлгээнд дараах хүмүүсийг оролцуулна. Үүнд:

- Насанд хүрэгчид (тэр дундаа эмэгтэйчүүд), хөгжлийн бэрхшээлтэй болон бусад бүх хүүхэд {тэр дундаа охид};
- Эрсдэлтэй нөхцөлд буй хүүхдийн асран хамгаалагчид.

Хүртээмжийн саад бэрхшээлийг бууруулах, хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс сэргийлэх зорилгоор эмэгтэйчүүд, охидтой орон байрны төлөвлөлт, орон байрны эд зүйлсийн түгээлт ба цагийн хуваарийн талаарх ярилцлага зөвшилцлийг эрэгтэйчүүд, хөвгүүдээс тусад нь зохион байгуулна.

Орон байр, суурьшлын мэргэжлийн анги хүүхдийн тоо, тэдний хэрэгцээг сайтар судалж сургууль, тоглоомын талбай зэрэг хүүхдэд зориулсан бусад орон зай, байгууламжийг төлөвлөнө. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүний асран хамгаалагчийн хэрэгцээг тооцох нь өрх, иргэд олон нийтийн хамгааллын асуудалд бүхэлд нь эергээр нөлөөлнө. Тиймээс тусгай хэрэгцээтэй өрхийн хүртээмж, орон байрны асуудалд анхаарал хандуулж тэдэнд зориулсан төлөвлөлтийг хийнэ.

Нийгмийн эмзэг бүлгийн богино ба урт хугацааны орон байрны хэрэгцээг хангахын тулд хүүхэд хамгааллын мэргэжлийн анги орон байр, суурьшлын асуудал хариуцсан мэргэжлийн ангитай хамтран дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Өрх толгойлсон эмэгтэйчүүд, өрх толгойлсон хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг орон байраар хангахад иргэд олон нийтийн хүчийг дайчлах;
- Хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй, тэгш хамруулсан, хамгаалагдсан орон байр, орчныг бүрдүүлэх;
- Хүүхэд тоглох дотор ба гадаах талбай, орон зайг тооцох;
- Охид, хөвгүүд тусдаа унтах ор, хөнжлөөр хангах;
- Хүүхдийг орчны осол аюул (нүх, ил задгай жорлон, усны том сав, цахилгааны ил утас, зуух гэх мэт)-аас хамгаалах;
- Суурьшлын бүх талбай, орон зай, орчин нь хангалттай гэрэлтүүлэгтэй байх;
- Хүүхэд сургууль, тоглоомын талбайд ирж очих аюулгүй замыг тооцох;

Зөвхөн хөдөлмөр эрхлэх насанд хүрсэн хүүхэд орон байр, суурьшилтай холбоотой хөдөлмөр эрхэлж буйд хяналт тавьж ажиллана.

Ард иргэдийг дараах онцгой нөхцөл үүссэн үед нүүлгэн шилжүүлж хуарангийн зохион байгуулалтаар үйлчилгээ үзүүлнэ.

- Томоохон хот сууринд газар хөдлөлт, бөмбөгдөлт, дэлбэрэлтийн улмаас орон сууцны хороолол, сургууль нурсан, үерийн улмаас гэр хорооллын олон зуун айл, сургууль, нийгмийн үйлчилгээний байгууллагууд усанд автсан томоохон гамшгийн үед ард иргэдийг түр болон удаан хугацаагаар нүүлгэн шилжүүлэх хэрэгцээ үүснэ. Нэрвэгдсэн өрх, ард иргэдийг эвдрэл сүйрэлд ороогүй хотын нөгөө тал, хотоос зайдуу гэр бүлээр нь байршуулна.
- Томоохон хэмжээний нутаг дэвсгэрийг хамарсан ган, зудын улмаас олон сая мал хорогдож малчид олон зуугаараа амьжиргааны эх үүсвэргүй болсон үед хөдөөгөөс хот руу олноороо шилжин суурьших үзэгдэл гарч болно. Хотын бүсийн газар хувьчлагдсан, ажлын байранд ур чадвар нь тэнцэхгүй гэх мэт шалтгааны улмаас шилжин ирсэн малчин өрхүүд хогийн цэг бараадан албан бус суурьшлын бүс үүсгэн амьдрах үед хүүхдийнх нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх ноцтой зөрчигдөх тул тэднийг зохион байгуулалттайгаар нийгмийн үйлчилгээнд хамруулна.

Салбар дундын зохицуулалттай хуарангийн менежментээр нүүлгэн шилжүүлэлт, шилжилт хөдөлгөөнд өртсөн хүүхэд, гэр бүлийн хэрэгцээ, хамгааллыг хангана.

Хуарангийн удирдлагын багт хүүхэд хамгааллын ажилтныг томилж дээрх үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлж хүүхдийн оролцоо, хамгааллыг хангаж, эрсдэлийг бууруулахад анхаарч ажиллана. Ингэхийн тулд эрсдэлтэй хүүхэд, хүн амын бүлгүүдийг илрүүлж, тэдний хамгааллын хэрэгцээг тодорхойлж хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хуарангийн менежмент ба хүүхэд хамгааллын нийтлэг тулгамдсан асуудлыг тодорхойлж, хариу арга хэмжээний бүхий л шатанд хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулахад анхаарч ажиллана. Хүүхэд хамгааллын тулгамдсан асуудлыг илрүүлэхэд чиглэсэн мэдээллийн менежментийн аргачлалыг боловсруулна. Эрсдэл, аюулгүй байдлын давтамжтай үнэлгээгээр түр суурьшлын бүсийн хүүхэд хамгааллын эрсдэлийг тодорхойлно. Хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулах хүүхэд хамгаалал ба хуарангийн менежментийн хамтарсан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Хүүхэд болон бусад оролцогч талуудтай хамтран хүүхэд хамгааллын асуудлаар хүүхдэд ээлтэй, хүртээмжтэй, нууцлалыг хадгалсан санал авах, мэдээлэх механизмыг боловсруулан хэрэгжүүлэх, хянаж үнэлнэ.

Хүүхэд хамгааллын ажилтан хуарангийн аюулгүй байдлыг хариуцаж бэлгийн болон жендерт суурилсан хүчирхийлэл, хүн хулгайлах, халдлага, хүүхдийн хөдөлмөр болон бусад аюул осол (тэсэрч дэлбэрэх бодис, усан живэх, галд өртөх)-д хяналт тавьж ажиллана. Хүүхэд хамгааллын ажилтан хуарангийн удирдлагатай хамтран дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Хүртээмж ба аюул ослын хяналт үнэлгээ хийх;
- Хүүхэд хамгааллын тодорхой эрсдэл ба хэрэгцээг тодорхойлох;
- Аюул, ослын эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Дээрх арга хэмжээг гамшгийн үед хүүхэд хамгааллын оролцоог тодорхойлсон гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд тусгаж өгснөөр гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудлыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэж өгдөг.

Иймд гамшиг болохоос өмнө гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг шат дараалан зохион байгуулж, хүүхэд хамгаалалд оролцогчдын чадавхыг бэхжүүлэх, эрсдэлийг бууруулах буюу таслан зогсоох, эрсдэлийг даван туулах, хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэх юм. Мөн хүүхдийн хамгааллын оролцоог хангаснаар даван туулах чадварыг бэхжүүлдэг. Энэ нь эрсдэлийг даван туулах чадвартай, эрхээ мэддэг, оролцооны аргад суралцсан, мэдээллийг олж авах, ашиглах чадвартай, гамшгийн талаарх мэдлэг, мэдээлэлтэй эцэг эх, асран хамгаалагчид, баг, бүрэлдэхүүнийг бий болгоно.

Хүүхэд хамгааллын эрх зүйн зохицуулалт. Жил бүр дэлхийн хэмжээнд 175 сая хүүхэд үер, хар салхи, ган гачиг, халуун, хүчтэй шуурга, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт нэрвэгддэг. Байгалийн гамшгийн үед хүүхдүүдийн бие махбодын эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндтэй холбоотой асуудлууд ихээр үүсэж байна. Иймд гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах бодлого, хөтөлбөрийн тусламжтайгаар олон нийтийг гамшигт илүү сайн бэлтгэх, хариу арга хэмжээ авахад нь тусалснаар хүүхдийн эрсдэлийг бууруулж болох учраас гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн зохицуулалтад шинжилгээ хийлээ. Эрх зүйн шинжилгээг олон улсын эрх зүйн зохицуулалт болон үндэсний эрх зүйн зохицуулалтын хүрээнд судаллаа.

Олон Улсын эрх зүйн зохицуулалт. Олон улсын гэрээ, конвенцод нэгдэх, соёрхон батлах асуудлыг Улсын их хурал (УИХ) бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэдэг бөгөөд Монгол Улсын соёрхон баталсан буюу нэгдэн орсон гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэхийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан. Монгол Улс эдүгээ хүний эрхийн олон улсын 60 гаруй гэрээнд нэгдэн орж, мөн дээрх хуульд нийцсэн үндэсний 700 орчим хуулийг батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улс 1989 онд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай НҮБ-ын конвенцод, түүний нэмэлт протоколууд болох Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг (2003), Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг (2004), Мэдээлэл хүргүүлэх журмын тухай (2015) онд нэгдэн орсон. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын үндсэн 8 конвенцыг соёрхон баталсны дотор Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах тухай 182 дугаар конвенцыг 2001 онд, Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай 138 дугаар

конвенцыг 2002 онд соёрхон баталж нийт 30 гаруй олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсноос хүснэгт 1-т байгаа олон улсын гэрээ, конвенц нь гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудлыг нийтлэг байдлаар тусгасан байна.

Хүснэгт 1. Монгол Улсын нэгдэн орсон хүүхэд хамгаалалтай холбоотой олон улсын гэрээ конвенц дахь гамшгийн үеийн хүүхэд хамгааллын зарим зохицуулалт

№	Олон улсын гэрээ, конвенцын нэр	Баталсан огноо	Гамшгийн үетэй холбоотой заалт	Тайлбар
1	Хүний эрхийн түгээмэл тунхаглал	1948.12.10	25.2 “Эх нялхас онцгой асрамж, туслалцаа авах эрхтэй. Баталгаатай гэр бүлээс гарсан буюу бутач гэдгээс үл хамааран бүх хүүхэд нийгмээс адилхан хамгаалалт эдлэх ёстой.”	Бүх хүүхэд нийгмээс адилхан хамгаалалт эдлэх хэрэгтэй.
2	Хүүхдийн Эрхийн тухай конвенц	1989.11.20	3.2 “Оролцогч улсууд хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч буюу түүний төлөө хуулийн дагуу хариуцлага хүлээх бусад этгээдийн эрх, үүргийг харгалзан, хүүхдийг хамгаалах, халамжлах зорилгоор хууль тогтоох болон захиргааны бүхий л зохистой арга хэмжээг авна.”	Хүүхдийг хамгаалах арга хэмжээг авахаар тусгасан.
3	Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сангийн хоорондын хамтын ажиллагааны тухай үндсэн хэлэлцээр	1994.02.08	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан /ЮНИСЕФ/-нь энэхүү болоод бусад тогтоолуудаар санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шаардлагатай зүйлээр хангах, сургалт явуулах, зөвлөгөө өгөх замаар хүүхдийн яаралтай шаардлагатай, байнгын ба хэгийн хэрэгцээг хангах, ... мөн түүнчлэн аль зохистой газарт нь хүүхдийн эсэн мэнд бойжих, хөгжих нөхцөлийг хангах, хүүхдийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийг ЮНИСЕФ-тэй хамтран ажиллаж байгаа орнуудад бэхжүүлэх зорилтыг харгалзан ...энэхүү хэлэлцээрийг байгуулав.	Хүүхдийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийг ЮНИСЕФ-тэй хамтран ажиллахаар заасан.

4	Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай Конвенц	1993.05.29	Энэхүү Конвенц нь зөвхөн эцэг эх хүүхдийн байнгын харилцаа бий болгох үрчлэлтэд хамаарна.	Энэ нь үрчлэгдсэн хүүхдэд хамааралтай байна.
---	---	------------	---	--

Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн гуравдугаар бага хурал Японы Мияги мужийн Сендай хотноо 2015 онд зохион байгуулагдаж, Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг батлан улс орнууд хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү баримт бичигт “Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүн төвтэй үйл ажиллагааг өргөн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг үр дүнтэй, үр нөлөөтэй болгохын тулд олон салбарын олон төрлийн аюулыг тооцсон, хүртээмжтэй болгох хэрэгтэй. Удирдан зохицуулах үүрэг, хариуцлага бүхий Засгийн газрууд бодлого, төлөвлөгөө, стандарт боловсруулах, хэрэгжүүлэхдээ эмэгтэйчүүд, хүүхэд, залуус, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ядуу иргэд, шилжин суурьшигсад, нутгийн уугуул иргэд, сайн дурынхан болон ахмадууд, холбогдох бусад талуудын оролцоог хангах хэрэгтэй. Төрийн, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагууд, академи, шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд нягт хамтран ажиллаж, хамтын ажиллагааны шинэ боломжуудыг бий болгох, бизнесийн үйл ажиллагаандаа гамшгийн эрсдэлийг тооцдог байх шаардлагатай байна; Олон нийтийн онцлог, хэрэгцээ шаардлагыг тусгасан кампанит ажил зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах зэргээр олон нийтийн гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг, мэдээлэл, боловсрол, ойлголтыг дээшлүүлэх үндэсний стратегийг дэмжих;” зэрэг асуудлуудыг тусгасан байна.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалт.

Хүүхдийн эрхийн тухай Конвенцын зарчмыг шингээн 1996 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль нь хүүхдийн эрхийн анхны бие даасан хууль болсон бөгөөд 2016 онд шинэчлэн найруулж Хүүхдийн эрхийн тухай хууль нэртэйгээр баталсан. 2016-2017 онд шинээр баталсан болон шинэчлэн найруулсан Хүүхэд харах үйлчилгээний тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Хүүхэд хамгааллын

тухай, хууль, Эрүүгийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль зэрэг хуулиудад хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, тусламж үйлчилгээ үзүүлэх, хүүхэд хамгааллын зохицуулалтуудыг нарийвчлан оруулсан байна.

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг 2016 онд баталсан бөгөөд эдгээр нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай хуулийн хамт хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж байна. Хүүхдийн эрхийн тухай конвенц нь ийнхүү Монгол Улсын хууль тогтоомжид тусгалаа олж хэрэгжиж байна. Хүүхдийн эрхийн тухай хууль (2016) нь эрхийн талаарх өргөн хүрээний ойлголтыг тодорхойлж, үүрэг хүлээгчдийн хууль ёсны үүрэг хариуцлагыг голчлон хөндсөн бол Хүүхэд хамгааллын тухай хууль (2016) нь хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэх, мөлжих зэрэг бүх хэлбэрийн хүчирхийллээс хүүхдийг хамгаалахад чиглэсэн болно.

Хүснэгт 2. Монгол Улсын нэгдэн орсон хүүхэд хамгаалалтай холбоотой олон улсын гэрээ конвенц дахь гамшгийн үеийн хүүхэд хамгааллын эрх зүйн зохицуулалт

№	Хуулийн нэр	Батлагдсан огноо	Хүүхэд хамгааллын зарим зохицуулалт	Тайлбар
1	Монгол Улсын үндсэн хууль ¹	1992.01.13	Үндсэн хуулийн дагуу иргэнийхээ хувьд хүүхэд амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хувийн өмчтэй байх, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, сурч боловсрох, ерөнхий боловсролыг төлбөргүй эзэмших зэрэг үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэх эрхтэй. Монгол Улсын иргэд Үндсэн хуулиараа үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх журамт үүрэг хүлээдэг.	Монгол Улсын үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн “Хүний эрх, эрх чөлөө”-г нэгэн адил эдэлнэ.
2	Иргэний хууль ²	2002.01.10	Тус хуулийн дагуу насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн бүрэн бус чадамжтай байна. Бүрэн бус чадамжтай иргэн хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг хууль ёсны	Хуульд эрх зүйн чадамжгүй, эрх зүйн зарим чадамжтай, эрх зүйн бүрэн бус чадамжтай

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992, №1 “Монгол Улсын үндсэн хууль”

² Төрийн мэдээлэл эмхэтгэл 2002, №7 “Иргэний хууль”

			<p>төлөөлөгчийн бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хийнэ. Насанд хүрээгүй хүнд өөрийн хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, тэдгээртэй адилтгах бусад орлого, тэдэнд өөрийн үзэмжээр захиран зарцуулахад нь зориулж шилжүүлсэн эд хөрөнгийг захиран зарцуулах, өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх ахуйн чанартай хэлцэл хийх эрхийг хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр бие даан хэрэгжүүлж болно. Мөн тус хуулиар 7-14 хүртэлх насны этгээд иргэний эрх зүйн зарим чадамжтай, 7 хүртэлх насны этгээдийг иргэний эрх зүйн чадамжгүй гэж тус тус тодорхойлсон.</p>	<p>талаар тодорхой тусгаж өгсөн.</p>
3	Эрүүгийн хууль ¹	2002.01.03	<p>Эрүүгийн хуулийн ерөнхий ангид зааснаар гэмт хэрэг үйлдэх үедээ 16 нас хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин 14-16 хүртэлх насны хүн уг хуулийн тусгай ангийн хүнийг алах, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, хүчиндэх, хулгайлах, дээрэмдэх зэрэг арван хоёр төрлийн гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн ба 18 насанд хүрээгүй хүнд ял оногдуулахгүйгээр энэ хуульд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно. Өсвөр насны хүн сэтгэцийн хөгжлийн хоцрогдлын улмаас өөрийн үйлдэл, эс үйлдэхүүн хууль бус шинж, түүний улмаас учрах хор уршгийг бүрэн хэмжээгээр ухамсарлах</p>	<p>Эрүүгийн хариуцлагыг хүүхдэд хэрхэн хариуцлагыг хүлээлгэх талаар тусгасан.</p>

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2002, №5 “Эрүүгийн хууль”

			чадваргүй бол ял оногдуулахгүй байж болно.	
4	Боловсролын тухай хууль ¹	2002.05.03	Боловсролын тухай хуулиар хүүхэд сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролыг үнэ төлбөргүй эзэмших, төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөх; оюун ухаан, авьяас билэг, бие бялдар, ур чадвараа хөгжүүлэхэд төрөөс дэмжлэг авах; чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрийгөө хөгжүүлэх хүүхдийн эрхийг хуулиар баталгаажуулсан.	Сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх хүүхдийн эрхийг хуулиар баталгаажуулсан.
5	Хөдөлмөрийн тухай хууль ²	2021.01.01	Хөдөлмөрийн тухай хуулиар 16 насанд хүрсэн хүн хөдөлмөрийн гэрээ байгуулах эрхтэй боловч насанд хүрээгүй хүнийг оюун ухааны хөгжил, эрүүл мэндэд нь харшлах хөдөлмөр эрхлүүлэх, шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн нийтээр амрах баярын болон долоо хоногийн амралтын өдөр болон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлтэй ажилд ажиллуулахыг хориглоно. Мөн ажлын цагийг 14-15 насны ажилтанд 30 цаг хүртэл 16-17 насны болон хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд 36 цаг хүртэл байхаар богиносгож насанд хүрээгүй ажилтны эрүүл мэндийг хамгаалдаг.	Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг хааж өгсөн.
			2022 оны 1 дүгээр сарын 1-с мөрдөгдөх Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар байнгын асаргаатай хүүхдээ асарч байгаа эцэг, эх тодорхой хэмжээний хөнгөлөлт	Хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэхээр тусгасан.

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2002, №19 “Боловсролын тухай хууль”

² Төрийн мэдээлэл эмхэтгэл 2021, №31 “Хөдөлмөрийн тухай хууль”

			эдлүүлэх, ажил олгогч нь ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх зэрэг шинэ заалтууд тусгагдсан байна.	
6	Гэр бүлийн тухай хууль ¹	1999.06.11	Хуульд хүүхэд гэр бүлийн дотор тэгш эрх эдлэх, гэрлэгчид дагавар хүүхдийг ялгаварлан гадуурхаж, эрх, ашиг сонирхлыг нь хохироохгүй байх, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, эцэг, эх хүүхдийн ашиг сонирхол хоорондоо зөрчилдвөл Засаг дарга хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах төлөөлөгчийг томилох, гэрлэгчид гэрлэлт цуцлуулах үед хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзэх, бүтэн өнчин, эцэг, эх нь хүндэтгэн үзэх шалтгаанаар хүүхдээ биечлэн тэжээн тэтгэх бололцоогүй, эсхүл зайлсхийсэн бол хүүхдийн эрх, ашиг сонирхлыг Засаг дарга хамгаалах зохицуулалт байдаг.	Хүүхэд үрчлэх, гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж байна.
7	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	2016.12.22	Хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангахаар зохицуулсан. Энэ чиглэлээрх үйл ажиллагааны зохих журмуудыг эрх бүхий талууд баталж, цагдаа, эрүүл мэнд, нийгмийн ажилтнууд зэрэг мэргэжилтнүүд хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж эхэлсэн.	Хохирогч хүүхдийг хамгаалах үйлчилгээг нарийвчлан зохицуулсан.
8	Хүний эрхийн Үндэсний комиссын тухай	2020.01.23	Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны зарчим, эрх зүйн	Хүүхэд гэж тусгайлан заагаагүй ч

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл 1999, №30 “Гэр бүлийн тухай хууль”

	хууль ¹		үндсийг тодорхойлж, Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн боловсролыг олон нийгэд түгээх, дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	хүний эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлыг заасан.
9	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай ²	2016.02.05	Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулдаг	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бие даан амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн.
10	Хүүхэд харах үйлчилгээний тухай ³	2015.07.02	Энэ хуулийн зорилт нь эрүүл, аюулгүй орчинд хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулдаг.	Хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд асран халамжлах, хамгаалах, хооллох, тоглуулах, амрах үйл ажиллагааг зохицуулсан.
11	Хүүхдийн эрхийн тухай ⁴	2016.02.05	Энэ хуулийн зорилт нь хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Хүүхдийн эрхийг хангах, хамгаалах харилцааг нарийвчлан тусгасан.

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020, №18 “Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль”

² Төрийн мэдээлэл эмхэтгэл 2016, №28 “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”

³ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2015, №19 “Хүүхэд хамгааллын тухай хууль”

⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2016, №19 “Хүүхдийн эрхийн тухай хууль”

12	Хүүхэд хамгааллын тухай хууль ¹	2016.02.05	Энэ хуулийн зорилт нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	Хүүхэд хамгааллын чиглэлээр явуулах үйл ажиллагаа, хамтын ажиллагааг тусгасан.
----	--	------------	--	--

Дээрх хуулиудад хүүхэд хамгааллын тогтолцоо бэхжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Хүүхэд хамгааллын талаарх хуулиудад хэрэгжилтийг хангах тогтолцоонд салбар хоорондын хамтын ажиллагааны зохицуулалт хангалтгүй, хүүхдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийн хариуцлагын тогтолцоог тусгах шаардлагатай. Мөн хүүхэд хамгааллын тогтолцоонд хүүхдийн тусламжийн утас, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхдийн эрхийн улсын байцаагч зэрэг олон үйлчилгээ үзүүлэгч талууд нэмэгдсэн хэдий ч талуудын хамтын ажиллагаа дутагдалтай гэж үзэж байна.

Хөгжлийн бодлого, хөтөлбөр, стандартууд. Монгол Улсын Засгийн газар хүн амын гуравны нэгийг эзэлж байгаа хүүхдэд хуулиар олгогдсон эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалуулах, сурч боловсрох, хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрх, эрх чөлөөг нь хангахад чиглэсэн олон улсын болон үндэсний бодлогыг тасралтгүй хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлсээр байна. Мөн 2016 оноос хойш явуулж буй бодлого нь тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд анхаарч байна. Үүний тод жишээ нь Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн баримт бичгийг тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан боловсруулж, хэрэгжүүлж байгаа явдал юм.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болох алсын хараатайгаар “Алсын Хараа-

¹ Төрийн мэдээлэл эмхэтгэл 2016, №28 “Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль”

2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан юм. Тус бодлогын баримт бичигт “Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн гэр бүл, хүүхэд, хүн амын бүлгүүдийн талаар баримтлах бодлого боловсруулж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулах (2.3.2.); Хүүхэд хамгаалах төв, асрамжийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлэх (9.1.8.) зэрэг зорилтуудыг тусгасан.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2020-2024) нь хүүхэд хамгааллын чиглэлээр хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого; хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах түр хамгаалах байр байгуулах зэрэг зорилтуудыг тусган хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах тусламж, дэмжлэг үзүүлэх журам” нь Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан аюулт үзэгдэл, осол болон олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан, эмх замбараагүй байдал зэрэг онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд тусламж, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг хангах, хүүхдийн бүх төрлийн дарамт, хүчирхийлэл, үл хайхрах явдал, мөлжлөгөөс хамгаалуулах эрхийг хангахын тулд цаг алдалгүй тусламж, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн, боловсролын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага нь нутгийн захиргааны байгууллага, цагдаа, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар тусгасан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/205 дугаар тушаалын хавсралтаар "Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө" батлагдсан. Тус стратеги төлөвлөгөөний “Хүн амын хөгжлийн бодлого” ерөнхий чиг үүргийн 1.3-ын “Хүн амын бүлгүүдийн хөгжлийн бодлого”-ын 1.3.1 Хүүхдийг гэр бүл, нийгмийн ээлтэй орчинд эсэн мэнд, аюулгүй хүчирхийллээс ангид өсөх нөхцөлийг бүрдүүлэх, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх” гэж тусгасан.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар “Хүүхдэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” тогтоолоор Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн эрхийн конвенц, Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн үзэл санаатай уялдуулан байгууллага, салбар бүрд мөрдөх Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичгийг боловсруулан батлагдсан байна. Энэ нь байгууллага, хуулийн этгээд нь өөрийн ажил үйлчилгээ болон ажилтан албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалахад хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх асуудлыг тусгасан.

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналаар Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2016 оны А/69 дүгээр тушаалаар “Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хороог байгуулан хүүхэд хамгааллын үйл ажиллагаа, үйлчилгээнд хүүхдийн эрхийн хэм хэмжээг тогтоосон 15 стандартыг эмхэтгэсэн.¹

Гамшигийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийн хүрээнд “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгааллын нийтлэг шаардлага MNS 6948:2021” стандартыг 2021 онд баталсан.

Энэхүү стандартуудаас “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS 6948:2021” стандарт нь гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн амь насыг аврах, аюулгүй байдлыг хангах, бүх төрлийн дарамт, хүчирхийлэл, үл хайхрах явдал, мөлжлөгөөс хамгаалуулах хүүхдийн эрхийг баталгаажуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зохистой хариу үйлчилгээг хүүхэдтэй хамааралтай асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны шат, шатны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн анги, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн

¹ Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Стандарт, хэмжил зүйн газар “Хүүхдийн эрхийн стандартын эмхэтгэл” -Уб., 2022.

байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийт хамтран зохион байгуулах үйл ажиллагааны зохицуулалт уялдаа холбоог хамарна. Мөн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулахад, хүүхэд хамгааллын үйлчилгээний цар хүрээ, чанарын үр дүнг тодорхойлоход, хүүхэд хамгааллын хамтын ажиллагааг зохицуулахад, хүүхэд хамгааллын асуудлаар нөлөөллийн ажлыг зохион байгуулахад, шийдвэр гүйцэтгэгч нарт хүүхэд хамгааллын зарчим, нэн тэргүүний асуудлаар танилцуулга хийхэд, хүмүүнлэгийн бусад салбарын хүүхэд хамгаалах чадавхыг бэхжүүлэх зэрэг асуудлууд гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд оролцож байгаа талууд дотооддоо болон байгууллага хоорондын хамтын ажиллагаанд ашиглах талаар тусгасан болно.

§1.2. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх олон улсын туршлага

НҮБ-ын Хүүхдийн сан нь 190 гаруй улс орон, нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж, судалгаа, шинжилгээний нотлох баримт, судалгаа, өгөгдөлд суурилсан тайланг жил бүр гаргаж, олон улсад хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна. Үүний нэг жишээ бол НҮБ-ын Хүүхдийн сангаас 2022 онд батлагдсан “2022–2025 он хүртэлх стратегийн төлөвлөгөө”-г гарган батлуулсан явдал юм.¹

Энэхүү төлөвлөгөө нь хүүхдийн эрхийн тухай конвенцод заасан хүмүүнлэгийн үйл ажиллагаанд хүүхдийн төлөөх үндсэн амлалтыг удирдан чиглүүлсэн бүх хүүхдийн эрхийг хөхүүлэн дэмжих талаар НҮБ-ын Хүүхдийн сангаас хүлээсэн үүрэг амлалтыг тусгаж боловсруулсан баримт бичиг юм. Мөн бүх хүүхдэд хүрэх НҮБ-ын Хүүхдийн сангийн бүх нийтийн үүрэг хариуцлагыг тусгасан байна. Энэ нь сүүлийн 4 жилийн туршлага, сургамж болсон аюул, эрсдэлийн мэдээллүүд, түүний дотор Ковид-19 цар тахлын сургамж, түүнчлэн тогтвортой хөгжлийн зорилтуудад өгсөн амлалтынхаа дагуу улс орон, нийгмийг сэргээн босгох, хүүхдийн хамгааллыг дэмждэг тогтолцоог бэхжүүлэхэд туслах болно.

Энэхүү баримт бичигт хүүхдийн төлөө хийсэн ажлуудын хэрэгжилтийн тайлангийн мэдээлэлд:

- Дэлхийн улс орны 0-5 насны нас баралт 1990-2019 оны хооронд 59 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- Сүүлийн арван жилд хүүхдийн гэрлэлт буурсан байна.
- 2020 онд 61 улс нийгмийн хамгааллын хүчирхэг буюу дунд зэргийн хүчтэй тогтолцоотой байсан нь 2017 оны тооноос хоёр дахин их үзүүлэлттэй гарсан.
- 2000 оноос хойш дэлхий даяар 5-аас доош насны хүүхдүүдийн тоо гуравны нэгээр нэмэгдэж хүүхдүүдийн тоо 55 саяд хүрсэн байна.
- 2016-2020 оны хооронд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэй хөтөлбөрүүдээр дамжуулан 95 сая орчим охид, хөвгүүдийг тус тусын боловсролыг олгох зорилгоор суралцах материалаар

¹ www.unicef.org

хангаж, боловсролын түвшин олгосон нь ахиц дэвшилттэй байна гэдгийг харуулж байна гэжээ.

Харин цаашид хүүхдийн төлөө хийх ажлууд илүү ихийг хийхийг шаардаж байна. Энэ нь:

- 5-аас доош насны 48 сая хүүхэд 2020-2030 оны хооронд урьдчилан сэргийлэх боломжтой шалтгаанаар нас барна гэж таамаглаж байна.
- Хоол тэжээлийн дутагдал нь 5-аас доош насны гурван хүүхэд тутмын нэг нь буюу 200 сая хүүхэд өртөнө. Харин гурван хүүхдийн хоёр нь 6-23 сар өсөж, хөгжиж, бүрэн чадамжаа олох хүртлээ хамгийн бага хоолны дэглэмээр хооллосоор байна.
- 2020 оны 3 дугаар сараас 2021 оны 3 дугаар сар хүртэлх нэг жилийн хугацаанд сургууль эрсдэлд орж, хаагдсанаас болж 214 сая сурагч биечлэн хичээллэх ангийнхаа дөрөвний гурваас илүүт алдсан байна.
- Дэлхий дахинд хүүхэд, өсвөр насныхны 10-20 хувь нь сэтгэцийн эмгэгтэй байна. Сэтгэцийн бүх эмгэгийн тал хувь нь 14 наснаас, дөрөвний гурвыг 20-иод насны дунд үеэс эхэлдэг.
- Ойролцоогоор 1,2 тэрбум хүүхэд (2019 оныхоос бараг хоёр дахин их) эрсдэл, эмзэг байдал үүссэн орнуудад амьдарч байна.
- 500 сая орчим хүүхэд үер усны эрсдэл ихтэй буюу маш өндөр эрсдэлтэй бүс нутагт амьдарч байна. 160 сая хүүхэд ган гачигт нэрвэгдэх эрсдэлтэй буюу өндөр эрсдэлтэй бүс нутагт амьдарч байна. 2040 он гэхэд дөрвөн хүүхэд тутмын нэг нь усны хэт ачааллын үе буюу усны хомсдолд амьдрах юм.
- Хүүхдийн хөдөлмөрийн насны хүүхдийн тоо дэлхий даяар 160 саяд хүрч, 4 жилийн хугацаанд 8.4 сая хүүхэд нэмэгджээ.
- Дэлхийн 1-14 насны хүүхдүүдийн дөрөвний гурваас илүү нь ихэвчлэн 5 настайгаасаа эхлэн бие махбодын хохирол эсвэл сэтгэл санааны түрэмгийлэл, хүчирхийлэлд өртдөг.
- Хөгжиж буй орнуудын бүх хүүхдийн бараг тал хувь нь материаллаг гачигдалд өртдөг бөгөөд дэлхий даяар хүүхдүүдийн дөнгөж 35 хувь нь нийгмийн хамгаалалд хамрагддаг.

Иймээс НҮБ-ын Хүүхдийн сангийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөнд хүүхэд, багачуудад зориулсан дунд, урт хугацааны хүрэх үр

дүнгийн түвшний өөрчлөлтөд хүрэхийн тулд хөтөлбөр, үйл ажиллагаандаа өөрчлөлтийг тусгасан бичиг баримтыг мөрдлөг болгон ажиллахаар тусгасан байдаг. Үүнд:


Хүүхдийн эндэгдэл, ядуурал, эмзэг байдал, хүйсийн тэгш бус байдал, гадуурхалтын үндсэн шалтгааныг бүх нөхцөлд шийдвэрлэхэд хүүхэд хамгааллын тогтолцооны өөрчлөлтөд анхаарлаа хандуулна. Үүнд:

- Хүүхэд хамгааллын хүмүүнлэгийн хямрал, эмзэг нөхцөл байдал,
- Хүүхэд хамгааллын санхүүжилтийг нэмэгдүүлэх,
- Эрх зүйд суурилсан бодлого, хууль тогтоомжийг дэмжих;
- Тэгш хүртээмжтэй шаардлагатай хангамж, үйлчилгээг нэмэгдүүлэх;
- Хүүхдийн төлөө дэлхий нийтийн түншлэл, хамтын ажиллагааг зохицуулах;
- Хүүхдийн талаарх мэдээллийн орчныг өөрчлөх;
- Гэр бүл, эцэг эхээ дэмжих;
- Нийгмийн зан төлөв, хэм хэмжээнд нөлөөлөх.

Дэлхий дахины нэгдмэл байдал, сайн үйл ажиллагаа явуулж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын системд нэгдсэн, хувийн секторыг ашиглах, НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтын ажиллагааг сэргээж, эх үүсвэрийн дайчилгааг өргөжүүлэхийн зэрэгцээ орон нутгийн хүүхэд хамгаалалд анхаарал хандуулах хэрэгтэй.


НҮБ-ын Хүүхдийн сан нь хүүхдийн эрхийн тухай конвенцын дагуу хүүхдийн эрхтэй холбогдсон таван урт хугацааны үр дүнд хүрэх зорилготойгоор стратеги төлөвлөгөөг хүүхэд хамгааллын хүмүүнлэгийн хямрал, эмзэг нөхцөл байдалд хүүхэд бүр, түүний дотор өсвөр насныхан: (1) амьд үлдэж, цэцэглэн хөгжиж байх, шим тэжээлтэй хоолны дэглэм, чанартай үндсэн эрүүл мэнд, хүмүүжлийн дадал хэвшилтэй байх зайлшгүй шаардлагатай хангамжууд; (2) ирээдүйд ур чадвартай болоход суралцах, мэдлэг олж авах, эзэмших; (3) хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах, хор хөнөөлтэй үйлдэл, эрсдэлт байдлаас хамгаалагдсан; (4) ус, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан аюулгүй, эрүүл орчинд амьдрах, тэгш хүртээмжтэй шаардлагатай хангамж, үйлчилгээг авах; (5) нийгмийн хамгааллыг хүртэж, ядуурлаас ангид амьдарна гэсэн 5 хүрэх үр дүнг тодорхойлсон.

Зураг 1. НҮБ-ын Хүүхдийн сангийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөний хүрэх үр дүн



Эх сурвалж. НҮБ-ын Хүүхдийн сангийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөө

Зураг 2. 2022–2025 оны стратеги төлөвлөгөө: 2030 он руу чиглэсэн шинэчлэл



Эх сурвалж. НУБ-ын Хүүхдийн сангийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөө

НҮБ-ын Хүүхдийн сангийн 2022 оны тайланд¹ "Бид энэ жил дэлхий даяар урьд өмнө байгаагүй их хэмжээний үер болж, үүнтэй зэрэгцэн хүүхдүүдэд аюул заналхийлсэн байгалийн аюулт үзэгдлийг харж байна." "Уур амьсгалын хямрал энд байна. Олон газар үер нэг буюу хэд хэдэн удаа тохиолдсон хамгийн аймшигтай үе юм. Манай хүүхдүүдийн эцэг эх хэзээ ч байгаагүй хэмжээгээр зовж шаналж байна." гэж тэмдэглэсэн байна.

Өнгөрсөн жил хөгжингүй орнууд дасан зохицоход үзүүлэх дэмжлэгийг 2025 он гэхэд жил бүр 40 тэрбум ам.долларт хүргэхээр төлөвлөгдөн ажиллаж байна. Жил бүр 300 тэрбумаас доошгүй доллар хүргэх алхам болгон үүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой үе шатуудыг агуулсан найдвартай аюулын замын зураглал болон 2030 он гэхэд дасан зохицох чадварын талаарх авах арга хэмжээг танилцуулах ёстой. Уур амьсгалын нийт санхүүжилтийн наад зах нь тал хувь нь дасан зохицоход чиглэх ёстой.

НҮБ-ын Хүүхдийн сангаас үерт нэрвэгдсэн орнуудад үзүүлэх хүмүүнлэгийн яаралтай арга хэмжээ нь эрүүл мэнд, хоол тэжээл, ус, ариун цэвэр, эрүүл ахуй, хүүхэд хамгаалал, боловсрол зэрэг бүх салбарт өргөн хүрээг хамарч байна. Гэсэн хэдий ч санхүүжилт дутмаг байгаа нь олон оронд хариу арга хэмжээ авахад саад болж байна. Тухайлбал, Пакистанд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх санхүүжилтийн зөрүү одоогоор 85 хувьтай байна.

НҮБ-ын Хүүхдийн сан нь гамшгаас үүдэлтэй аюулыг даван туулахын тулд олон нийт, эрүүл мэндийн дэд бүтцийн чадавхыг бэхжүүлэх, хүмүүнлэгийн хариу арга хэмжээ болон урт хугацааны уур амьсгалд дасан зохицох чиглэлээр хийж буй ажлуудаа улам нягт уялдуулахаар ажиллаж байна.

2022 онд үерт нэрвэгдсэн 27.7 сая хүүхдийн дийлэнх нь хамгийн эмзэг бүлгийнх бөгөөд усанд живж нас барах, өвчний дэгдэлт, ундны усны хомсдол, хоол тэжээлийн дутагдал, сурах үйл явц тасалдал зэрэг олон аюулд өртөх өндөр эрсдэлтэй байна. хүчирхийлэл. Үерийн дараах үр дагавар нь ихэвчлэн үерийн улмаас үүссэн цаг агаарын эрс тэс үзэгдлээс илүү хүүхдүүдэд илүү их үхэлд хүргэдэг. 2022 онд үер нь хоол тэжээлийн дутагдал, хумхаа, холер, суулгалт зэрэг хүүхдийн гол алуурчдын тархалт

¹ www.unicef.org/state-worlds-children-2022

нэмэгдэхэд нөлөөлсөн. Пакистанд үерт нэрвэгдсэн Синд, Белужистан мужийн эрүүл мэндийн байгууллагуудад хэвтэн эмчлүүлж буй тав хүртэлх насны 9 хүүхэд тутмын 1-ээс илүү нь хоол тэжээлийн дутагдалд орсон байна. Саяхан Пакистанд болсон үерийн улмаас 27,000 орчим сургуулийн барилга эвдэрч сүйдэж, 2 сая хүүхэд хичээлдээ хоцрохоос өөр аргагүйд хүрчээ.

2022 оны нэгдүгээр сард Малавид аадар бороо орж, халуун орны Ана шуурганы улмаас ус, ариун цэврийн байгууламжид их хэмжээний хохирол учирсан нь холерын дэгдэлт гарах нөхцөлийг бүрдүүлсэн. Дэгдэлтийн улмаас 203 хүн амиа алдсаны 28 нь хүүхэд байна. Өнөөдрийн байдлаар 1631 хүүхэд холероор өвчилсөн гэсэн мэдээ байна.

Чадад 465,030 га тариалангийн талбай сүйдэж, хүнсний аюулгүй байдлын аль хэдийн хүнд байдалд орсон.

Уур амьсгалын бусад цочрол, мөргөлдөөний хамт үерийн улмаас Өмнөд Суданд хүнсний аюулгүй байдлын алдагдал их байгаа ба хүнсний хангамж, үйлчилгээ, тусламж авч чадахгүй байгаа хүүхдүүдийн тоо 2013, 2016 оны мөргөлдөөний үеэр ажиглагдаж байсан түвшингээс давсан байна. Мөн НҮБ-ын тайланд “ зарим ард иргэд ийм эрсдэлтэй байгааг анхааруулсан. хүмүүнлэгийн тусламж тогтвортой байж, уур амьсгалд дасан зохицох арга хэмжээг нэмэгдүүлэхгүй бол өлсгөлөнд нэрвэгдэх болно” гэдгийг тэмдэглэсэн.

Дэлхий дахинаа уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн үед хүүхдийн эмзэг байдалтай холбоотойгоор дараах эрсдэлүүд хамгийн өндөр дүнтэй гарсаар байна. Тухайлбал:

Газар хөдлөлт: Газар хөдлөлт нь үзүүлэх хор хөнөөлөөрөө байгалийн бусад гамшигтай зүйрлэхийн аргагүй их байдаг. Армений 1988 оны 12 дугаар сард болсон газар хөдлөлт, хойд Сахалины Нефтегорскийн 1995 оны 5 дугаар сарын сүүлчээр болсон газар хөдлөлт зэргийг санацгаая. Хэчнээн хүүхэд гэртээ, сургууль дээрээ, цэцэрлэг дээрээ нэрвэгдлээ? Бараг бүгд гэнэт, аюулын тухай оршин суугчдад урьдчилан зарлан мэдээлэх боломжгүй тохиолдогоороо газар хөдлөлт хамгийн хортой үр дагавартай байдаг. Хүмүүст бодит үйл ажиллагаа явуулах минут, секунд ч оногддоггүй. Хэрэв чичирхийллээр байшин чинь тэсэж үлдсэн бол нэгдүгээр давхарт байгаа нь хүүхдээ аваад маш яаралтай гадаа гарах хэрэгтэй. Танд ердөө 15-20 секунд л байгаа. Хоёроос дээш давхарт амьдарч

байгаа хүмүүс хүүхдээ биедээ наагаад хаалга, тагтныхаа рамын доор орж зогсох хэрэгтэй. Мөн тасалгааны булан, даацын ханыг ашиглаж болно. Эдгээр нь арай бат бөх учраас аюулаас хохирол багатай гарах боломж илүү байдаг. Хүүхдэд цонх, тагтнаас үсрэх боломж олгож хэрхэвч болохгүй. Ихэнх тохиолдолд энэ нь эмгэнэлт байдалд хүргэдэг. Чичирхийлэл зогсмогц нэн даруй байшингаасаа гарах хэрэгтэй. Ингэхдээ хүүхдийг ганцаар нь үлдээж болохгүй. Хэрэв цахилгаан шат ашиглах юм бол тэндээ гацаж болзошгүй. Нэг ч хүүхэд эвдэрсэн байшин руу оруулж болохгүй гэдгийг хатуу анхаарах хэрэгтэй. Газар хөдөлсний дараа дахин давтан газар хөдлөлт болдог. Үүнд бэлэн байхаас гадна хүүхдүүддээ анхааруулах хэрэгтэй. Давтан газар хөдлөлт нь хэдэн цаг, заримдаа хэд хоногийн дараа ч болдог тохиолдол бий. Хүүхдүүд лаа, чүдэнз, асаагуур зэргийг ашиглах дуртай байдаг тул ийм асуудал гаргаж болохгүй. Шатдаг хий ашигладаг газар хий алдагдсанаас дэлбэрэлт болж хүүхэд, насанд хүрэгчид хэн ч нэрвэгдэж болно. Газар хөдлөлтийн анхны чичирхийлэл таныг гадна явахад тохиолдож болно. Тэгвэл барилга, байгууламж, өндөр хашаа, багана зэрэг нь нурах аюултай тул тэдгээрээс хүүхдүүдээ маш яаралтай холдуулах хэрэгтэй.

Газар хөдлөлтийн аюултай нутаг дэвсгэрт байгаа хүүхдийн байгууллага, сургуулийн ажилтнууд байшин барилга нурах, эвдрэх үед хана, хаалтууд унахаас гадна бутран унаж байгаа шил, яндан, рам, байшингийн хаяг, чимэглэл, тагт, гэрэлтүүлгийн төхөөрөмж, гудамжны самбар, замын тэмдгийн эвдэрсэн хэсгүүд үсэрч аюул учруулдаг гэдгийг сайтар ойлгож мэдсэн байх хэрэгтэй. Хэрэв та гэмтэж бэртсэн хүүхэд харвал тэр дор нь эмнэлгийн анхны тусламж үзүүлэх хэрэгтэй.

Гал түймэр: Гал түймэр аж үйлдвэрийн салбар, хөдөө аж ахуйн объект, сургууль, цэцэрлэг, орон сууцны барилгуудад хаа сайгүй гардаг. Эдгээр гал түймрийн 50 орчим хувь нь гэр болон орон сууцны барилгад гардаг. Мөн бүх төрлийн тээврийн хэрэгслээр шатахуун тээвэрлэх үед гал түймэр гарч байна. Скипидар (шилмүүст модноос гаргаж авдаг шингэн тос), камфор, нафталин зэрэг химийн бодис нь өөрөө аяндаа шатах тохиолдол түгээмэл байдаг. Хоорондоо үрэлдэх явцад хүчтэй хордолт өгдөг хорт бодис ялгаруулдаг. Модны, нүүрсний (хүлрийн), гурилын, үр тарианы, хөвөнгийн, маалингын тоос тодорхой нөхцөлд аюултай болж, өөрөө аяндаа шатдаг. Манай улсад жилд 3000 орчим гал түймэр гарч 50-60 хүн амь насаа алдаж байгаагийн 20-50 хувь нь хүүхэд байна. Үүнээс гадна түлэгдэж

гэмтсэн хүүхэд бүр ч олон байна. Эдгээр тоо бидэнд анхааруулга өгөөд зогсохгүй шийдвэртэй алхам хийхийг биднээс шаардаж байна. Ийм нөхцөл байдалд түймэр гарч байгаа газраас хүүхдийг гал, утаан дундуур гаргана гэдэг хүсээд байхаар зүйл биш гэдгийг санах хэрэгтэй. Илүү хөнгөн, аюулгүй арга замыг эрэн хайх хэрэгтэй. Хэрэв уг барилгын шатыг ашиглах боломжгүй бол цахилгаан шатаар эсвэл цонх болон тагтаар автомашины өргөгч, зөөврийн болон нэмэлт шат оруулж тэднийг буулгахыг оролдох хэрэгтэй. Хэрэв бүх гарцууд галаар хаагдсан бол ямар нэг аюулгүй газар нуугдаж хэрхэвч болохгүй, бөх олс юм уу орны хэд хэдэн даавууг хооронд нь найдвартай холбоод нэг үзүүрт нь хүүхдээ сайн уяад нөгөө үзүүрийг нь халаалтын радиатор зэрэг хүнд зүйлд уяад уг олс буюу даавууг гартаа сайн ороож хүүхдийг алгуурхан доошлуулж газарт буулгах хэрэгтэй. Энэ бол 2,3,4 давхраас буулгахад ашиглаж болох арга юм. Ингэхдээ олс болон орны даавууг цонхны рамаас уяж хэрхэвч болохгүй. Учир нь хүний жингээс хамаараад цонх нурж, цонхны рам хугарч болзошгүй.

Үер: Үерийн аюул тохиолдсон үед сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг яаралтай зогсооно. Хүүхдүүдийг гэр гэрт нь хүргэх эсвэл аюулгүй газар аваачих арга хэмжээг яаралтай авна. Аюултай газраас хүүхдүүдийг нүүлгэн шилжүүлэх шаардлагатай болбол эхний ээлжид бага насны хүүхдүүд, хүүхдийн байгууллага, эмнэлэгт байгаа хүүхдүүдийг зөөвөрлөнө. Хэрэв ийм боломж олдохгүй бол хүүхдүүдийг байшингийн дээд давхрууд, дээвэр рүү гаргах арга хэмжээ авна. Тэндээсээ завь, хөвөх хэрэгсэл, нисдэг тэрэг ашиглан зөөвөрлөх арга хэмжээ авна. Хөвөх хэрэгсэл дээр нэг нэгээрээ, тавцангийн голоор явж гарна. Усны захад ирээд насанд хүрэгчдээс нэг нь хүүхдүүдийг хуурай газар дээр гарч дуустал завь, хөвөх хэрэгслийг барьж байх хэрэгтэй. Онцгой тохиолдолд хүүхэд тус бүрд гарын доорх материал, торх, дүнз, модон самбар, хашааны хугархай, машины дугуй зэрэг барьж болох зүйлийг ашиглахыг зөвлөж тэдний хажууд заавал насанд хүрэгчид байх хэрэгтэй.

Цасан болон шороон шуурга нь маш хүчтэй салхитай, удаан хугацаанд үргэлжилдэг, их хэмжээний эвдэж сүйтгэх хүчтэй байдаг. Хүчтэй хуй салхи нь эвдэж сүйтгэхээс гадна хөнгөн байгууламжийг хийсгэх, багана шонгуудыг унагах, модыг үндсээр нь булгалах, утас, уяануудыг таслах, зам харилцааны шугамыг эвдэх зэрэг хохирлыг учруулдаг. Ус цаг уурын алба эдгээрийг хангалттай урьдчилан тодорхойлж хуй салхины хурд, хүчний тухай урьдчилан анхааруулдаг. Иймд урьдчилан

сэргийлэх мэдээ дамжуулсны дараа хүүхдүүдийг гэр, сургууль, цэцэрлэгээс гаргаж болохгүй. Түүнчлэн хүүхдүүдийг шилний хагархайд өртөхөөс болгоомжилж цонхонд ойртуулахгүй байх хэрэгтэй. Энэ үед хүүхдийг цонхны хоорондох зайд эсвэл коридорт байлгавал сайн. Хуй салхины эрсдэлээс хамгаалахын тулд баг бөх мебель тавилга, бичгийн ширээ, шүүгээ ашиглаж болно. Практикаас үзэхэд хоргодох байр, подвал, зоорь, тоосгон байшингийн нэгдүгээр давхрын дотор талын өрөө тасалгаанууд зэрэг газрууд хамгийн аюулгүй байдаг. Салхи нэг намдаад дахин хүчтэй болдог тул салхины хүч намдангуут гадагш гарч болохгүй. Хэрэв хүчтэй хуй салхи, шуурганы үед гадаа явж байсан бол суваг, шуудуу, замын хажуугийн хонхор, хөдөө газар бол замын ховил зэрэг ямар нэгэн хонхор газар хүүхдээ биедээ наагаад яаралтай хэвтэх хэрэгтэй. Хүүхдийнхээ толгойг цүнх, үүргэвч, хавтас зэрэг хамгийн ойр байгаа гарын доорх материалаар халхалбал зохино. Барилга байгууламжаас аль болох хол байгаарай. Ийм үед хүүхэд гол төлөв шил, шифр болон вааран дээврийн хагархай, дээврийн төмрийн хэсэг, замын тэмдгийн тасархай, фасад болон карнизны хэлтэрхий тагт болон хашлага дотор хадгалагдаж байсан эд зүйлст цохигдон бэртэж гэмтдэг байна. Утас тогтой байж болзошгүй тул тасарсан, унжсан утсанд хүүхэд хүрэхээс болгоомжил. Хүчтэй хуй салхи, шороон болон цасан шуурганы талаар мэдээ авмагц 2-3 хоногийн хүнс, цэвэр усаа базааж, гэрэлтүүлгийн эх үүсвэрээ шийдвэрлэх хэрэгтэй. Тийм нөхцөлд хүүхдэд хоол, хувцас шаардагдана гэдгийг бодолцвол зохино. Мөн эм, ороох боох материал нөөцлөхөө мартав. Салхи шуурганы тухай мэдээлж, тодорхой нөхцөлд хэрхэн яаж ажиллах талаар тайлбарлаж болох тул зурагт, радиогоо байнга асаалттай сонсож байх шаардлагатай.

Дэлхий дахинаа уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн үед хүүхдүүд дараах эрсдэл үүсэх магадлал өндөр байна.

1. Далайн шуурга нэмэгдэж, далайн эргийн үер болж далайн эргийн доогуур бүсүүдэд болон хөгжиж буй жижиг арлын мужуудад амьдарч байгаа иргэдийн хүүхдүүд амь насаа алдах, гэмтэж бэртэх, эрүүл мэнд нь муудах, амьжиргааны эх үүсвэрээ алдах эрсдэл
2. Зарим бүс нутагт эх газрын үерийн улмаас хот суурин газрын олон хүн амын эрүүл мэнд, амь насаа алдсан эрсдэл

3. Цаг агаарын өөрчлөлтөөс болж дэд бүтцийн сүлжээ тасрах, цахилгаан, усан хангамж зэрэг чухал үйлчилгээ зэргээс шалтгаалан системчилсэн эрсдэлүүд.
4. Хэт халуун үед нас баралт, өвчин эмгэгийн эрсдэл
5. Уур амьсгалын өөрчлөлтөөс хэт дулааралтай холбоотой үүссэн гангаас болж хүнсний аюулгүй байдал, хүнсний хомсдолоос учирч болох эрсдэл
6. Ундны ус хүрэлцэхгүй болсноос хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний усжуулалт ашиглах боломжгүйгээс амьжиргааны түвшин, орлого алдагдах эрсдэл
7. Далайн болон эрэг хавийн экосистем алдагдах эрсдэл гэх мэт.

Гамшгийн эрсдэлийг даван туулах чадварыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Бид аюулууд бий болох эх үүсвэр, эрсдэл үзүүлэх нөлөөллийг асуудлын модоор аюулыг бүдүүвчлэн үзүүлэх, зорилтод болгох, эдгээр үүсэх эрсдэлийн даван туулах чадварыг нэмэгдүүлэх асуудлыг хоёрдугаар бүлэгт тусгах болно.

Нэгдүгээр бүлгийн дүгнэлт

Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал ба урьдчилан сэргийлэлт нь осол, гамшгийн үед хүүхдийг үл хайхрах явдал гаргахгүй байх, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаалах зорилгоор урьдчилсан арга хэмжээнүүдийг авсан байхаар ойлгож болохоор байна.

Ингэхдээ иргэдийнхээ амь нас эрүүл мэндийг гамшиг ослоос хамгаалах чиг үүрэгтэй Онцгой байдлын байгууллагын зүгээс гамшгийн үед хүүхэд хамгаалал, урьдчилан сэргийлэх талаар гэр бүлийн гишүүд чухам юуг анхаарах ёстойг мэдээлэх хэрэгтэй байна.

Хүүхэд хамгааллын асуудал зөвхөн гэр бүлийн төдийгүй захиргаа, аж ахуйн нэгж олон нийтийн байгууллагуудын санаа тавих ёстой асуудал гэдгийг бид бас ойлгох хэрэгтэй.

Хүүхэд хамгааллын бүхий л асуудлыг хамарсан цогц, уялдаа холбоотой хууль нь хүүхэд хамгааллын үр дүнтэй тогтолцоог баталгаажуулах хүчирхэг хэрэгсэл. Хүүхэд хамгааллын асуудал нь ялгаатай хэд хэдэн суурь хуулиуд, мөн олон журам, дүрэм, заавар бүхий эрх зүйн хоёрдогч баримт бичгүүдэд тусгагдсан байдаг. Энэ нь хүүхдэд хамгааллын үйлчилгээ хэрэгтэй үед ямар шат дарааллаар, хэрхэн хүргэх талаар үүрэг хүлээгчид тодорхой ойлголт, мэдээлэлтэй байхад хүндрэл үүсгэж байна.

Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудалд аюул, осол, гамшгийн үед хүүхдийг үл хайхрах явдал гаргахгүй байх, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаалах зорилгоор урьдчилсан арга хэмжээнүүд авсан байхыг хэлж болно.

Хүүхэд хамгааллын тухай хууль нь 18-аас доош насны хүүхдэд хамааралтай бөгөөд зөвхөн Монгол Улсын харьяалалтай хүүхдэд уг хууль үйлчлэхээр заасан нь дутагдалтай тал ажиглагдлаа. Энэ нь Монгол Улсад амьдарч буй иргэн бус хүүхдүүд хууль ёсоор болон хууль бусаар оршин сууж буй эсэхээс үл хамааран ямарваа хамгаалалтгүй үлдэнэ гэсэн үг юм. Иймээс эдгээр хүүхдүүдийн хамгааллын асуудлыг эрх зүйн зохицуулалтад тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд “Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг

ойлгоно гэж тусгасан ч хуулийн гуравдугаар бүлэгт “Эрсдэлт нөхцөлд байгаа” хүүхдүүдэд буюу гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээ, үйлчилгээг тусгаж, гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийн талаар нарийвчлан тусгаагүй байна.

Харин “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS 6948:2021” стандарт нь гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн амь насыг аврах, аюулгүй байдлыг хангах, бүх төрлийн дарамт, хүчирхийлэл, үл хайхрах явдал, мөлжлөгөөс хамгаалуулах хүүхдийн эрхийг баталгаажуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зохистой хариу үйлчилгээг хүүхэдтэй хамааралтай асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны шат, шатны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн анги, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийт хамтран зохион байгуулах үйл ажиллагааны зохицуулалт уялдаа холбоог зохицуулагдахаар тусгасан нь гамшгийн үеийн хүүхэд хамгаалалтай холбогдсон харилцаа зохицуулагдаж байна гэж дүгнэлтэд хүрлээ.

НҮБ-ын Хүүхдийн сангаас гамшигт нэрвэгдсэн орнуудад үзүүлэх хүмүүнлэгийн яаралтай арга хэмжээ нь эрүүл мэнд, хоол тэжээл, ус, ариун цэвэр, эрүүл ахуй, хүүхэд хамгаалал, боловсрол зэрэг бүх салбарт өргөн хүрээг хамарч байна. Гэсэн хэдий ч санхүүжилт дутмаг байгаа нь олон оронд хариу арга хэмжээ авахад саад болж байна.

Өнгөрсөн жил хөгжингүй орнууд дасан зохицоход үзүүлэх дэмжлэгийг 2025 он гэхэд жил бүр 40 тэрбум ам.долларт хүргэхээр төлөвлөгдөн ажиллаж байна. Жил бүр 300 тэрбумаас доошгүй доллар хүргэх алхам болгон үүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой үе шатуудыг агуулсан найдвартай аюулын замын зураглал болон 2030 он гэхэд дасан зохицох чадварын талаарх авах арга хэмжээг танилцуулах ёстой. Уур амьсгалын нийт санхүүжилтийн наад зах нь тал хувь нь дасан зохицоход чиглэх ёстой. Иймээс Монгол Улс гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудлыг аюул үүсэх эх үүсвэрийг үнэлэх, түүнээс даван

туулах чадварыг бэхжүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГИЙН ҮЕИЙН ХҮҮХЭД
ХАМГААЛАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ, САЙЖРУУЛАХ АРГА
ЗАМ**

(ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

**§2.1. Хөвсгөл аймгийн хэмжээн дэх гамшгийн үеийн хүүхэд
хамгаалалд хийсэн шинжилгээ**


Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 22 дугаар тушаалаар “Гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэл, гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээний маягт, заавар”-ыг баталсан. Энэхүү маягт, заавар нь геологийн гаралтай, биологийн гаралтай, ус, цаг уурын гаралтай, гал түймэр, хүний үйл ажиллагаатай холбоотой осол гэсэн таван төрөлтэй.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар гамшиг, аюулт үзэгдэл, ослын бүртгэлээс объектын гал түймэр, усны ослыг түүвэрлэн харууллаа.

**Хүснэгт 3. Монгол Улсын
хэмжээнд объектын гал түймрийн
тохиолдлын тоо /Сүүлийн 5 жилээр/**

№	Бүсчлэл	Аймаг	2018 ОН		2019 ОН				2020 ОН				2021 ОН				2022 ОН										
			Эд хараагаа		Нас барсан		Эд хөрөнгө		Аварсан		Эд хөрөнгө		Аварсан		Эд хөрөнгө		Аварсан		Эд хөрөнгө								
			Гал	Байшин	Хүүхэл	Халхал	Гал	Байшин	Халхал	Халхал	Гал	Байшин	Халхал	Халхал	Гал	Байшин	Халхал	Халхал	Гал	Байшин	Хүүхэд	Халхал	Халхал				
1	Баруун бүс	Баян-Өлгий											1	3				1				1					
2		Ховд	1	5		1	1						1			1	1					1					
3		Говь-Алтай																									
4		Завхан					1		2	1			2	1		1											
5		Увс	2			5																					
6	Зүүн бүс	Дорнод				1	2																				
7		Сүхбаатар	1		1				1				1														
8		Хэнтий								1			2	1				2									
9	Өмнөд бүс	Өмнөговь	1	2					1				1														
10		Баянхонгор								2			3	3	1	4		3	1			1					
11		Говьсүмбэр								1				2	1			2									
12		Дорноговь					1	1	1										1			1					
13		Дундговь	1			2	1	1	2	1									1				1				
14		Өвөрхангай	1			1	2	1	2					1				1									
15		Орхон		1		3																					
16	Хойд бүс	Архангай	1		1				1				5	4				1	1	3							
17		Булган	2	1		2	1			2		2	2						1			3					
18		Дархан								4									1			2					
19		Сэлэнгэ	1	2				1	1						1			1		1	3						
20		Хөвсгөл	1			1	2		1	1		1		2	1			1	1				1				
21		Төв	1		1		1	2		1	1		1	1				1									
22	Нийслэл		6	4	7	3	8	1	6	9	2	6	2		3	13	5	5	10	4	5	1		1			
Нийт			19	6	16	8	13	10	11	21	0	12	15	5	2	11	30	14	9	17	4	18	8	3	6	1	1

Эх сурвалж. ОБЕГ-ын мэдээллийн сан



Зураг 3. Сүүлийн 5 жилийн харьцуулалт

Эх сурвалж. ОБЕГ-ын мэдээллийн сан


Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн объектын гал түймрээр нас барсан, аварсан, гэмтсэн хүүхдийн судалгааг зураг 2-т харьцуулан үзүүлээ.

Хүснэгт 4. Монгол Улсын 2018-2022 онд усны осолд өртсөн хүүхдийн судалгаа /Сүүлийн 5 жилээр/

№	Бүсчлэл	Аймаг	2018 он		2019 он		2020 он		2021 он		2022 он	
			Хүүхэд		Хүүхэд		Хүүхэд		Хүүхэд		Хүүхэд	
			Нас барсан	Аварсан	Нас барсан	Аварсан	Нас барсан	Аварсан	Нас барсан	Аварсан	Нас барсан	Аварсан
1	Баруун бүс	Баян-Өлгий	8					1				
2		Ховд	1		2			1				
3		Говь-Алтай					1		1	1		
4		Завхан	1			2			2	5	1	
5		Увс			1			1	1			
6	Зүүн бүс	Дорнод	2				2	3	1		8	
7		Сүхбаатар	2				1					
8		Хэнтий	2				2	4	1	5	1	1
9	Өмнөд бүс	Өмнөговь					2		2			
10		Баянхонгор	1	1			1		2			
11		Говьсүмбэр										
12		Дорноговь	1									
13		Дундговь					2		3			
14	Өвөрхангай	2			1		1	1				
15	Хойд бүс	Орхон							2			
16		Архангай		6					1		1	
17		Булган	1	1			1		2	2		
18		Дархан		2								
19		Сэлэнгэ	1	2	2		1	2	4	3		
20		Хөвсгөл	2				4		5	2		
21		Төв	1	1	1	1			2	3	2	
22	Нийслэл	3	9	2	5	11	10	5	9	8		
	Улсын хэмжээнд	28	22	8	9	29	22	32	32	21	1	


Эх сурвалж. ОБЕГ-ын мэдээллийн сан

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн усны ослоор нас барсан, аварсан хүүхдийн судалгааг хүснэгт 4-т харьцуулан үзүүлээ.



Зураг 4. Усны осолд өртөж нас барсан хүүхдийн тоо

Эх сурвалж. ОБЕГ-ын мэдээллийн сан



Зураг 5. Усны ослоос аварсан хүүхдийн тоо

Эх сурвалж. ОБЕГ-ын мэдээллийн сан

Хүснэгт 5. Хөвсгөл аймагт сүүлийн 5 жилд тохиолдсон аюулт үзэгдэл, гамшиг ослын бүртгэгдсэн байдал

№	Гамшиг ослын төрөл	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Усны осол	9	5	22	18	18
2	Төөрч, сураггүй болсон	6	6	4	2	1
3	Хүний буруутай үйл ажиллагаатай холбогдолтой осол				3	2
4	Объектын гал түймэр	2	4	2	2	1

Эх сурвалж. Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газар



Зураг 6. Гамшиг осолд өртөж нас барсан хүүхдийн шалтгаан

Эх сурвалж. ОБЕГ-ын мэдээллийн сан

Хөвсгөл аймгийн хэмжээнд гамшгийн төрлөөр нь шинжилгээ хийхэд усны осол, гал түймрийн аюулын тоо хамгийн өндөр гарч байна.

Иймд дээрх 2 гамшгийн төрлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, даван туулах чадавхын асуудлыг бэхжүүлэх нь шаардлагатай гэж үзлээ.

Хөвсгөл аймгийн сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн нийт 289 эцэг эх, асран хамгаалагчдаас гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд хийсэн судалгааг google form-оор авч, судалгааг SPSS-25.0 программ ашиглан харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, түүвэрлэх, социологийн болон статистикийн мэдээлэл ашиглах арга, аргачлалыг ашиглан дараах судалгааг боловсруулсан.

Хүснэгт 6. Судалгаанд оролцогчдын хүйсийн ангилал

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	эр	80	27.7	27.7	27.7
	эм	209	72.3	72.3	100.0
	Нийт	289	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 1 дэх асуулт “Судалгаанд оролцогчдын хүйсийн ангилал” асуултад нийт 289 оролцогчоос 80 оролцогч ба 27.7% нь эрэгтэй, 209 ба 72.3% нь эмэгтэй хүн оролцсон байна. Үүнээс үзэхэд дийлэнх масс буюу эмэгтэй хүн гамшгийн үеийн хүүхэд хамгаалалтын талаар сэтгэл зовнилттой харагдаж байна.

Хүснэгт 7. Судалгаанд оролцогчдын насны ангилал

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	18-25 нас	28	9.7	9.7	9.7
	26-35 нас	140	48.4	48.4	58.1
	36-45 нас	81	28.0	28.0	86.2
	46-55 нас	36	12.5	12.5	98.6
	56-аас дээш нас	4	1.4	1.4	100.0
	Нийт	289	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 2 дахь асуулт “Судалгаанд оролцогчдын насны ангилал” асуултад нийт 289 оролцогчоос 28 оролцогч ба 9.7% нь 18-25 нас, 140 ба 48.4% нь 26-35 нас, 81 ба 28.0% нь 36-45 нас, 36 ба 12.5% нь 46-55 нас, 4 ба 1.4% нь 56-аас дээш настай хүмүүс манай энэ судалгаанд хамрагдсан байна. Эндээс 26-35 настай оролцогчид хамгийн өндөр хувь эзэлж байсан бөгөөд гамшгийн үед хүүхдийг хэрхэн хамгаалах талаар мэдлэг муутай байгаа нь батлагдаж байна.

Хүснэгт 8. Судалгаанд оролцогчдын гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаар таны ойлголт хангалттай байдаг уу

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	138	47.8	47.8	47.8
	Үгүй	151	52.2	52.2	100.0
	Нийт	289	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 3 дахь асуулт “Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаар таны ойлголт хангалттай байдаг уу” асуултад нийт 289 оролцогчоос 138 оролцогч ба 47.8% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 151 ба 52.2% нь хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн байна. Судалгаанаас үзэхэд гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх ойлголт хангалтгүй харагдаж байна.

Хүснэгт 9. Судалгаанд оролцогчдын гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээллийг хүүхдэд хэрхэн өгч байна вэ

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтла гдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Сургалтын хөтөлбөрт тусгагдсан	47	16.3	16.3	16.3
	Аюулгүй амьдрахуй үүднээс заадаг	170	58.8	58.8	75.1
	Заадаггүй	49	17.0	17.0	92.0
	Бусад	23	8.0	8.0	100.0
	Нийт	289	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 4 дэх асуулт “Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээллийг хүүхдэд хэрхэн өгч байна вэ” асуултад нийт 289 оролцогчоос 47 оролцогч ба 16.3% нь сургалтын хөтөлбөрт тусгагдсан гэж хариулт өгсөн бол 170 ба 58.8% нь аюулгүй амьдрахуй үүднээс заадаг, 49 ба 17.0% нь заадаггүй, 23 ба 8.0% нь бусад гэж хариулт өгсөн байна.

Хүснэгт 10. Судалгаанд оролцогчдын гамшгийн үеийн хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдсэн гэдэгт итгэж байна уу

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	78	27.0	27.1	27.1
	Үгүй	174	60.2	60.4	87.5
	Бусад	36	12.5	12.5	100.0
	Нийт	288	99.7	100.0	
Хариулаагүй	Систем	1	0.3		
Нийт		289	100.0		

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 5 дахь асуулт “Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдсэн гэдэгт итгэж байна уу” асуултад нийт 289 оролцогчоос 78 оролцогч ба 27.0% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 174 ба 60.2% нь хангалтгүй буюу үгүй, 36 ба 12.5% нь бусад гэсэн хариулт өгсөн байна. Мөн 1 ба 0.3% нь хариулт өгөөгүй байна. Судалгаанаас үзэхэд гамшгийн үеийн хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдсэн талаарх ойлголт хангалтгүй харагдаж байна.

Хүснэгт 11. Судалгаанд оролцогчдын хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн зохицуулалт хангалттай гэж бодож байна уу

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	84	29.1	29.2	29.2
	Үгүй	167	57.8	58.0	87.2
	Бусад	37	12.8	12.8	100.0
	Нийт	288	99.7	100.0	
Хариулаагүй	Систем	1	0.3		

Нийт	289	100.0		
------	-----	-------	--	--

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 6 дахь асуулт “Хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн зохицуулалт хангалттай гэж бодож байна уу” асуултад нийт 289 оролцогчоос 84 оролцогч ба 29.1% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 167 ба 57.8% нь хангалтгүй буюу үгүй, 37 ба 12.8% нь бусад гэсэн хариулт өгсөн байна. Мөн 1 ба 0.3% нь хариулт өгөөгүй байна. Судалгаанаас үзэхэд 167 буюу 57.8% нь үгүй гэсэн хариулт өгснийг харахад хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн зохицуулалтын талаарх ойлголт хангалтгүй харагдаж байна. Ийм учраас гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хуульд гамшгийн үед хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг тусгаж өгөх нь энэхүү судалгаагаар батлагдаж байна.

Хүснэгт 12. Судалгаанд оролцогчдын хүүхдийг гамшгаас хамгаалах талаар сургалт, мэдлэг, мэдээлэл хангалттай авдаг уу

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	83	28.7	28.7	28.7
	Үгүй	167	57.8	57.8	86.5
	Бусад	39	13.5	13.5	100.0
	Хийт	289	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 7 дахь асуулт “Хүүхдийг гамшгаас хамгаалах талаар сургалт, мэдлэг, мэдээлэл хангалттай авдаг уу” асуултад нийт 289 оролцогчоос 83 оролцогч ба 28.7% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 167 ба 57.8% нь хангалтгүй буюу үгүй, 39 ба 13.5% нь бусад гэсэн хариулт өгсөн байна. Судалгаанаас үзэхэд хүүхдийг гамшгаас хамгаалах талаар сургалт, мэдлэг, мэдээлэл хангалтгүй харагдаж байна.

Хүснэгт 13. Судалгаанд оролцогчдын гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө хамгаалах талаар сургалт ордог уу

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
	Тийм	109	37.7	37.7	37.7

Хүчинтэй тоон үзүүлэлт	Үгүй	139	48.1	48.1	85.8
	Бусад	41	14.2	14.2	100.0
	Нийт	289	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 8 дахь асуулт “Гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө хамгаалах талаар сургалт ордог уу” асуултад нийт 289 оролцогчоос 109 оролцогч ба 37.7% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 139 ба 48.1% нь хангалтгүй буюу үгүй, 41 ба 14.2% нь бусад гэсэн хариулт өгсөн байна. Судалгаанаас үзэхэд гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө хамгаалах талаар сургалт ордоггүй болох нь харагдаж байна.

Хүснэгт 14. Судалгаанд оролцогчдын гамшиг болоход хүүхэд өөрийгөө аврах чадвар эзэмшсэн гэж бодож байна уу

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	61	21.1	21.1	21.1
	Үгүй	200	69.2	69.2	90.3
	Бусад	28	9.7	9.7	100.0
	Нийт	289	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 9 дэх асуулт “Гамшиг болоход хүүхэд өөрийгөө аврах чадвар эзэмшсэн гэж бодож байна уу” асуултад нийт 289 оролцогчоос 61 оролцогч ба 21.1% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 200 ба 69.2% нь хангалтгүй буюу үгүй, 28 ба 9.7% нь бусад гэсэн хариулт өгсөн байна. Судалгаанаас үзэхэд гамшиг болоход хүүхэд өөрийгөө аврах чадвар эзэмшээгүй болох нь харагдаж байна.

Хүснэгт 15. Судалгаанд оролцогчдын гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэгийг хүүхдэд хэрхэн хүргэвэл үр дүнтэй вэ

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Хичээл сургалтын төлөвлөгөөнд тусгаж онолын байдлаар	107	37.0	37.0	37.0

	Дадлага сургуулиар	163	56.4	56.4	93.4
	Цахим хуудас ашиглаж	19	6.6	6.6	100.0
	Нийт	289	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 10 дахь асуулт “Гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэгийг хүүхдэд хэрхэн хүргэвэл үр дүнтэй вэ” асуултад нийт 289 оролцогчоос 107 оролцогч ба 37.0% нь хичээл сургалтын төлөвлөгөөнд тусгаж онолын байдлаар гэсэн хариулт өгсөн бол 163 ба 56.4% нь дадлага сургуулиар, 19 ба 6.6% нь цахим хуудас ашиглаж гэсэн хариулт өгсөн байна. Судалгаанаас үзэхэд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэгийг хүүхдэд дадлага сургуулилтаар өгвөл илүү үр дүнтэй харагдаж байна.

Хүснэгт 16. Гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө аврах ур чадварыг хэн эзэмшүүлэх вэ

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Боловсролын байгууллага	124	42.9	42.9	42.9
	Гэр бүлийн гишүүд	74	25.6	25.6	68.5
	Онцгой байдлын байгууллага	91	31.5	31.5	100.0
	Нийт	289	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 11 дэх асуулт “Гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө аврах ур чадварыг хэн эзэмшүүлэх вэ” асуултад нийт 289 оролцогчоос 124 оролцогч ба 42.9% нь боловсролын байгууллага гэсэн хариулт өгсөн бол 74 ба 25.6% нь гэр бүлийн гишүүд, 91 ба 31.5% нь Онцгой байдлын байгууллага гэсэн хариулт өгсөн байна. Судалгаанаас үзэхэд гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө аврах ур чадварыг боловсролын байгууллага өгвөл илүү үр дүнтэй харагдаж байна.

Хүснэгт 17. Гамшигт өртсөн хүүхдийн хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломж байна уу

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	172	59.5	59.5	59.5
	Үгүй	66	22.8	22.8	82.4
	Бусад	51	17.6	17.6	100.0
	Нийт	289	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 12 дахь асуулт “Гамшигт өртсөн хүүхдийн хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломж байна уу” асуултад нийт 289 оролцогчоос 172 оролцогч ба 59.5% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 66 ба 22.8% нь хангалтгүй буюу үгүй, 51 ба 17.6% нь бусад гэсэн хариулт өгсөн байна. Гамшигт өртсөн хүүхдийн хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломж байгааг судалгаанаас харуулж байна.

Хүснэгт 18. Гамшгийн үед хүүхдэд үүсэж болох эмзэг байдлуудын талаар дурдана уу

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Сэтгэл гутрал	108	37.4	37.4	37.4
	Зан төлөвийн доголдол	11	3.8	3.8	41.2
	Гэмтэл	108	37.4	37.4	78.5
	Өвчин	13	4.5	4.5	83.0
	Хүчирхийлэл	3	1.0	1.0	84.1
	Сургууль хоцрох	10	3.5	3.5	87.5
	Нийгмийн харилцаанд оролцохгүй болох	36	12.5	12.5	100.0
	Нийт	289	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 13 дахь асуулт “Гамшгийн үед хүүхдэд үүсэж болох эмзэг байдлуудын талаар дурдана уу” асуултад нийт 289 оролцогчоос 108 оролцогч ба 37.4% сэтгэл гутрал гэсэн хариулт өгсөн бол 11 ба 3.8% нь зан төлөвийн доголдол, 108 ба 37.4% нь гэмтэл, 13 ба 4.5% нь өвчин, 3 ба 1.0% нь хүчирхийлэл, 10 ба 3.5% нь сургууль хоцрох, 36 ба 12.5% нь нийгмийн харилцаанд оролцохгүй болох гэсэн хариулт өгсөн байна. Эндээс манай оролцогчдын ихэнх хувь болох 108 оролцогч сэтгэл гутрал, 108 оролцогч гэмтэл гэж хариулт өгсөн тул гамшгийн үед хүүхдэд энэ төрлийн эмзэг байдлууд ихээхэн тохиолддог нь судалгаанаас харуулж байна.

Хүснэгт 19. Та гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар хүүхдэд мэдээлэл, зөвлөгөө өгдөг үү

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	179	61.9	61.9	61.9
	Үгүй	78	27.0	27.0	88.9
	Бусад	32	11.1	11.1	100.0
	Нийт	289	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 14 дэх асуулт “Та гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар хүүхдэд мэдээлэл, зөвлөгөө өгдөг үү” асуултад нийт 289 оролцогчоос 179 оролцогч ба 61.9% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 78 ба 27.0% нь хангалтгүй буюу үгүй, 32 ба 11.1% нь бусад гэсэн хариулт өгсөн байна.


Хүснэгт 20. Гамшгийн үед хүүхэд хамгааллын талаар мэдээлэл, зөвлөгөө авдаг уу

Үзүүлэлт		Frequency Хэлбэлзэл	Percent Хувь	Valid Percent Хүчинтэй хувь	Cumulative Percent Хуримтлагдсан хувь
Хүчинтэй тоон үзүүлэлт	Тийм	139	48.1	48.1	48.1
	Үгүй	113	39.1	39.1	87.2
	Бусад	37	12.8	12.8	100.0
	Нийт	289	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны SPSS-25.0 шинжилгээний үр дүн

Судалгааны цогц асуумжийн 15 дахь асуулт “Гамшгийн үед хүүхэд хамгааллын талаар мэдээлэл, зөвлөгөө авдаг уу” асуултад нийт 289

оролцогчоос 139 оролцогч ба 48.1% нь хангалттай ба тийм гэсэн хариулт өгсөн бол 113 ба 39.1% нь хангалтгүй буюу үгүй, 37 ба 12.8% нь бусад гэсэн хариулт өгсөн байна. Үүнээс үзэхэд гамшгийн үед хүүхэд хамгааллын талаар мэдээлэл, зөвлөгөө ихэнх тохиолдолд авдаг үзүүлэлт гарч байгаа нь сайшаалтай байна.



Зураг 7. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг эрх зүйн зохицуулалттай харьцуулбал

Энэхүү судалгаагаар гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг эрх зүйн зохицуулалттай харьцуулан авч үзэхэд нийт 288 оролцогч судалгаанд хамрагдахад 113 оролцогч 39.1% нь хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн нь анхаарал татаж байна. Үүнийг харахад гамшгаас хамгаалах тухай хууль, галын аюулгүй байдлын тухай хуульд гамшгийн үед хүүхэд хамгааллын талаар цогц бодлого ороогүй байгаа нь судалгаагаар батлагдаж байна.

**§2.2.Хөвсгөл аймгийн хэмжээн дэх гамшгийн үеийн хүүхэд
хамгааллыг
сайжруулах арга зам**

Хүүхдэд учрах эрсдэл, хор нөлөөнөөс сэргийлж, хамгаалахын тулд байгууллага бүр анхаарлаа хандуулсан эрх зүйн баримт бичгүүд хангалттай боловсруулагдан мөрдөгдөж байна. Үүнд, хүүхэд бүрд аюулгүй, эерэг орчин бүрдүүлэхийн тулд байгууллага, ажилтнууд, сайн дурын идэвхтнүүд болон бусад холбогдох хүмүүс юуг анхаарах ёстойг тусгасан байгаа хэдий ч бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн талаарх асуудал өнөөдөр тодорхой бус байгаа нь харагдаж байна.

Мөн бидний судалгаагаар гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг эрх зүйн зохицуулалттай харьцуулан авч үзэхэд нийт 288 оролцогч судалгаанд хамрагдахад 113 оролцогч 39.1% нь хангалтгүй ба үгүй гэсэн хариулт өгсөн нь анхаарал татаж байна. Үүнийг харахад гамшгаас хамгаалах тухай хууль, галын аюулгүй байдлын тухай хуульд гамшгийн үед хүүхэд хамгааллын талаар цогц бодлого ороогүй байна гэж судалгааны үр дүн гарсан.

Бид хүүхэд хамгааллын талаарх бодлогын баримт бичиг хангалттай боловсруулагдан мөрдөж байгаа хэдий ч хэрэгжилтийн асуудлыг судлахад судалгаа, шинжилгээ, тайлан дутмаг байна. Иймээс бидний гол баримтлах баримт бичиг болох гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021 стандартад шинжилгээ хийж үзлээ.

Хүснэгт 21. Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага
MNS6948:2021 стандартын харьцуулалт

Чиглэл	Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021 стандарт	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө	НҮБ-ын Хүүхдийн сангаас 2022 онд батлагдсан “2022–2025 он хүртэлх Стратегийн төлөвлөгөө”
Зорилго	Энэхүү стандарт нь гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн язгуур эрх ашгийг нэн тэргүүнд тавих, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, эрсдэлд өртсөн хүүхдийн эсэн мэнд, аюулгүй амьдрах, хөгжих, оролцох эрхийг нь тэнцвэртэй хангах, хүүхэд хамгааллын үйлчилгээг гамшгийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний хүрээнд хор хохирол, эрсдэл учруулахгүйгээр үзүүлэх чиглэлээр оролцогч талуудын хүлээх чиг үүрэг, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, зарчим, хамтын ажиллагааны зохицуулалтад тавир босго шаардлагыг тогтооно.	Хүүхэд хамгаалалд зориулсан зардлыг одоогийн хүрсэн түвшнөөс бууруулахгүйгээр цаашид нэмэгдүүлэн, үр дүнд суурилсан санхүүжилтийг олгох, зарцуулалтын үр ашгийг сайжруулах	Хүүхэд багачуудад зориулсан хүрэх үр дүнгийн түвшний өөрчлөлтөд хүрэхийн тулд хөтөлбөр, үйл ажиллагаандаа өөрчлөлтийг тусгасан бичиг баримтыг мөрдлөг болгон, хүүхдийн эндэгдэл, ядуурал, эмзэг байдал, хүйсийн тэгш бус байдал, гадуурхалтын үндсэн шалтгааныг бүх нөхцөлд шийдвэрлэхэд хүүхэд хамгааллын тогтолцооны өөрчлөлтөд анхаарлаа хандуулсан.

<p style="text-align: center;">Ерөнхий Зарчим</p>	<p>Нэгдүгээр зарчим: Эсэн мэнд амьдрахуй ба хөгжил Хоёр дугаар зарчим: Үл ялгаварлал ба тэгш хамааруулалд Гуравдугаар зарчим: Хүүхдийн оролцоо Хүмүүнлэгийн ажилтан гамшгийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний үед хүүхдэд Дөрөвдүгээр зарчим: Хүүхдийн дээд ашиг, сонирхол Тавдугаар зарчим: Хүүхдийн аюулгүй байдал, нэр төр, эрхийг хамгаалж, нэмж хохирол учруулахгүй байх Зургаадугаар зарчим: Хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн тусламжийг ялгаварлан гадуурхалтаас ангид, шударгаар үзүүлэх Долоодугаар зарчим: Бие махбод, сэтгэл санааны хүчирхийлэл, сүрдүүлэг, албадлага болон санаатайгаар бай болгосон хомсдолыг даван туулахад нь хүмүүнд туслах Наймдугаар зарчим: Хүмүүст эрх ашгаа хамгаалахад нь туслах Есдүгээр зарчим: Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх Аравдугаар зарчим: Хүмүүнлэгийн үйл ажиллагааны үед хүүхдийн</p>	<p>- Зорилт, арга хэмжээ нь хүний хөгжлийг дэмжсэн, үл ялгаварлан гадуурхах, жендерийн тэгш байдлыг хангах, хоорондын уялдааг хангасан байх; Бодлогын залгамж чанарыг хадгалсан, нэгдмэл, харилцан уялдаатай байх; Хүн амын хөгжилд иргэний нийгмийн оролцоог идэвхжүүлж, нийгмийн зөвшилцлийг хангасан байх; Төлөвлөгөөний зорилт арга хэмжээг хэрэгжүүлснээр гарах үр дүн, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байх;</p>	<p>Нэгдүгээр зарчим: Эсэн мэнд амьдрахуй ба хөгжил Хоёр дугаар зарчим: Үл ялгаварлал ба тэгш хамааруулалд Гуравдугаар зарчим: Хүүхдийн оролцоо Дөрөвдүгээр зарчим: Хэрэгцээнд нийцсэн тусламжийг ялгаварлан гадуурхалтаас ангид, шударгаар үзүүлэх Тавдугаар зарчим: Хүүхдийн эрх тэгш байдал Зургаадугаар зарчим: хүмүүнлэгийн зарчмууд Долоодугаар зарчим: хүүхэд хамгаалал, даван туулах чадвар</p>
---	--	--	--

	даван туулах чадварыг бэхжүүлэх		
Чиг үүрэг	Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэдэх Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги нь салбарын хэмжээнд гамшиг, онцгой нөхцөн байдлын үеийн хүүхэд хамгааллын удирдлага, зохион байгуулалтыг хангах,гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө гаргах, хүүхэд, гэр бүлд тулгамдсан асуудлыг олж илрүүлэх, шуурхай арга хэмжээ авах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бүх салбар ажилтан алба хаагчдыг хүүхэд хамгааллын чиглэлээр сургаж чадавхжуулах, УОК-ийн шуурхай штабт хүүхдийн асуудлаар санал мэргэжлийн зөвлөгөө өгөх чиг үүрэг хүлээнэ.	1.3.1 Хүүхдийг гэр бүл, нийгмийн ээлтэй орчинд эсэн мэнд, аюулгүй, хүчирхийллээс ангид өсөх нөхцөлийг бүрдүүлэх, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх 1.3.2 Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, төлөвшлийг дэмжих, эцэг, эх, олон нийт, төр, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх 1.3.3 Залуучуудын нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд идэвхтэй оролцож, хөгжилд бодитой хувь нэмэр оруулах таатай орчныг бүрдүүлэх 1.3.4 Залуучуудын идэвхтэй, бүтээлч санаачилгыг дэмжих, ур чадварыг хөгжүүлэх, эерэг хандлагыг төлөвшүүлэх	-Хүүхдийн хүмүүнлэгийн хямрал, эмзэг нөхцөл байдал, -Хүүхэд хамгааллын санхүүжилтийг нэмэгдүүлэх, -Эрх зүйд суурилсан бодлого, хууль тогтоомжийг дэмжих; -Тэгш хүртээмжтэй шаардлагатай хангамж, үйлчилгээг нэмэгдүүлэх; -Хүүхдийн төлөө дэлхий нийтийн түншлэл, хамтын ажиллагааг зохицуулах; -Хүүхдийн талаарх мэдээллийн орчныг өөрчлөх; -Гэр бүл, эцэг эхээ дэмжих; -Нийгмийн зан төлөв, хэм хэмжээнд нөлөөлөх

<p style="writing-mode: vertical-rl; transform: rotate(180deg);">Уялдаа холбоо</p>	<p>Хүмүүнлэгийн үйл ажиллагааны зорилго нь хүүхдийн өөрийнх нь чадавхыг бэхжүүлж, эрсдэлийг бууруулах буюу таслан зогсоож, эрсдэлийг даван туулах, хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэх юм. Хүүхдийн оролцоог хангах нь түүний даван туулах чадварыг бэхжүүлдэг. Хүүхдийн оролцоотой хүмүүнлэгийн хөтөлбөр нь гамшиг, онцгой байдлын үеийн эрсдэлийг даван туулах хүүхдийн чадавхыг бэхжүүлж, эрсдэлийг бууруулан, хүүхэд, гэр бүл, олон нийтийн эерэг харилцааг дэмжинэ.</p>		<p>НҮБ-ын Хүүхдийн сан нь гамшгаас үүдэлтэй аюулыг даван туулахын тулд олон нийт, эрүүл мэндийн дэд бүтцийн чадавхыг бэхжүүлэх, хүмүүнлэгийн хариу арга хэмжээ болон урт хугацааны уур амьсгалд дасан зохицох чиглэлээр хийж буй ажлуудаа улам нягт уялдуулахаар ажиллаж байна.</p>
--	---	--	---

<p style="text-align: center;">Хэн хэрэгжүүлэх</p>	<p>Сум, хорооны хамтарсан баг нь гамшиг дөнгөж эхэлсэн үед иргэд, хүүхдийг авран хамгаалах эрэн хайх үйл ажиллагаанд оролцож буй онцгой байдлын ажилтанд дэмжлэг үзүүлэх, гэр бүлээсээ төөрсөн, тусгаарлагдсан хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх, бүртгэх, аюулгүй газар шилжүүлэн байршуулах, хоол хүнс, ус, түгээх зэрэг ажилд оролцоно. Хүүхэд хамгааллын төрийн болон төрийн бус байгууллага, Олон улсын хүүхэд хамгааллын байгууллага, Онцгой байдлын байгууллага хамтран хэрэгжүүлнэ. Эцэг эхийн үүргийг орлон гүйцэтгэж асран хамгаалагч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн зүгээс хүүхдийн өсөлт хөгжил, зан төлөв, тулгарч буй асуудал, түүнийг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны өөрчлөлтийг хянах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, гарган ажиллахаар тусгасан.</p>	<p>Яамд, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, түүний салбар нэгж, асрамжийн газар, төрийн бус байгууллага, холбоод, олон улсын байгууллага</p>	<p>НҮБ-ын Хүүхдийн сан нь 190 гаруй улс орон, нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж, судалгаа, шинжилгээний нотлох баримт, судалгаа, өгөгдөлд суурилсан олон улсад хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.</p>
--	---	---	---

Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021 стандартад гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхэд төрийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн анги, хүмүүнлэгийн болон хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийтийн хамтын ажиллагааны уялдаа холбоог ханган ажиллах, стандартыг хялбаршуулсан хэлбэрээр сурталчлах, сургалт зохион байгуулах үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжүүлэн ажиллана. Энэ нь гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн язгуур эрх ашгийг нэн тэргүүнд тавих, хүүхдэд учрах сөрөг нөлөөллийг бууруулах, эрсдэлд өртсөн хүүхдийн эсэн мэнд, аюулгүй амьдрах, хөгжих, оролцох эрхийг нь тэнцвэртэй хангах, хүүхэд хамгааллын үйлчилгээг гамшгийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний хүрээнд хор хохирол, эрсдэл учруулахгүйгээр үзүүлэх чиглэлээр оролцогч талуудын хүлээх чиг үүрэг, хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, зарчим, хамтын ажиллагааны зохицуулалтад тавих босго шаардлагыг тогтооно.¹ гэж тусгасан байна.

НҮБ-ын Хүүхдийн сан нь 190 гаруй улс орон, нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж, олон улсад хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байгаа учраас манай улс НҮБ-ын Хүүхдийн сангаас 2022 онд батлагдсан “2022–2025 он хүртэлх Стратегийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангуулж ажиллах нь чухал байна.


Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021 стандартад хүүхдэд тулгарч буй аюул, ослыг олон талаас нь шалтгаан нөхцөл, шийдлийг хамт авч үзэхийн тул хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулах арга хэмжээг дараах аргачлалыг ашиглана гэж тусгасан. Үүнд:

- Аюулыг тодорхойлох, суурь шалтгааныг илрүүлэх
- Хариу арга хэмжээг тухайн нөхцөл байдалд тохируулах
- Орон нутгийн иргэдийн оролцоо, санаачилгыг дэмжих
- Салбар дундын хамтын ажиллагааг хангах
- Урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг зэрэг хэрэгжүүлэх
- Холбогдох бүх талуудтай хамтран ажиллах

¹ Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS6948:2021 стандарт

Иймээс гамшгийн үеийн хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулах арга хэмжээний аргачлалаас аюулыг тодорхойлох, суурь шалтгааныг илрүүлэх, хариу арга хэмжээг тухайн нөхцөл байдалд тохируулахын тулд асуудлын модны загварыг ашиглан, эрсдэл үүсгэх нөлөөллийг гаргахыг оролдлоо.

Гамшгийн аюулууд бий болох эх үүсвэр, эрсдэл үүсгэх нөлөөллийг аюул тус бүрээр зурагт орууллаа.



Зураг 8. Гамшгийн аюулын эх үүсвэр, эрсдэл үзүүлэх нөлөөлөл

Эх сурвалж. Асуудлын модны загварыг ашиглан өөрийн боловсруулсан хувилбар

Дээрх аюулын үед хүүхдэд нөлөөлөх эмзэг байдалд хүргэж байгаа суурь хүчин зүйлүүдэд сэтгэл зүйн эмзэг байдал, бие махбодын эмзэг байдал, боловсролын эмзэг байдлууд бас үүсэхээр байна.

Хүснэгт 22. Хүүхдэд үүсэж болох эмзэг байдал

Сэтгэл зүйн эмзэг байдал	Бие махбодын эмзэг байдал	Боловсролын эмзэг байдал
<ul style="list-style-type: none"> • Сэтгэл гутрал • Сэтгэл гутралын дараах стрессийн синдром • Сэтгэлийн зовнил • Сэтгэлийн зовлон • Өвчний эмгэг • Гомдол • Зан төлөвийн асуудлууд 	<ul style="list-style-type: none"> • Үхэл • Гэмтэл • Өвчин • Хоол тэжээлийн дутагдал • Хит стресс • Бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл 	<ul style="list-style-type: none"> • Сургууль хоцрогдох • Боловсролоо бүрэн гүйцэд эзэмшихгүй байх • Мэдлэг, мэдээлэл дутмаг • Нийгмийн оролцоогүй

Гамшгийн аюулууд бий болох эх үүсвэр, эрсдэл үүсэх нөлөөллийг бууруулах арга зам бол дээрх асуудлын модыг зорилтот болгохоор дэвшүүлж байна. Ингэхийн тулд бид дээрх гамшгийн аюул үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга замыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

НҮБ-ын Хүүхдийн сан нь гамшгаас үүдэлтэй аюулыг даван туулахын тулд олон нийт, эрүүл мэндийн дэд бүтцийн чадавхыг бэхжүүлэх, хүмүүнлэгийн хариу арга хэмжээ болон урт хугацааны уур амьсгалд дасан зохицох чиглэлээр хийж буй ажлуудаа улам нягт уялдуулахаар ажиллаж байна.

Тэгэхээр бид Хөвсгөл аймгийн жишээн дэх гамшгийн аюулын статистик тоо баримтаас харахад объектын гал түймэр, усны осолд өртсөн хүүхдийн судалгаанд хийсэн шинжилгээгээр хамгийн өндөр гарсан 2 гамшгийн төрлүүд дээр даван туулах чадварыг нэмэгдүүлэх үнэлгээ хийж үзвэл:

Хүснэгт 23. Эрсдэлийг даван туулах чадварын үнэлгээ

Аюул	Эрсдэл	Даван туулах чадвар	Нөөц бололцоо
Объектын гал түймэр	Хүүхэд	<ul style="list-style-type: none"> - Анхаарах, сэрэмжээ дээшлүүлэх - Бага насны хүүхдийг асран хамгаалах хүнтэй үлдээх -Хүүхдийн мэдлэгийг дээшлүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Хөршийн холбоо эсвэл иргэдийн нөхөрлөл байгуулах
	Гэр оронгүй болох	<ul style="list-style-type: none"> - Айл өрхүүд цахилгаан монтажаа чанартай утсаар хийх/солих - Цогтой үнс нурмаа галын аюулгүй байдлыг хангасан төмөр сав эсвэл нүхэнд хадгалах -Чүдэнзээр тоглуулахгүй байх 	<ul style="list-style-type: none"> - Хүйтний улиралд ахуйн түймрээс урьдчилан сэргийлэх мэдээ, сануулгыг орон нутгийн болон төвийн телевизийн сувгаар авах - ОБА-ны галын байцаагчаас галын аюулгүй байдлын талаар зөвлөгөө авах - Мэргэжлийн хүнээр цахилгааны монтажаа тавиул, шинэчлэх
	Амьжиргаа	<ul style="list-style-type: none"> - Даван туулах тодорхой арга замыг бий болгох - халамжийн үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> Олон улсын байгууллага, Халамжийн байгууллагаас гэртэй болох болон бусад хэлбэрийн тусалцааг авах


Усны осол	Хүүхэд	<ul style="list-style-type: none"> - Хувь хүн иргэд өөрсдийн нөөц бололцоогоор тусалж үзүүлэх - Гар утсаар усны ослын талаар мэдээллийг хурдан шуурхай дамжуулах - Гол нуурын ойролцоо нутаглаж, амарч зугаалж байгаа бол хараа хяналтаа дээшлүүлэх 	<ul style="list-style-type: none"> - Анхны тусламж үзүүлэх сургалтад хамрагдах - ОБА-ны мэргэжилтэн орон нутгийн засаг захиргаатай хамтарч усны ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх - Усны ослоос авран хамгаалах сургалтад хамруулах - Бага насны хүүхдийг хараа хяналтгүй харгалзах хүнгүйгээр гол нуурын ойролцоо үлдээхгүй байх
	Автомашин	<ul style="list-style-type: none"> - Даван туулах тодорхой арга замыг эрэлхийлэх, мэдлэг олгох, сургалт орох 	<ul style="list-style-type: none"> Урьдчилан сэргийлэх арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах
	Амьжиргаа	<ul style="list-style-type: none"> - Даван туулах тодорхой арга замыг бий болгох, хүүхэд хамгааллын журмыг мөрдүүлэх 	<ul style="list-style-type: none"> Мэргэжлийн байгууллагаас гаргаж байгаа мэдээ мэдээллийг иргэн бүрд богино хугацаанд хүргэх

НҮБ-ын Хүүхдийн сангийн 2022 оны тайланд¹ “өнгөрсөн жил хөгжингүй орнууд дасан зохицоход үзүүлэх дэмжлэгийг 2025 он гэхэд жил бүр 40 тэрбум ам.долларт хүргэхээр төлөвлөгдөн ажиллаж байна. Жил бүр 300 тэрбумаас доошгүй доллар хүргэх алхам болгон үүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой үе шатуудыг агуулсан найдвартай аюулын замын зураглал болон 2030 он гэхэд дасан зохицох чадварын талаарх авах арга хэмжээг танилцуулах ёстой. Уур амьсгалын нийт санхүүжилтийн наад зах нь тал хувь нь дасан зохицоход чиглэх ёстой” гэж тусгасан.

Мөн цаашид бид хүүхэд хамгааллыг сайжруулахын тулд НҮБ-ын Хүүхдийн сангийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан гамшгийн эрсдэл, эмзэг нөхцөл байдалд хүүхэд бүр, түүний дотор өсвөр насныхан: (1) амьд үлдэж, цэцэглэн хөгжиж байх, шим тэжээлтэй хоолны дэглэм, чанартай үндсэн эрүүл мэнд, хүмүүжлийн дадал хэвшилтэй байх зайлшгүй шаардлагатай хангамжууд; (2) ирээдүйд ур чадвартай болоход суралцах, мэдлэг олж авах, эзэмших; (3) хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах, хор хөнөөлтэй үйлдэл, эрсдэлт байдлаас хамгаалагдсан; (4) ус, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан аюулгүй, эрүүл орчинд амьдрах, тэгш хүртээмжтэй шаардлагатай хангамж, үйлчилгээг авах; (5) нийгмийн хамгааллыг хүртэж, ядуурлаас ангид амьдарна гэсэн 5 хүрэх үр дүнг тодорхойлж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах боломжтой гэж үзэж байна.

¹ www.unicef.org/state-worlds-children-2022

Зураг 9. НҮБ-ын Хүүхдийн сангийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөний хүрэх үр дүн



Эх сурвалж. НҮБ-ын Хүүхдийн сангийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөө

Мөн хүүхдийн эндэгдэл, ядуурал, эмзэг байдал, хүйсийн тэгш бус байдал, гадуурхалтын үндсэн шалтгааныг бүх нөхцөлд шийдвэрлэхэд хүүхэд хамгааллын тогтолцооны өөрчлөлтөд анхаарлаа бас хандуулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Хүүхдийн хамгааллын хүмүүнлэгийн хямрал, эмзэг нөхцөл байдал;
- Хүүхэд хамгааллын санхүүжилтийг нэмэгдүүлэх;
- Эрх зүйд суурилсан бодлого, хууль тогтоомжийг дэмжих;
- Тэгш хүртээмжтэй шаардлагатай хангамж, үйлчилгээг нэмэгдүүлэх;

- Хүүхдийн төлөө дэлхий нийтийн түншлэл, хамтын ажиллагааг зохицуулах;
- Хүүхэд хамгааллын талаарх мэдээллийн орчныг өөрчлөх;
- Гэр бүл, эцэг эхээ дэмжих;
- Нийгмийн зан төлөв, хэм хэмжээнд нөлөөлөх.

Мөн Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт “Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүн төвтэй үйл ажиллагааг өргөн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай. Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг үр дүнтэй, үр нөлөөтэй болгохын тулд олон салбарын олон төрлийн аюулыг тооцсон, хүртээмжтэй болгох хэрэгтэй. Удирдан зохицуулах үүрэг, хариуцлага бүхий Засгийн газрууд бодлого, төлөвлөгөө, стандарт боловсруулах, хэрэгжүүлэхдээ эмэгтэйчүүд, хүүхэд, залуус, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ядуу иргэд, шилжин суурьшигсад, нутгийн уугуул иргэд, сайн дурынхан болон ахмадууд, холбогдох бусад талуудын оролцоог хангах хэрэгтэй. Төрийн, хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагууд, академи, шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд нягт хамтран ажиллаж, хамтын ажиллагааны шинэ боломжуудыг бий болгох, бизнесийн үйл ажиллагаандаа гамшгийн эрсдэлийг тооцдог байх шаардлагатай байна; Олон нийтийн онцлог, хэрэгцээ шаардлагыг тусгасан кампанит ажил зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах зэргээр олон нийтийн гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг, мэдээлэл, боловсрол, ойлголтыг дээшлүүлэх үндэсний стратегийг дэмжих;” зэрэг асуудлуудыг тусгасны дагуу хүүхэд хамгааллын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар “Хүүхдэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай” тогтоолоор Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн эрхийн конвенц, Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн үзэл санаатай уялдуулан байгууллага, салбар бүрд мөрдөх Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичгийг боловсруулан батлагдсан байна. Энэ нь байгууллага, хуулийн этгээд нь өөрийн ажил үйлчилгээ болон ажилтан албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийг эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан

сэргийлэх, хамгаалахад хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх асуудлыг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай гэж үзлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах тусламж, дэмжлэг үзүүлэх журам” нь Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан аюулт үзэгдэл, осол болон олон нийтийг хамарсан жагсаал, цуглаан, эмх замбараагүй байдал зэрэг онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд тусламж, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг хангах, хүүхдийн бүх төрлийн дарамт, хүчирхийлэл, үл хайхрах явдал, мөлжлөгөөс хамгаалуулах эрхийг хангахын тулд цаг алдалгүй тусламж, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн, боловсролын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага нь нутгийн захиргааны байгууллага, цагдаа, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар тусгасныг хэрэгжилтийг хангуулан ажиллах шаардлагатай байна.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь үүрэг хүлээнэ

- Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн амь нас, эрүүл байдлыг хангахад орон байр, боловсрол, хоол тэжээл, үндны цэвэр ус, ариун зам, тээврийн үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын санбар дундын уялдаа холбоог хангах, хяналт тавих;
- Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагын тусламж, дэмжлэг, үзүүлэх арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангах.

Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь үүрэг хүлээнэ

- Гамшгаас хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомжийн хүрээнд онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг авран хамгаалах, аюулгүй байдлыг хангах үзүүлэх асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- Онцгой байдлын үед төөрсөн, хаягдсан хүүхдийг эзэн хайх, авран хамгаалах ажлыг шуурхай зохион байгуулах.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ

- Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах бэлэн байдлын төлөвлөгөөтэй байх;
- Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн сурч боловсрох эрхийг хангаж, боловсролын үйлчилгээг тасалдуулахгүй байх;
- Гамшгийн эрсдэлд өртсөн хүүхдийг байрлуулах, асрамжлах байр танхимгаар хангах;
- Хүүхэд эзлэй аюулгүй орчныг бүрдүүлэх.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ

- Онцгой нөхцөл байдлын үед эрүүл мэндийн яаралтай тусламж үзүүлэх;
- Онцгой нөхцөл байдлын үед орчны эрүүл ахуй, халдваргүйжүүлэлтийн ажлыг шуурхай зохион байгуулах;
- Шаардлагатай эрүүл мэндийн үйлчилгээг төлөвлөн, хэрэгжүүлэх;
- Гамшгийн дараахь эрүүл ахуйн эрсдэлийг тодорхойлох, орчны ариун цэврийн үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээ авах.

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь үүрэг хүлээнэ

- Хүүхэд гэр бүлээс тусгаарлагдах, бүх төрлийн хүчирхийлэл, дарамтад өртөхөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулах;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, чадваржуулах;
- Хүүхдийн эрхийг хамгаалах, эрх нь зөрчигдсөн хүүхдэд хамгааллын үйлчилгээ, тусламж, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах;
- Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах зөвлөмж боловсруулж тараах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, олон чийгээр сүтгэлдэх.

Цагдаагийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ

- Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалалтад авах, аюулгүй байдлыг хангах;
- Нийтийн хэв жуурмыг хамгаалах, урьдчилан сэргийлэх.

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ

- Онцгой нөхцөл байдал үүссэн нутаг дэвсгэрт хүүхдийн эрхийг хамгаалах талаар үнэн бодит мэдээлэл, зургалгал гаргах, анхдагч хэрэгцээг шуурхай үнэлж, дэд шатны байгууллаагч мэдээллээр хангах;
- Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг хамгаалах байгууллагын бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн үүрэг гүйцэтгэх;
- Хүүхэд гэр бүлээс тусгаарлагдахаас урьдчилан сэргийлэх, гэр бүлээсээ тусгаарлагдсан хүүхдийг хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд хамруулах;
- Хөгжлийн бархшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх;
- Эрх нь зөрчигдсэн, гэр бүлээс тусгаарлагдсан, хүчирхийлэл,

Орон нутгийн онцгой байдлын хэлтэс, албад дараахь үүрэг хүлээнэ

- Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Онцгой нөхцөл байдлын үед орон нутгийн мэргэжлийн ангийг арга зүй, удирдлагаар хангаж ажиллах;
- Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүүлийн этгээдэд онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг авран хамгаалах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулах.

Нутгийн захиргааны байгууллага дараахь үүрэг хүлээнэ

- Орон нутгийн Засаг дарга онцгой нөхцөл байдлын үед мэргэжлийн ангийг удирдлага, арга зүйгээр хангах;
- Онцгой нөхцөл байдлын үед хүүхэд хамгаалахтай холбогдсон орон нутгийн төсөвт тусгах.

Дотоодын хүмүүнлэгийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ

- Онцгой нөхцөл байдлын үед хүүхдэд анхан шатны тусламж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх;
- Онцгой нөхцөл байдлын үед хүүхдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх;
- Онцгой нөхцөл байдлын үед ажиллах холбогдох байгууллага, мэргэжлийн ангид нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сургалт зохион байгуулах;
- Гамшиг, онцгой нөхцөл байдлын үед тусгаарлагдсан хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, холбон зүүчлэх үйл ажиллагааг зохион байгуулах.

“Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS 6948:2021” стандарт нь гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн амь насыг аврах, аюулгүй байдлыг хангах, бүх төрлийн дарамт, хүчирхийлэл, үл хайхрах явдал, мөлжлөгөөс хамгаалуулах хүүхдийн эрхийг баталгаажуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зохистой хариу үйлчилгээг хүүхэдтэй хамааралтай асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны шат, шатны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн анги, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийт хамтран зохион байгуулах үйл ажиллагааны зохицуулалт уялдаа холбоог хамарна. Мөн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулахад, хүүхэд хамгааллын үйлчилгээний цар хүрээ, чанарын үр дүнг тодорхойлоход, хүүхэд хамгааллын хамтын ажиллагааг зохицуулахад, хүүхэд хамгааллын асуудлаар нөлөөллийн ажлыг зохион байгуулахад, шийдвэр гүйцэтгэгч нарт хүүхэд хамгааллын зарчим, нэн тэргүүний асуудлаар танилцуулга хийхэд, хүмүүнлэгийн бусад салбарын хүүхэд хамгаалах чадавхыг бэхжүүлэх зэрэг асуудлууд гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд оролцож байгаа талууд дотооддоо болон байгууллага хоорондын хамтын ажиллагаанд ашиглах талаар тусгасан байна.

Хүснэгт 24. Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын оролцоо

Хүүхэд хамгааллын баг	Оролцоо, чиг үүрэг
Зохицуулалт хамтын ажиллагаа	Хүүхэд гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дээр Хүүхэд хамгааллын салбар дундын бүлгийг (цаашид Салбар дундын бүлэг гэнэ) байгуулж ажиллуулна. Салбар дундын бүлгийн бүрэлдэхүүнд боловсрол эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, онцгой байдал, цагдаа, нийгмийн халамж, хүүхэд гэр бүл хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, олон улсын, хүмүүнлэгийн болон дотоодын төрийн бус байгууллагын төлөөлөл багтана.
Мэргэжлийн анги	Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги нь онцгой байдлын үед хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн амь насыг аврах, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, осол гэмтэл, хүчирхийлэл, үл хайхралд, мөлжлөгөөс хамгаалах, зохистой хариу арга хэмжээ авах, хүүхдэд ээлтэй орон зай бий болгох гэх мэт хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд салбар дундын хамтын ажиллагааг чиглүүлэн зохион байгуулна.

Хамтарсан багийн
үүрэг оролцоо

Сум хорооны хамтарсан баг нь гамшиг дөнгөж эхэлсэн үед иргэд, хүүхдийг авран хамгаалах эрэн хайх үйл ажиллагаанд оролцож буй онцгой байдлын ажилтанд дэмжлэг үзүүлэх, гэр бүлээсээ төөрсөн, тусгаарлагдсан хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх, бүртгэх аюулгүй газар шилжүүлэн байршуулах, хоол хүнс, ус, түгээх зэрэг ажилд оролцоно.

“Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS 6948:2021” стандартад гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээг хүүхэдтэй хамааралтай асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны шат, шатны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн анги, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийт хамтран зохион байгуулах үйл ажиллагааны зохицуулалт уялдаа холбоог зааж өгсөн хэдий ч хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид хамааралтай заалт байхгүй байна.

2022 оны 1 дүгээр сарын 1-с мөрдөгдөх Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар байнгын асаргаатай хүүхдээ асарч байгаа эцэг, эх тодорхой хэмжээний хөнгөлөлт эдлүүлэх, ажил олгогч нь ажилтны хүүхдэд ээлтэй, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх зэрэг шинэ заалтууд тусгагдсан хэдий ч хүүхэд хамгаалалд чухал үүрэг гүйцэтгэгч эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээ, чиг үүргийг тусгаж өгсөн нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Цаашид гамшиг болохоос өмнө гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг шат дараалан зохион байгуулж, хүүхэд хамгаалалд оролцогчдын чадавхыг бэхжүүлэх, эрсдэлийг бууруулах буюу таслан зогсоох, эрсдэлийг даван туулах, хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлэх явдал юм. Мөн хүүхдийн хамгааллын оролцоог хангаснаар даван туулах чадварыг бэхжүүлдэг. Энэ нь эрсдэлийг даван туулах чадвартай, эрхээ мэддэг, оролцооны аргад суралцсан, мэдээллийг олж авах, ашиглах чадвартай, гамшгийн талаарх мэдлэг, мэдээлэлтэй эцэг эх, асран хамгаалагчид, баг, бүрэлдэхүүнийг бий болгох боломж бүрэлдэнэ.

Хоёрдугаар бүлгийн дүгнэлт

Хөвсгөл аймгийн хэмжээн дэх гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд хийсэн шинжилгээний үр дүнд дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

1. Хөвсгөл аймгийн хэмжээнд гамшгийн төрлөөр нь сүүлийн 5 жилийн байдлаар гамшиг, аюулт үзэгдэл, ослын статистик, тоо мэдээлэлд шинжилгээ хийхэд усны осол, гал түймрийн аюулын тоо хамгийн өндөр гарч байна. Иймд дээрх 2 гамшгийн төрлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, даван туулах чадавхын асуудлыг бэхжүүлэх нь шаардлагатай гэж үзээд эрсдэл үүсэх нөлөөллийг гаргаж, түүнээс даван туулах чадварын үнэлгээ хийсэн.
2. Хөвсгөл аймгийн сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн нийт 289 эцэг эх, асран хамгаалагчдаас гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд хийсэн судалгааг google form-оор авч, судалгааг SPSS-25.0 программ ашиглан судалгааг нэгтгэн үзэхэд гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх ойлголт хангалтгүй, гамшгийн үеийн хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдсэн талаарх ойлголт хангалтгүй, хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн зохицуулалтын талаарх ойлголт хангалтгүй бөгөөд гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хуульд гамшгийн үед хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг тусгаж өгөөгүй гэж судалгааны дүн гарсан учраас хүүхэд хамгааллын талаарх стандарт, стратегийн бодлогын баримт бичгийг олон улсын стратеги төлөвлөгөөтэй харьцуулалт хийсэн.
3. Гамшгийн үед хүүхдэд үүсэж болох эмзэг байдлуудын талаар дурдана уу гэсэн асуултад 37.4% сэтгэл гутрал, 3.8% нь зан төлөвийн доголдол, 37.4% нь гэмтэл, 4.5% нь өвчин, 1.0% нь хүчирхийлэл, 3.5% нь сургууль хоцрох, 12.5% нь нийгмийн харилцаанд оролцохгүй болох гэсэн хариулт өгсөн байна. Үүнийг ашиглан гамшгийн үеийн хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулах арга хэмжээний аргачлалаас аюулыг тодорхойлох, суурь шалтгааныг илрүүлэх, хариу арга хэмжээг тухайн нөхцөл байдалд тохируулахын тулд асуудлын модны загварыг ашиглан, эрсдэл үүсгэх нөлөөллийг гаргахыг оролдлоо. Мөн хүүхдэд нөлөөлөх эмзэг байдалд хүргэж байгаа суурь хүчин зүйлүүдэд

сэтгэл зүйн эмзэг байдал, бие махбодын эмзэг байдал, боловсролын эмзэг байдлууд бас үүсэхээр байна гэж үзлээ.

Хөвсгөл аймгийн хэмжээн дэх гамшгийн үеийн хүүхэд хамгааллыг сайжруулах арга замыг тодорхойллоо. Үүнд:

1. НҮБ-ын Хүүхдийн сан нь гамшгаас үүдэлтэй аюулыг даван туулахын тулд олон нийт, эрүүл мэндийн дэд бүтцийн чадавхыг бэхжүүлэх, хүмүүнлэгийн хариу арга хэмжээ болон урт хугацааны уур амьсгалд дасан зохицох чиглэлээр хийж буй ажлуудаа улам нягт уялдуулан ажилладгаас гадна аюулын замын зураглал болон 2030 он гэхэд дасан зохицох чадварын талаарх авах арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлэх гэж тусгасны адилаар бид Хөвсгөл аймагт тохиолдох болзошгүй гамшгийн аюулыг даван туулах чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзлээ.
2. НҮБ-ын Хүүхдийн сангийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан гамшгийн эрсдэл, эмзэг нөхцөл байдалд хүүхэд бүр, түүний дотор өсвөр насныхан: (1) амьд үлдэж, цэцэглэн хөгжиж байх, шим тэжээлтэй хоолны дэглэм, чанартай үндсэн эрүүл мэнд, хүмүүжлийн дадал хэвшилтэй байх зайлшгүй шаардлагатай хангамжууд; (2) ирээдүйд ур чадвартай болоход суралцах, мэдлэг олж авах, эзэмших; (3) хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах, хор хөнөөлтэй үйлдэл, эрсдэлт байдлаас хамгаалагдсан; (4) ус, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан аюулгүй, эрүүл орчинд амьдрах, тэгш хүртээмжтэй шаардлагатай хангамж, үйлчилгээг авах; (5) нийгмийн хамгааллыг хүртэж, ядуурлаас ангид амьдарна гэсэн 5 хүрэх үр дүнг манай улс хүүхэд хамгааллын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах боломжтой гэж үзэж байна.
3. Хүүхдийн эндэгдэл, ядуурал, эмзэг байдал, хүйсийн тэгш бус байдал, гадуурхалтын үндсэн шалтгааныг бүх нөхцөлд шийдвэрлэхэд хүүхэд хамгааллын тогтолцооны өөрчлөлтөд анхаарлаа бас хандуулах шаардлагатай ба хүүхдийн хамгааллын хүмүүнлэгийн хямрал, эмзэг нөхцөл байдал; хүүхэд хамгааллын санхүүжилтийг нэмэгдүүлэх; эрх зүйд суурилсан бодлого, хууль тогтоомжийг дэмжих; тэгш хүртээмжтэй шаардлагатай хангамж,

үйлчилгээг нэмэгдүүлэх; хүүхдийн төлөө дэлхий нийтийн түншлэл, хамтын ажиллагааг зохицуулах; хүүхэд хамгааллын талаарх мэдээллийн орчныг өөрчлөх; гэр бүл, эцэг эхээ дэмжих; нийгмийн зан төлөв, хэм хэмжээнд нөлөөлөх гэсэн хүүхэд хамгааллын тогтолцооны өөрчлөлтийг нэвтрүүлж ажиллах шаардлагатай гэж үзлээ.

4. Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээг хүүхэдтэй хамааралтай асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны шат, шатны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн анги, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийт хамтран зохион байгуулах үйл ажиллагааны зохицуулалт уялдаа холбоог зааж өгсөн хэдий ч хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид хамааралтай заалт байхгүй байна. Иймд хүүхэд хамгаалалд чухал үүрэг гүйцэтгэгч эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээ, чиг үүргийг тусгаж өгсөн нарийвчилсан зохицуулалтыг тусгах гэсэн саналтай байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудалд аюул, осол, гамшгийн үед хүүхдийг үл хайхрах явдал гаргахгүй байх, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаалах зорилгоор урьдчилсан арга хэмжээнүүд авсан байхыг хэлж болно.

Хүүхэд хамгааллын тухай хууль нь 18-аас доош насны хүүхдэд хамааралтай бөгөөд зөвхөн Монгол Улсын харьяалалтай хүүхдэд уг хууль үйлчлэхээр заасан нь дутагдалтай тал ажиглагдлаа. Энэ нь Монгол Улсад амьдарч буй иргэн бус хүүхдүүд хууль ёсоор болон хууль бусаар оршин сууж буй эсэхээс үл хамааран ямарваа хамгаалалтгүй үлдэнэ гэсэн үг юм. Иймээс эдгээр хүүхдүүдийн хамгааллын асуудлыг эрх зүйн зохицуулалтад тусгах шаардлагатай гэж үзлээ.

Хүүхэд хамгааллын тухай хуульд “Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг ойлгоно гэж тусгасан ч хуулийн гуравдугаар бүлэгт “Эрсдэлт нөхцөлд байгаа” хүүхдүүдэд буюу гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээ, үйлчилгээг тусгаж, гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийн талаар нарийвчлан тусгаагүй байна.

Харин “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS 6948:2021” стандарт нь гамшиг, онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн амь насыг аврах, аюулгүй байдлыг хангах, бүх төрлийн дарамт, хүчирхийлэл, үл хайхрах явдал, мөлжлөгөөс хамгаалуулах хүүхдийн эрхийг баталгаажуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зохистой хариу үйлчилгээг хүүхэдтэй хамааралтай асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны шат, шатны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн анги, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийт хамтран зохион байгуулах үйл ажиллагааны зохицуулалт уялдаа холбоог

зохицуулагдахаар тусгасан нь гамшгийн үеийн хүүхэд хамгаалалтай холбогдсон харилцаа зохицуулагдаж байна гэж дүгнэлтэд хүрлээ.

НҮБ-ын Хүүхдийн сангаас гамшигт нэрвэгдсэн орнуудад үзүүлэх хүмүүнлэгийн яаралтай арга хэмжээ нь эрүүл мэнд, хоол тэжээл, ус, ариун цэвэр, эрүүл ахуй, хүүхэд хамгаалал, боловсрол зэрэг бүх салбарт өргөн хүрээг хамарч байна. Гэсэн хэдий ч санхүүжилт дутмаг байгаа нь олон оронд хариу арга хэмжээ авахад саад болж байна.

Өнгөрсөн жил хөгжингүй орнууд дасан зохицоход үзүүлэх дэмжлэгийг 2025 он гэхэд жил бүр 40 тэрбум ам.долларт хүргэхээр төлөвлөгдөн ажиллаж байна. Жил бүр 300 тэрбумаас доошгүй доллар хүргэх алхам болгон үүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой үе шатуудыг агуулсан найдвартай аюулын замын зураглал болон 2030 он гэхэд дасан зохицох чадварын талаарх авах арга хэмжээг танилцуулах ёстой. Уур амьсгалын нийт санхүүжилтийн наад зах нь тал хувь нь дасан зохицоход чиглэх ёстой.

Иймээс Монгол Улс гамшгийн үеийн хүүхэд хамгааллын асуудлыг аюул үүсэх эх үүсвэрийг үнэлэх, түүнээс даван туулах чадварыг бэхжүүлэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд хийсэн шинжилгээний үр дүнд дараах дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

- Хөвсгөл аймгийн хэмжээнд гамшгийн төрлөөр нь сүүлийн 5 жилийн байдлаар гамшиг, аюулт үзэгдэл, ослын статистик, тоо мэдээлэлд шинжилгээ хийхэд усны осол, гал түймрийн аюулын тоо хамгийн өндөр гарч байна. Иймд дээрх 2 гамшгийн төрлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, даван туулах чадавхын асуудлыг бэхжүүлэх нь шаардлагатай гэж үзээд эрсдэл үүсэх нөлөөллийг гаргаж, түүнээс даван туулах чадварын үнэлгээ хийсэн.
- Хөвсгөл аймгийн сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн нийт 289 эцэг эх, асран хамгаалагчдаас гамшгийн үеийн хүүхэд хамгаалалд хийсэн судалгааг google form-оор авч, судалгааг SPSS-25.0 программ ашиглан судалгааг нэгтгэн үзэхэд гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх ойлголт хангалтгүй, гамшгийн үеийн хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдсэн талаарх ойлголт хангалтгүй,

хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн зохицуулалтын талаарх ойлголт хангалтгүй бөгөөд гамшгаас хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хуульд гамшгийн үед хүүхэд хамгааллын талаарх ойлголтыг тусгаж өгөөгүй гэж судалгааны дүн гарсан учраас хүүхэд хамгааллын талаарх стандарт, стратегийн бодлогын баримт бичгийг олон улсын стратеги төлөвлөгөөтэй харьцуулалт хийсэн.

- Гамшгийн үед хүүхдэд үүсэж болох эмзэг байдлуудын талаар дурдана уу гэсэн асуултад 37.4% сэтгэл гутрал, 3.8% нь зан төлөвийн доголдол, 37.4% нь гэмтэл, 4.5% нь өвчин, 1.0% нь хүчирхийлэл, 3.5% нь сургууль хоцрох, 12.5% нь нийгмийн харилцаанд оролцохгүй болох гэсэн хариулт өгсөн байна. Үүнийг ашиглан гамшгийн үеийн хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулах арга хэмжээний аргачлалаас аюулыг тодорхойлох, суурь шалтгааныг илрүүлэх, хариу арга хэмжээг тухайн нөхцөл байдалд тохируулахын тулд асуудлын модны загварыг ашиглан, эрсдэл үүсгэх нөлөөллийг гаргахыг оролдлоо. Мөн хүүхдэд нөлөөлөх эмзэг байдалд хүргэж байгаа суурь хүчин зүйлүүдэд сэтгэл зүйн эмзэг байдал, бие махбодын эмзэг байдал, боловсролын эмзэг байдлууд бас үүсэхээр байна гэж үзлээ.

Хөвсгөл аймгийн хэмжээнд гамшгийн үеийн хүүхэд хамгааллыг сайжруулах арга замыг тодорхойллоо. Үүнд:

- НҮБ-ын Хүүхдийн сан нь гамшгаас үүдэлтэй аюулыг даван туулахын тулд олон нийт, эрүүл мэндийн дэд бүтцийн чадавхыг бэхжүүлэх, хүмүүнлэгийн хариу арга хэмжээ болон урт хугацааны уур амьсгалд дасан зохицох чиглэлээр хийж буй ажлуудаа улам нягт уялдуулан ажилладгаас гадна аюулын замын зураглал болон 2030 он гэхэд дасан зохицох чадварын талаарх авах арга хэмжээний санхүүжилтийг нэмэгдүүлэх гэж тусгасны адилаар бид Хөвсгөл аймагт тохиолдох болзошгүй гамшгийн аюулыг даван туулах чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзлээ.
- НҮБ-ын Хүүхдийн сангийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан гамшгийн эрсдэл, эмзэг нөхцөл байдалд хүүхэд бүр, түүний дотор өсвөр насныхан: (1) амьд үлдэж, цэцэглэн хөгжиж байх, шим тэжээлтэй хоолны дэглэм,

чанартай үндсэн эрүүл мэнд, хүмүүжлийн дадал хэвшилтэй байх зайлшгүй шаардлагатай хангамжууд; (2) ирээдүйд ур чадвартай болоход суралцах, мэдлэг олж авах, эзэмших; (3) хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрах, хор хөнөөлтэй үйлдэл, эрсдэлт байдлаас хамгаалагдсан; (4) ус, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан аюулгүй, эрүүл орчинд амьдрах, тэгш хүртээмжтэй шаардлагатай хангамж, үйлчилгээг авах; (5) нийгмийн хамгааллыг хүртэж, ядуурлаас ангид амьдарна гэсэн 5 хүрэх үр дүнг манай улс хүүхэд хамгааллын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах боломжтой гэж үзэж байна.

- Хүүхдийн эндэгдэл, ядуурал, эмзэг байдал, хүйсийн тэгш бус байдал, гадуурхалтын үндсэн шалтгааныг бүх нөхцөлд шийдвэрлэхэд хүүхэд хамгааллын тогтолцооны өөрчлөлтөд анхаарлаа бас хандуулах шаардлагатай ба хүүхдийн хамгааллын хүмүүнлэгийн хямрал, эмзэг нөхцөл байдал; хүүхэд хамгааллын санхүүжилтийг нэмэгдүүлэх; эрх зүйд суурилсан бодлого, хууль тогтоомжийг дэмжих; тэгш хүртээмжтэй шаардлагатай хангамж, үйлчилгээг нэмэгдүүлэх; хүүхдийн төлөө дэлхий нийтийн түншлэл, хамтын ажиллагааг зохицуулах; хүүхэд хамгааллын талаарх мэдээллийн орчныг өөрчлөх; гэр бүл, эцэг эхээ дэмжих; нийгмийн зан төлөв, хэм хэмжээнд нөлөөлөх гэсэн хүүхэд хамгааллын тогтолцооны өөрчлөлтийг нэвтрүүлж ажиллах шаардлагатай гэж үзлээ.
- Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээг хүүхэдтэй хамааралтай асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны шат, шатны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн анги, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэд, олон нийт хамтран зохион байгуулах үйл ажиллагааны зохицуулалт уялдаа холбоог зааж өгсөн хэдий ч хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид хамааралтай заалт байхгүй байна. Иймд хүүхэд хамгаалалд чухал үүрэг гүйцэтгэгч эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээ, чиг үүргийг

тусгаж өгсөн нарийвчилсан зохицуулалтыг тусгах гэсэн саналтай
байна.

САНАЛ

Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын эрх зүйн зохицуулалтад шинжилгээ хийж дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хүүхэд хамгааллын тухай хуульд “Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг ойлгоно гэж тусгасан ч хуулийн гуравдугаар бүлэгт “Эрсдэлт нөхцөлд байгаа” хүүхдүүдэд буюу гэмт хэргийн хохирогч болсон, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон, ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээ, үйлчилгээг тусгаж, гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийн талаар нарийвчлан тусгах;
2. Хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг хангах тогтолцоонд салбар хоорондын хамтын ажиллагааны зохицуулалтыг нарийвчлан тусгах, хэрэгжилтийг хангуулах;
3. Хүүхэд хамгаалалд чухал үүрэг гүйцэтгэгч эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээ, чиг үүргийг тусгах.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол Улсын хууль, тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992
- Боловсролын тухай хууль. 2002
- Гэр бүлийн тухай хууль. 1999
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. 2017
- Монгол Улсын Иргэний хууль. 2002
- Олон улсын гэрээний тухай хууль. 2016
- Хөдөлмөрийн тухай хууль. 2021

Олон улсын гэрээ

- Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц. 1930
- Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенц. 1957
- Дарамт, хүчирхийллийг устгах тухай 190 дүгээр конвенц. 2019
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт. 1966
- Олон улсын гэрээний тухай Венийн конвенц. 1969
- Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дүгээр конвенц. 1983
- Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенц. 1973
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай 122 дугаар конвенц,
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1946
- Хүүхдийн эрхийн тухай конвенц. 1989
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 182 дугаар конвенц. 1999
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай 87 дугаар конвенц. 1948
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт. 1966

УИХ, ЗГ-ын тогтоол, бодлогын баримт бичиг

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого (2016-2026)

Ном, сурах бичиг, гарын авлага:

М.Мөнхбат. Олон улсын гэрээний эрх зүй. Уб., 2017

С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. Уб., 2007

Ч.Нямсүрэн. Эрх зүйн онол. Уб., 2017

ОУХБ. Тоглоомын дүрэм. Уб., 2019

ОУХБ. ОУХБ-ын конвенц, зөвлөмжүүдийн эмхэтгэл. Уб., 2012

ОУХБ. Зохистой хөдөлмөрийг дэмжиж 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь. Уб., 2019

Цахим эх сурвалж

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=1214>

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=10259>

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=1192>

https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_norm/relconf/documents/meetingdocument/wcms_712057.pdf

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=10260>

<https://president.mn/24595/>

www.1212.mn

www.unicef.org

www.unicef.org/state-worlds-children-2022

1. Тийм 2. Үгүй 3.

Бусад.....

Асуулт 7. Хүүхдийг гамшгаас хамгаалах талаар сургалт, мэдлэг, мэдээлэл хангалттай авдаг уу?

1. Тийм 2. Үгүй 3.

Бусад.....

Асуулт 8. Гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө хамгаалах талаар сургалт ордог уу?

1. Тийм 2. Үгүй 3.

Бусад.....

Асуулт 9. Гамшиг болоход хүүхэд өөрийгөө аврах чадвар эзэмшсэн гэж Та бодож байна уу?

1. Тийм 2. Үгүй 3.

Бусад.....

Асуулт 10. Гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэгийг хүүхдэд хэрхэн хүргэвэл үр дүнтэй вэ?

1. Тийм 2. Үгүй 3.

Бусад.....

Асуулт 11. Гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө аврах ур чадварыг хэн эзэмшүүлэх вэ?

1. Тийм 2. Үгүй 3.

Бусад.....

Асуулт 12. Гамшигт өртсөн хүүхдийн хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломж байна уу? /Гал түймэрт өртсөн тохиолдолд гэр оронтой болгох, хүнс өгөх...../

1. Тийм 2. Үгүй 3.

Бусад.....

Асуулт 13. Гамшгийн үед хүүхдэд үүсэж болох эмзэг байдлуудын талаар дурдана уу?

1. Сэтгэл гутрал 2. Зан төлөвийн доголдол 3. Гэмтэл 4. Өвчин
5. Хүчирхийлэл 6. Сургууль хоцрох 7. Нийгмийн харилцаанд оролцохгүй болох 8. Бусад

Асуулт 14. Та гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар хүүхдэд мэдээлэл, зөвлөгөө өгдөг үү? 1. Тийм 2. Үгүй
3. Бусад.....

Асуулт 15. Гамшгийн үед хүүхэд хамгааллын талаар мэдээлэл, зөвлөгөө авдаг уу?

1. Тийм 2. Үгүй 3.
Бусад.....

Баярлалаа танд

		Таны хүйс:	Таны нас	Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаар таны ойлголт хангалттай байна уу?	Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээллийг хүүхэд хэрхэн өгч байна вэ?	Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдсэн гэдэгт итгэж байна уу?	Хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн зөмбүүлэлт хангалттай гэж болох байна уу?	Хүүхдийг гамшгаас хамгаалах талаар сургалт, мэдээт, мэдээлэл хангалттай авдаг уу?	Гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө хамгаалах талаар сургалт ордог уу?	Гамшиг болоход хүүхэд өөрийгөө аврах чадвар эзэмшсэн гэж Та бодож байна уу?	Гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээллийг хүүхэд хэрхэн хүргэвэл үр дүнтэй вэ?	Гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө аврах үр чадварыг хэн эзэмшүүрх вэ?	Гамшигт өрсөн хүүхдийн хамгааллын асуудлыг дотлоор нь шийдвэрлэх болохыг байна уу? Гал түншэрт өрсөн тохиолдолд гэр орлогон болгох, хүрс өгөх гэх мэт /	Гамшгийн үед хүүхэд үүсэж болох эмэгт байдлуудын талаар дурдана уу?	Та гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар хүүхэд мэдээлэл, зөвлөгөө өгдөг үү?	Гамшгийн үед хүүхэд хамгааллын талаар мэдээлэл зөвлөгөө авдаг уу?
Таны хүйс:	Pearson Correlation	1	.175*	0.012	-0.095	0.030	0.012	-0.014	-0.043	0.012	0.114	-0.055	0.115	0.049	-.132*	-0.025
	Sig. (2-tailed)		0.003	0.834	0.106	0.617	0.844	0.807	0.462	0.835	0.053	0.347	0.050	0.404	0.025	0.674
	N	289	289	289	289	288	288	289	289	289	289	289	289	289	289	289
Таны нас	Pearson Correlation	.175**	1	-.123*	-0.078	0.013	-0.035	-0.100	-0.068	-0.089	0.052	-0.011	0.068	-0.038	-.133*	-0.066
	Sig. (2-tailed)	0.003		0.037	0.184	0.830	0.549	0.088	0.250	0.129	0.381	0.855	0.249	0.525	0.023	0.265
	N	289	289	289	289	288	288	289	289	289	289	289	289	289	289	289
Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаар таны ойлголт хангалттай байна уу?	Pearson Correlation	0.012	-.123*	1	0.113	.262**	.362**	.362**	.270**	.258**	0.047	-.217**	.163**	-0.085	.220**	.282**
	Sig. (2-tailed)	0.834	0.037		0.054	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.426	0.000	0.005	0.150	0.000	0.000
	N	289	289	289	289	288	288	289	289	289	289	289	289	289	289	289
Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээллийг хүүхэд хэрхэн өгч байна вэ?	Pearson Correlation	-0.095	-.078	0.113	1	0.028	.117*	.127*	.253**	.117*	0.020	0.049	0.086	0.103	.175**	.157**
	Sig. (2-tailed)	0.106	0.184	0.054		0.640	0.047	0.031	0.000	0.047	0.740	0.410	0.146	0.079	0.003	0.007
	N	289	289	289	289	288	288	289	289	289	289	289	289	289	289	289
Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдсэн гэдэгт итгэж байна уу?	Pearson Correlation	0.030	0.013	.262**	0.028	1	.435**	.346**	.209**	.325**	.118*	0.020	.239**	0.023	.204**	.230**
	Sig. (2-tailed)	0.617	0.830	0.000	0.640		0.000	0.000	0.000	0.000	0.046	0.733	0.000	0.697	0.000	0.000
	N	288	288	288	288	288	288	288	288	288	288	288	288	288	288	288

Хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн зохицуулалт хангалттай гэж бодож байна уу?	Pearson Correlation	0.012	-0.035	.362**	.117*	.435**	1	.392**	.251**	.383**	0.006	-0.010	.196**	0.057	.179**	.171**
	Sig. (2-tailed)	0.844	0.549	0.000	0.047	0.000		0.000	0.000	0.000	0.919	0.865	0.001	0.334	0.002	0.004
	N	288	288	288	288	288	288	288	288	288	288	288	288	288	288	288
Хүүхдийг гамшгаас хамгаалах талаар сургалт, мэдлэг, мэдээлэл хангалттай авдаг уу?	Pearson Correlation	-0.014	-0.100	.362**	.127*	.346**	.392**	1	.424**	.302**	0.052	-0.077	.125*	0.033	.196**	.177**
	Sig. (2-tailed)	0.807	0.088	0.000	0.031	0.000	0.000		0.000	0.000	0.375	0.192	0.034	0.579	0.001	0.003
	N	289	289	289	289	288	288	289	289	289	289	289	289	289	289	289
Гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө хамгаалах талаар сургалт ордог уу?	Pearson Correlation	-0.043	-0.068	.270**	.253**	.209**	.251**	.424**	1	.330**	0.046	-0.088	.201**	-0.021	.307**	.372**
	Sig. (2-tailed)	0.462	0.250	0.000	0.000	0.000	0.000	0.000		0.000	0.437	0.137	0.001	0.728	0.000	0.000
	N	289	289	289	289	288	288	289	289	289	289	289	289	289	289	289
Гамшиг болоход хүүхэд өөрийгөө аврах чадвар эзэмшсэн гэж Та бодож байна уу?	Pearson Correlation	0.012	-0.089	.258**	.117*	.325**	.383**	.302**	.330**	1	0.032	0.046	.249**	-0.003	.262**	.250**
	Sig. (2-tailed)	0.835	0.129	0.000	0.047	0.000	0.000	0.000	0.000		0.587	0.432	0.000	0.962	0.000	0.000
	N	289	289	289	289	288	288	289	289	289	289	289	289	289	289	289
Гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэгийг хүүхэд хэрхэн хүргэвэл үр дүнтэй вэ?	Pearson Correlation	0.114	0.052	0.047	0.020	.118*	0.006	0.052	0.046	0.032	1	0.055	0.032	0.020	-0.041	-0.017
	Sig. (2-tailed)	0.053	0.381	0.426	0.740	0.046	0.919	0.375	0.437	0.587		0.352	0.591	0.737	0.488	0.767
	N	289	289	289	289	288	288	289	289	289	289	289	289	289	289	289
Гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө аврах үр чадварыг хэн эзэмшүүлэх вэ?	Pearson Correlation	-0.055	-0.011	-.217**	0.049	0.020	-0.010	-0.077	-0.088	0.046	0.055	1	0.001	0.111	-0.040	-0.097
	Sig. (2-tailed)	0.347	0.855	0.000	0.410	0.733	0.865	0.192	0.137	0.432	0.352		0.987	0.060	0.498	0.101
	N	289	289	289	289	288	288	289	289	289	289	289	289	289	289	289
Асуулт 12. Гамшигт өрсөн хүүхдийн	Pearson Correlation	0.115	0.068	.163**	0.086	.239**	.196**	.125*	.201**	.249**	0.032	0.001	1	0.052	.133*	.214**

хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломж байна уу? /Гал түймэрт өртсөн тохиолдолд гэр оронтой болгох, хүнс өгөх гэх мэт/	Sig. (2-tailed)	0.050	0.249	0.005	0.146	0.000	0.001	0.034	0.001	0.000	0.591	0.987		0.382	0.023	0.000
	N	289	289	289	289	288	288	289	289	289	289	289	289	289	289	289
Гамшгийн үед хүүхэд үүсэж болох эмэгт байдлуудын талаар дурдана уу?	Pearson Correlation	0.049	-0.038	-0.085	0.103	0.023	0.057	0.033	-0.021	-0.003	0.020	0.111	0.052	1	-0.021	0.028
	Sig. (2-tailed)	0.404	0.525	0.150	0.079	0.697	0.334	0.579	0.728	0.962	0.737	0.060	0.382		0.720	0.640
	N	289	289	289	289	288	288	289	289	289	289	289	289	289	289	289
Та гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар хүүхэд мэдээлэл, зөвлөгөө өгдөг үү?	Pearson Correlation	-.132*	-.133*	.220**	.175**	.204**	.179**	.196**	.307**	.262**	-0.041	-0.040	.133*	-0.021	1	.435**
	Sig. (2-tailed)	0.025	0.023	0.000	0.003	0.000	0.002	0.001	0.000	0.000	0.488	0.498	0.023	0.720		0.000
	N	289	289	289	289	288	288	289	289	289	289	289	289	289	289	289
Гамшгийн үед хүүхэд хамгааллын талаар мэдээлэл, зөвлөгөө авдаг уу?	Pearson Correlation	-.025	-.066	.282**	.157**	.230**	.171**	.177**	.372**	.250**	-0.017	-0.097	.214**	0.028	.435**	1
	Sig. (2-tailed)	0.674	0.265	0.000	0.007	0.000	0.004	0.003	0.000	0.000	0.767	0.101	0.000	0.640	0.000	
	N	289	289	289	289	288	288	289	289	289	289	289	289	289	289	289

ХАВСРАЛТ 2.

Таны хүйс:					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	эр	80	27.7	27.7	27.7
	эм	209	72.3	72.3	100.0
	Total	289	100.0	100.0	

Таны нас					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	18-25 нас	28	9.7	9.7	9.7
	26-35 нас	140	48.4	48.4	58.1
	36-45 нас	81	28.0	28.0	86.2
	46-55 нас	36	12.5	12.5	98.6
	56-аас дээш нас	4	1.4	1.4	100.0
	Total	289	100.0	100.0	

Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаар таны ойлголт хангалттай байна уу?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	тийм	138	47.8	47.8	47.8
	үгүй	151	52.2	52.2	100.0
	Total	289	100.0	100.0	

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээллийг хүүхдэд хэрхэн өгч байна вэ					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	сургалтын хөтөлбөрт тусгагдсан	47	16.3	16.3	16.3
	аюулгүй амьдрахуй үүднээс заадаг	170	58.8	58.8	75.1
	заадаггүй	49	17.0	17.0	92.0
	бусад	23	8.0	8.0	100.0
	Total	289	100.0	100.0	

Гамшгийн үеийн хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдсэн гэдэгт итгэж байна уу?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	тийм	78	27.0	27.1	27.1
	үгүй	174	60.2	60.4	87.5
	бусад	36	12.5	12.5	100.0
	Total	288	99.7	100.0	
Missing	System	1	0.3		
Total		289	100.0		

Хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн зохицуулалт хангалттай гэж бодож байна уу?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	тийм	84	29.1	29.2	29.2
	үгүй	167	57.8	58.0	87.2
	бусад	37	12.8	12.8	100.0
	Total	288	99.7	100.0	
Missing	System	1	0.3		
Total		289	100.0		

Хүүхдийг гамшгаас хамгаалах талаар сургалт, мэдлэг, мэдээлэл хангалттай авдаг уу?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	тийм	83	28.7	28.7	28.7
	үгүй	167	57.8	57.8	86.5
	бусад	39	13.5	13.5	100.0
	Total	289	100.0	100.0	

Гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө хамгаалах талаар сургалт ордог уу?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	тийм	109	37.7	37.7	37.7
	үгүй	139	48.1	48.1	85.8
	бусад	41	14.2	14.2	100.0
	Total	289	100.0	100.0	

Гамшиг болоход хүүхэд өөрийгөө аврах чадвар эзэмшсэн гэж Та бодож байна уу?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	тийм	61	21.1	21.1	21.1

	үгүй	200	69.2	69.2	90.3
	бусад	28	9.7	9.7	100.0
	Total	289	100.0	100.0	

Гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэгийг хүүхдэд хэрхэн хүргэвэл үр дүнтэй вэ?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	хичээл сургалтын төлөвлөгөөнд тусгаж онолын байдлаар	107	37.0	37.0	37.0
	дадлага сургуулиар	163	56.4	56.4	93.4
	цахим хуудас ашиглаж	19	6.6	6.6	100.0
	Total	289	100.0	100.0	

Гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө аврах үр чадварыг хэн эзэмшүүлэх вэ?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	боловсролын байгууллага	124	42.9	42.9	42.9
	гэр бүлийн гишүүд	74	25.6	25.6	68.5
	онцгой байдлын байгууллага	91	31.5	31.5	100.0
	Total	289	100.0	100.0	


Гамшигт өртсөн хүүхдийн хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломж байна уу? /Гал түймэрт өртсөн тохиолдолд гэр оронтой болгох, хүнс өгөх гэх мэт /					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	тийм	172	59.5	59.5	59.5
	үгүй	66	22.8	22.8	82.4
	бусад	51	17.6	17.6	100.0
	Total	289	100.0	100.0	

Гамшгийн үед хүүхдэд үүсэж болох эмзэг байдлуудын талаар дурдана уу?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	сэтгэл гутрал	108	37.4	37.4	37.4


	зан төлвийн доголдол	11	3.8	3.8	41.2
	гэмтэл	108	37.4	37.4	78.5
	өвчин	13	4.5	4.5	83.0
	хүчирхийлэл	3	1.0	1.0	84.1
	сургууль хоцрох	10	3.5	3.5	87.5
	нийгмийн харилцаанд оролцохгүй болох	36	12.5	12.5	100.0
	Total	289	100.0	100.0	

Та гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар хүүхдэд мэдээлэл, зөвлөгөө өгдөг үү?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	тийм	179	61.9	61.9	61.9
	үгүй	78	27.0	27.0	88.9
	бусад	32	11.1	11.1	100.0
	Total	289	100.0	100.0	


Гамшгийн үед хүүхэд хамгааллын талаар мэдээлэл, зөвлөгөө авдаг уу?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	тийм	139	48.1	48.1	48.1
	үгүй	113	39.1	39.1	87.2
	бусад	37	12.8	12.8	100.0
	Total	289	100.0	100.0	




Зураг 1. Судалгаанд оролцогчдын хүйсийн ангилал




Зураг 2. Судалгаанд оролцогчдын насны ангилал




Зураг 3. Судалгаанд оролцогчдын гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаар таны ойлголт хангалттай байдаг уу




Зураг 4. Судалгаанд оролцогчдын гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээллийг хүүхдэд хэрхэн өгч байна вэ




Зураг 5. Судалгаанд оролцогчдын гамшгийн үеийн хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдсэн гэдэгт итгэж байна уу




Зураг 6. Судалгаанд оролцогчдын хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн зохицуулалт хагалттай гэж бодож байна уу




Зургаг 7. Судалгаанд оролцогчдын хүүхдийг гамшгаас хамгаалах талаар сургалт, мэдлэг, мэдээлэл хангалттай авдаг уу




Зургаг 8. Судалгаанд оролцогчдын гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө хамгаалах талаар сургалт ордог уу




Зураг 9. Судалгаанд оролцогчдын гамшиг болоход хүүхэд өөрийгөө аврах чадвар эзэмшсэн гэж бодож байна уу




Зураг 10. Гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэгийг хүүхдэд хэрхэн хүргэвэл үр дүнтэй вэ




Зураг 11. Гамшгийн аюулаас хүүхэд өөрийгөө аврах ур чадварыг хэн эзэмшүүлэх вэ




Зураг 12. Гамшигт өртсөн хүүхдийн хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх боломж



Зураг 13. Гамшгийн үед хүүхдэд үүсэж болох эмзэг байдал



Зураг 14. Та гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар хүүхдэд мэдээлэл, зөвлөгөө өгдөг эсэх



Зураг 15. Гамшгийн үед хүүхэд хамгааллын талаар мэдээлэл, зөвлөгөө авдаг уу